

ТЕХНИКИЙН ТАЙЛАН №1

ТАНДАН СУДАЛГААНЫ ТАЙЛАН

СААДГҮЙ БАЙДАЛ, ХҮРТЭЭМЖИЙН ТУХАЙ АНХДАГЧ ХУУЛИЙН ТӨСӨЛ БОЛОВСРУУЛАХ ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГА

Зөвлөх үйлчилгээний нэр: С24: “Саадгүй байдал, хүртээмжийн тухай” анхдагч хуулийн хэрэгцээ шаардлага, хуулийн тандалтын болон үр нөлөөний судалгаа гүйцэтгүүлэх

Гэрээний дугаар: 03/239

Нийлүүлсэн огноо: 2025 оны 9 дүгээр сарын 2

Улаанбаатар хот
2025 оны 6 дугаар сар

ТАНДАН СУДАЛГААНЫ ТАЙЛАН

СААДГҮЙ БАЙДАЛ, ХҮРТЭЭМЖИЙН ТУХАЙ АНХДАГЧ ХУУЛЬ БОЛОВСРУУЛАХ ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГЫГ ТОДОРХОЙЛОХ ТАНДАН СУДАЛГАА



Саадгүй байдал, хүртээмжийн тухай анхдагч хууль боловсруулах хэрэгцээ, шаардлагыг тодорхойлох тандан судалгааг АХБ-ны L3605/G9191:MON-Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн оролцоог хангах, үйлчилгээг сайжруулах төсөл"-ийн С24 хүрээнд зөвлөх үйлчилгээний хүрээнд гүйцэтгэв.

СААДГҮЙ БАЙДАЛ, ХҮРТЭЭМЖИЙН ТУХАЙ АНХДАГЧ ХУУЛЬ БОЛОВСРУУЛАХ ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГЫГ ТОДОРХОЙЛОХ ТАНДАН СУДАЛГААНЫ ХУРААНГУЙ

Саадгүй байдал, хүртээмжийн тухай анхдагч хуулийн төслийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тодорхойлох тандан судалгааны хүрээнд хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг “Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлал”-ын дагуу гүйцэтгэж үр дүнг дараах байдлаар дүгнэв.

Дэлхий нийтээр хүний жам ёсны болон хууль ёсны эрх, эрх чөлөөг бүрэн эдлүүлэх, хүн нас, хүйс, эдийн засгийн нөхцөл, бүр болон түр хугацааны хөгжлийн бэрхшээлтэй эсэхээс үл хамаарч бусдын нэгэн адил эрх тэгш байх боломжийг бүрдүүлэх зорилгоор олон улсын хүний эрхийн гэрээ, конвенцод нэгдэн орсон орнууддаа зорилтот бүлгийн, ялангуяа ХБХ-ий эрхийг хангахад онцгойлон анхаарч төрийн үйлчилгээ болон нийтэд үйлчилгээ үзүүлж буй барилга байгууламж, дэд бүтэц, техник тоног төхөөрөмж, харилцаа холбоо, мэдээллийн хэрэгсэл, технологийн дэвшилтэт бүтээгдэхүүн, үйлжилгээг олон улсын хэм хэмжээнд нийцүүлэн саадгүй, хүртээмжтэй байлгах, бодитоор хэрэгжүүлэх тал дээр хүчин чармайлт гаргаж, үндэсний хөгжлийн бодлого, стратегидаа тусгахыг уриалж, тодорхой шаардлага тавьж байна.

Монгол Улсын тухайд НҮБ-аас баталсан Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн конвенц, Хүний эрхийн түгээмэл тунхаглал, Улс төр, нийгэм, соёлын эрхийн факт, “Тогтвортой хөгжлийн зорилго 2016-2030” зэрэг 10 гаруй гэрээ, конвенц, тэдгээрийн нэмэлт протокол зэрэг бодлогын баримт бичигт нэгдэн орсон улсын хувьд эдгээр хүний эрхийн олон улсын баримт бичиг тусгасан эрхүүдийг өөрийн нийгэм, эдийн засгийн хэмжээнд тохируулан хууль, бодлогын түвшинд хангахаар стандарт тогтоох, олон нийтэд мэдээлэх, хяналт тавих эрх зүйн орчныг бүрдүүлэх, хэрэгжилтийг хангуулах үүрэгтэй.

Энэ үүргээ хэрэгжүүлэх чиглэлээр хууль тогтоомжоо боловсронгуй болгож 100 орчим хуульд саадгүй, хүртээмжтэй байдлыг хангах зохицуулалт тусгаж, эдгээрт холбогдох 20 гаруй стандарт, дүрэм, журмыг боловсруулсан ч хэрэгжилт хангалтгүй байгаа нь салбар хоорондын үйл ажиллагааны болон эрх зүйн орчны уялдаагүй байдал, хяналт, хариуцлагын тогтолцоо хангалтгүй байгаатай холбоотой байна. Үүний илрэл бол ХБХ-д саадгүй, хүртээмжтэй байх асуудлыг “Алсын хараа-2050”, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр зэрэг Монгол Улсын урт, дунд хугацааны бодлогын баримт бичгүүдэд тусгадаг, гэхдээ үндсэндээ Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуульд уг асуудлыг харьцангуй тодорхой заасан байгаа бол бусад хууль тогтоомжид ерөнхий байдлаар 2-4 заалтын хүрээнд тунхаглалын шинжтэй тусгажээ.

ХБХ-д саадгүй, хүртээмжтэй байдлыг хангах хууль эрх зүйн орчныг үнэлж үзэхэд ХБХ бусдын адил бие даан амьдрах, нийгмийн бүхий л салбарт эрх тэгш оролцох боломжтой байх, мөн барилга байгууламж, тээвэр, мэдээлэл харилцаа холбоо, үйлчилгээ саадгүй, хүртээмжтэй байх асуудалд холбогдох зохицуулалтууд хэт ерөнхий, тодруулбал, санхүүжилтийн эх үүсвэр, хариуцан хэрэгжүүлэх этгээдийг тодорхой тусгаагүй, саадгүй байдал, хүртээмжийг олон нийтэд ойлгуулах, мэдлэг, мэдээлэл түгээх, хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлагын асуудлыг орхигдуулсан, зөвлөмж, стандартууд нь заавал мөрдөх шинжгүй буюу сонгож хэрэглэх боломжтой, мөн бусад хууль тогтоомжтой хэрхэн уялдаж, харилцан хамааралтай ажилладаг нь ойлгомжгүй, нэг салбарын мэргэжилтэн нөгөө салбарын хууль тогтоомжийн

талаар мэдлэг сул, өөрийн ажиллаж буй салбарынхаа хууль тогтоомжийн талаар бүрэн мэдээлэлгүй, хяналт хэрэгжүүлэх механизм тодорхойгүй байх, олон байгууллага өөрийн эрх хэмжээнд хяналт хэрэгжүүлдгээс үүдэн хариуцлагын хэмжээ бага, түүнээс зайлсхийх арга хэлбэр олон гээд саадгүй, хүртээмжтэй орчныг бий болгоход чигдэсэн хуулийг хэрэгжүүлэхэд саад болдог шалтгаан олон байгаа нь асуудалд цогцоор нь хандаж чадахгүй, хэрэгжихгүй, үр дүнгүй байхад нөлөөлж байна.

ХБХ-д ээлгүй, хүртээмжгүй хот төлөвлөлт, барилга байгууламж, дэд бүтцээс гадна мэдээлэл, үйлчилгээ, техник, технологи, хүний нөөцийн хүртээмжгүй байдал ХБХ-ийг нийгмийн харилцаанд аливаа саадгүйгээр оролцох боломжийг хязгаарлаж, ялгаварлан гадуурхалтыг нэмэгдүүлэх суурь шалтгаануудын нэг болж байна. Иймээс цаашид ХБХ төдийгүй бусад хүний нийгмийн харилцаанд оролцох боломжийг хязгаарлаж хөгжлийн бэрхшээлтэй болгож буй орчны саад, хүртээмжгүй байдлыг өөрчлөхийн тулд бүх хүнд ээлтэй бүтээн байгуулалт хийх, үйл ажиллагаа явуулах ухамсрыг төлөвшүүлэхүйц эрх зүйн орчныг бүрдүүлэх шаардлагатай юм. Үүний тулд юуны өмнө ХБХ нийгмийн харилцаанд эрх тэгш оролцох эрхийг ноцтойгоор зөрчихөд хүргэж буй орчны саад, хүртээмжгүй байдлыг үүсгэж буй хот төлөвлөлт, газар олголт, архитектурын шийдэл, барилгын зөвшөөрөл зэрэг барилга байгууламж, дэд бүтцэд тавигдах шаардлага, түүнд тавих хяналт, хариуцлагыг шинэчлэн тогтоох, сайжруулах шаардлага тулгамдаж байна. Тухайлбал, өнөөдөр хот байгуулалт, барилгын тухай хууль тогтоомжийг зөрсөн этгээдэд оногдуулж буй 100 мянгаас 10 сая төгрөг хүртэлх төгрөгийн торгуулийн арга хэмжээ хэдэн зуун сая, тэрбумын хөрөнгө оруулагчийн хувьд үр дүнгүй, хууль биелүүлэх сэдэл, хөшүүрэг болохгүй байна.

Тандан судалгаагаар хүн амын нягтаршил, эдийн засаг, хөрөнгө оруулалтын төв болсон Улаанбаатар хотод үүссэн дэд бүтэц, төрийн үйлчилгээ, олон нийтийн үзвэр үйлчилгээний хүртээмжийн нөхцөл байдал орон нутагт, бусад төв суурин газарт ч мөн адил үүссэн, цаашид улам даамжрах эрсдэлтэй байгаа тул барилга байгууламж, дэд бүтцийн саадгүй байдал, хүртээмжийг нэмэгдүүлэхэд төр үүрэг, оролцоо, идэвхээгээ нэмэгдүүлэх нь чухал болох нь харагдаж байна.

Өөрөөр хэлбэл, төр өөрөө Үндсэн хуулиар иргэдийнхээ өмнө хүлээсэн үүргийнхээ хүрээнд төрийн байгууллагуудын барилга байгууламжийн саадгүй байдал, хүртээмжийг сайжруулах, хуулийн шаардлага хангах, мөн улс, орон нутгийн төсвийг үргүй зарцуулахаас сэргийлж төсвийн хөрөнгөөр хэрэгжих төсөл, хөтөлбөр, арга хэмжээ саадгүй, хүртээмжтэй байх анхдагч шалгуурыг тавьж хэрэгжилтийг хангуулах нь цаашид эл асуудлыг шийдвэрлэх алхам болох юм.

Ялангуяа сүүлийн жилүүдэд нийслэл, орон нутгийн зам, талбайн өргөтгөл, шинэчлэлийн ажилд ихээхэн хөрөнгө мөнгө зарцуулж байгаа боловч эдгээр төсөл, хөтөлбөрүүд нь ХБХ-ий эрхийг хангаагүй саадгүй байдал, хүртээмжийн наад захын шаардлага хангаагүй, чанаргүй гүйцэтгэлтэй байгаа, мөн шаардлага хангаагүй барилга, байгууламж, дэд бүтэц, зам талбай бий болгоход оруулсан хөрөнгө оруулалтын хэмжээ тэдгээрийг саадгүй, хүртээмжтэй болгоход чиглэсэн засвар, үйлчилгээнд зарцуулах хөрөнгө оруулалтын хэмжээгээр өсөж улсын төсөвт дарамт болж байгаагаас харж болно.

ХБХ-д хүртээмжтэй үйлчилгээ үзүүлэхэд иргэдийн дунд хөгжлийн бэрхшээлийн хандлага төлөвшөөгүй, шаардлагатай хүний нөөц дутагдалтай, санхүүжилт хангалтгүй, шаардлагатай журам, аргачлал зэрэг хуулийн хэрэгжилтийг бүрэн хангуулахад чиглэсэн эрх зүйн актуудыг боловсруулах батлуулах ажил удаашралтай байдаг зэрэг хэд хэдэн шалтгаан

нөлөөлж байна. Тухайлбал, нийслэлийн нийтийн тээврийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх ажил 10 жил үргэлжилж байгаа боловч 10 хувь нь л ХБХнд хүртээмжтэй, автобусны зогсоол, нийтийн үйлчилгээний байгууллагуудын зогсоол хүртээмжгүй, явган хүний гарцны дуут дохио хангалтгүй, ногоон байгууламжийн төлөвлөлт, арчилгаа, нийтийн эзэмшлийн талбайг зориулалтын бусаар ашиглах, зам талбайг дур мэдэн хаах, саад байршуулах асуудлаа шийдвэрлэж чадахгүй байхаас гадна такси, төмөр замын, хот хоорондын үйлчилгээ, агаарын тээврийн үйлчилгээ зэрэг уламжлалт тээврийн хэрэгслээс гадна шинэ тутам нэвтрүүлэхээр зорьж буй дүүжин тээвэр, трамвай зэргийг ХБХ-д хүртээмжтэй болгох тухай зохицуулалт байхгүй байна.

Хүртээмжийн асуудал үндсэндээ уламжлалт буюу эрүүл мэнд, боловсрол зэрэг төрийн үйлчилгээ, харилцаа холбоо, мэдээллийн технологийн үйлчилгээ, болон шинэ тутам зохицуулалт шаардагдах програм хангамж, компьютер, гар утас, цахим ном уншигч төхөөрөмж, банкны автомат, карт уншигч төхөөрөмж, вэбсайт зэрэг бүтээгдэхүүний хүртээмж гэж ангилалдахаар байна. ХБХ-д нэн шаардлагатай үйлчилгээ нь ихэвчлэн төрөөс үзүүлэх үйлчилгээ байдаг тул саадгүй байдал, хүртээмжийг нэмэгдүүлэхэд төр өөрөө манлайлах, мөн төрийн зарим чин үүргийг хэрэгжүүлэх, төрөөс дэмжлэг, татаас авах байгууллагуудад тавигдах шаардлагад саадгүй байдал, хүртээмжийн шалгуур тогтоох нь хуулийн хэрэгжилтийг хангах хөшүүрэг болох магадлалтай юм.

Хүртээмжтэй байдал бол ХБХ-ий оролцоог нэмэгдүүлэх “сонголт биш эрх” бөгөөд оролцоо, тэгш эрхийг хангаснаар ХБХ-ий нэр төр, нийгэмд эзлэх байр суурийг бэхжүүлэх, шийдвэр гаргах эрх чөлөөг бататгах асуудал болохын хувьд хүний ялгаатай байдлаас үл хамаарч төрийн болон хувийн хэвшлийн аж ахуйн нэгж байгууллагаас үзүүлж буй аливаа үйлчилгээ хүн бүрт хүртээмжтэй байх нь хүний эрхийг хангах суурь үзүүлэлт гэж үзэн НҮБ, Европын холбоо зэрэг олон улсад хэм хэмжээ тогтоогчид жишиг эрх зүйн зохицуулалтыг бий болгосон бол Япон, Канад зэрэг орнууд олон салангид хуульд агуулагдаж буй саадгүй байдал, хүртээмжийн зохицуулалтуудыг нэгтгэн бие даасан хүртээмжийн хууль батлах замаар гишүүн орнууд, мужуудын хэмжээнд хүний эрхийг хангах нөхцөлийг бүрдүүлж буй сайн туршлага байна.

Дээрхтэй холбоотой судалгааг тайлангийн өмнөх хэсгүүдэд тусгасан ба аргачлалын дагуу эрх ашиг нь хөндөгдөх этгээдүүдийг тодорхойлсон.

Мөн тус хэрэгцээ, шаардлагад үндэслэн хувилбар буюу зохицуулах аргуудад дүгнэлт хийн тэдгээрээс хоёр хувилбарыг сонгож хооронд нь харьцуулсан болно.

- Тэг хувилбарыг “Саадгүй байдал, хүртээмжтэй үйлчилгээ үзүүлэх талаар одоогийн зохицуулалтын хувилбарыг хэвээр үлдээх буюу шинэ зохицуулалт хийхээс татгалзах замаар асуудлыг шийдвэрлэх” гэж,
- хувилбар 1-ээр “Саадгүй байдал, хүртээмжтэй үйлчилгээ үзүүлэх эрх зүйн орчныг шинэчлэх буюу боловсронгуй болгох замаар асуудлыг шийдвэрлэх” гэж тус тус тодорхойлсон.

Улмаар тус хоёр хувилбаруудыг зорилгод хүрэх байдал, хүний эрх, эдийн засаг, нийгэм, байгаль орчинд үзүүлэх үр нөлөө, зардал, үр өгөөжийн харьцаа, хууль тогтоомжтой нийцэж байгаа эсэх гэсэн шалгуур үзүүлэлтээр эерэг үр дүн болон сөрөг үр дагаврыг нэг бүрчлэн, нарийвчлан тодорхойлсны үр дүнд зорилгод хүрэх байдал, шалгуур үзүүлэлт, хүний эрх, эдийн засаг, нийгэмд үзүүлэх үр нөлөө зардал, үр өгөөжийн харьцаа шалгуур үзүүлэлт, хууль

тогтоомжтой нийцэж байгаа эсэх шалгуур үзүүлэлт, хүний эрхэд үзүүлэх үр нөлөө гэх шалгуур үзүүлэлтийн хувьд зохицуулалтын хувилбар 1 нь хувилбар 0-ээс эерэг үр дүнг үзүүлж байна.

Мөн зохицуулалтын хувилбар 1-ий сонгосноор Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хууль, Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээнд нийцсэн, хэрэгжилтийг хангахад эерэг нөлөөтэй байна. Дүгнэвэл, хувилбар 1 буюу “Саадгүй байдал, хүртээмжтэй үйлчилгээ үзүүлэх эрх зүйн орчныг шинэчлэх буюу боловсронгуй болгох замаар асуудлыг шийдвэрлэх” нь хэрэгцээ, шаардлагад илүү нийцтэй, хүний эрхийг хангах чиглэлээр төрийн үүрэг, оролцоо хариуцлагыг бэхжүүлэх асуудлыг шийдвэрлэх арга зам болж чадахаар байна.

Судалгааны дүнгээс харахад саадгүй байдал, хүртээмжтэй үйлчилгээнд холбогдох эрх зүйн орчинг боловсронгуй болгохдоо Монгол Улсад өнөөдрийг хүртэл бат бөх оршсон “хүний эрхээс илүү эд хөрөнгө, нийтийн эрх ашгаас илүү хувийн ашиг сонирхол” гэх хандлагыг өөрчилж хүн бүр нийгмийн харилцаанд эрх тэгш оролцох, сурч боловсрох, хөдөлмөрлөх, эрүүл мэндээ хамгаалуулах, эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхээ эдлэх, ХБХ нийгэм, эдийн засгийн хувьд бусдаас хараат бусаар бие даан амьдрах боломжийг бүрдүүлэх тогтолцоог бэхжүүлэх буюу эрх зүйн зохицуулалт хоорондын уялдаа холбоог сайжруулах, төр өөрөө үлгэрлэж хууль тогтоомжийн хэрэгжилтийг сайжруулах, төрийн бодлого, стратеги хүн төвтэй, хүний эрхэд суурилсан байх зарчмыг илүү үр дүнтэйгээр тодорхойлж хэрэгжүүлэх байдлаар шийдвэрлэх нь зүйтэй юм.

Иймээс Монгол Улсад хүн бүр, эн тэргүүнд ХБХ бусдын нэгэн адил саадгүй, хүртээмжтэй үйлчилгээ авах эрхийг баталгаажуулах зорилгоор тухайлсан хууль боловсруулах шаардлагатай эсэхийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалт, 13 дугаар зүйлд заасны дагуу Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлал”-ын дагуу гүйцэтгэсэн судалгааны дүнд үндэслэн ХБХ саадгүй, хүртээмжтэй орчин, нөхцөлөөр хангагдах эрхийг баталгаажуулж буй 100 гаруй эрх зүйн актад тусгасан зохицуулалтыг нэгдсэн бүтэц, нэгдмэл тогтолцоонд оруулах замаар саадгүй байдал, хүртээмжийн асуудлыг цогцоор нь шийдэж эрх, үүрэг, хяналт, хариуцлага, харилцан хамаарлыг тодорхойлох, шинэ тутам үүсэж буй саад бэрхшээлийг ХБХ-нд ээлтэй байдлаар шийдвэрлэх шийдэл гаргах зэрэг асуудлыг тусгасан тухайлсан хууль боловсруулахыг зөвлөж байна.

Судалгаа гүйцэтгэсэн

С24 Зөвлөх-Ж.Бариширсүрэн

АГУУЛГА

УДИРТГАЛ.....	10
НЭГ. АСУУДАЛД ДҮН ШИНЖИЛГЭЭ ХИЙХ.....	12
1.1. Эрх зүйн орчны дүн шинжилгээ.....	12
1.2. Хэрэгжилт: Орчны саадгүй байдал.....	15
1.2.1. Барилга, байгууламж, дэд бүтцийн саадгүй байдал.....	16
1.2.2. Явган хүний зам, тээврийн хэрэгслийн саадгүй байдал.....	20
1.3. Хэрэгжилт: Хүртээмжтэй үйлчилгээ.....	32
1.3.1. Үйлчилгээний хүртээмж: Мэдээллийн технологи, харилцаа холбоо.....	32
1.3.2. Бүтээгдэхүүн, үйлчилгээний хүртээмжийн тухайд.....	34
ХОЁР. АСУУДЛЫН МӨН ЧАНАР, ЦАР ХҮРЭЭ.....	37
2.1. Эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж буй нийгмийн бүлэг, иргэдийг тодорхойлох.....	38
2.2. Асуудлыг үүсгэж буй шалтгаан нөхцөл.....	42
ГУРАВ. АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭХ ЗОРИЛГЫГ ТОМЪЁОЛОХ.....	42
ДӨРӨВ. АСУУДЛЫГ ЗОХИЦУУЛАХ ХУВИЛБАРУУД, ТЭДГЭЭРИЙН ЭЭРЭГ, СӨРӨГ ТАЛЫГ ХАРЬЦУУЛСАН БАЙДАЛ.....	44
ТАВ. ЗОХИЦУУЛАЛТЫН ХУВИЛБАРУУДЫН ҮР НӨЛӨӨГ ТАНДАН СУДАЛСАН БАЙДАЛ.....	46
5.1. Хүний эрхэд үзүүлэх үр нөлөө.....	46
5.2. Эдийн засагт үзүүлэх үр нөлөө.....	48
5.3. Нийгэмд үзүүлэх үр нөлөө.....	51
5.5. Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ, бусад хууль тогтоомжид нийцсэн байдал.....	57
ЗУРГАА. ЗОХИЦУУЛАЛТЫН ХУВИЛБАРУУДЫГ ХАРЬЦУУЛЖ ДҮГНЭЛТ ХИЙХ.....	59
ДОЛОО. ОЛОН УЛСЫН БОЛОН БУСАД УЛСЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА ХИЙХ.....	61
7.1. Олон улсын гэрээ, конвенцоор хүлээсэн үүрэг.....	61
7.2. Бусад орнуудын эрх зүйн зохицуулалтын онцлог.....	62
НАЙМ. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ.....	67
ЭХ СУРВАЛЖИЙН ЖАГСААЛТ.....	71

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

ГБХНХЯ	Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам
ЗГ	Засгийн газар
НҮБ	Нэгдсэн үндэстний байгууллага
ТББ	Төрийн бус байгууллага
УИХ	Улсын Их Хурал
ХБХ	Хөгжлийн бэрхшээлтэй хүн
ХБХХЕГ	Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар
ХБХЭТХ	Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль

Хүснэгтийн жагсаалт

Хүснэгт 2. Хувилбаруудын харьцуулалт	44
Хүснэгт 3. Хүний эрхэд үзүүлэх үр нөлөө	46
Хүснэгт 4. Эдийн засагт үзүүлэх үр нөлөө	48
Хүснэгт 5. нийгэмд үзүүлэх үр нөлөө	51
Хүснэгт 6. Байгаль орчинд үзүүлэх үр нөлөө	55
Хүснэгт 7. хувилбаруудын харьцуулалт	59
Хүснэгт 8. Хүснэгт Японы хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор 10-н жилийн үйл ажиллагааны төлөвлөгөө	63

Графикийн жагсаалт

График 1. Явган хүний замын гарцын налууугийн хэвгий:	22
График 2. Хөтөч зам	24
График 3. Анхааруулах хавтан	24
График 4. Дуут дохио	25
График 5. Дуут дохио	25
График 6. Явган хүний замын өргөн стандартад нийцсэн эсэх	26
График 7. Ногоон байгууламж	27
График 8. Хүн амд эзлэх ХБХ-ий тоо, ХБХ-ий тоо 3 жилийн өмнөх дүнтэй харьцуулсан үзүүлэлт (хувиар)	39
График 9 ХБХ-ий тоо, хөгжлийн бэрхшээлээр	40
График 10 ахмад настан, хүүхдийн тоо 2022-2024 он	40

Зургийн жагсаалт

Зураг 1 Явган хүний зам	22
Зураг 2 Явган хүний зам	26
Зураг 3 Замын ногоон байгууламж	27
Зураг 4 зам дээрх саад	28

УДИРТГАЛ

Дэлхий дахинаа хүний жам ёсны болон хууль ёсны эрх, эрх чөлөөг бүрэн эдлүүлэх, хүн нас, хүйс, эдийн засгийн нөхцөл, бүр болон түр хугацааны хөгжлийн бэрхшээлтэй эсэхээс үл хамаарч бусдын нэгэн адил эрх тэгш байхад анхаарч буйн нэг илрэл бол хүн бүрт хүртээмжтэй, саадгүй орчин, нөхцөлийг бүрдүүлэх чиглэсэн бодлого төлөвлөлт, хөрөнгө оруулалт юм.

Нэгдсэн үндэсний байгууллагаас 2006 онд баталсан “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн конвенц¹ (цаашид Конвенц гэх)-ын ерөнхий зарчмуудын нэг бол хүртээмжийн тухай ойлголт (3 (f)) юм. Иймээс конвенцын 9-р зүйлд “Оролцогч улсууд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг бие даан амьдрах, амьдралын бүхий л салбарт бүрэн оролцох боломжийг олгохын тулд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг бусадтай адил тэгш эрхтэйгээр бие махбодийн орчин, тээвэр, мэдээлэл, харилцаа холбоо, тэр дундаа мэдээлэл, харилцаа холбооны технологи, систем, хот, хөдөөгийн аль алинд нь олон нийтэд нээлттэй буюу үзүүлж буй бусад байгууламж, үйлчилгээнд нэвтрэх боломжийг хангах зохих арга хэмжээг авна.” гэж заасан ба энэ нь а) сургууль, орон сууц, эмнэлгийн байгууллага, ажлын байр зэрэг барилга, зам, тээвэр болон бусад дотор болон гадна байгууламж; б) мэдээлэл, харилцаа холбоо болон бусад үйлчилгээ, түүний дотор цахим үйлчилгээ, яаралтай тусламж нь ХБХ-ий нийгмийн харилцаан дахь тэгш оролцоог хангасан байдлаар илэрхийлэгдэх юм.

Дээрх асуудлыг 2013 онд зохион байгуулагдсан НҮБ-ын Хөгжлийн бэрхшээлтэй байдал, хөгжлийн асуудлаарх өндөр түвшний уулзалтаар² “Хөндлөнгөөс шалтгаалсан хөгжлийн асуудал” гэж үзээд “хүртээмжтэй байдал гэдэг нь ерөнхийдөө аливаа бүтээгдэхүүн, төхөөрөмж, үйлчилгээ, орчинд хандах, ашиг тусыг нь хүртэх чадварыг ойлгох ба хэрэв бүтээгдэхүүн, үйлчилгээ, орчин нь хүртээмжтэй байвал хөгжлийн бэрхшээлтэй бүх хүмүүс ямар ч саад бэрхшээлгүйгээр хандах боломжтой тул ХБХ-ийг хөгжлийн бүхий л салбарт хамруулах хүртээмжийг хангах нь чухал болохыг онцолсон. Мөн оролцогч талууд хөгжлийн бэрхшээлийн талаарх үндэсний хөгжлийн стратеги, хүчин чармайлтыг илүү амбицтай хэрэгжүүлэх ёстой ба энэ хүчин чармайлт нь хөгжлийн бэрхшээл, хөгжлийн талаарх олон улсын хэм хэмжээний тогтолцоог бүрэн хэрэгжүүлэх, хөгжлийн бүхий л бодлогод хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн хэрэгцээг харгалзан үзэх ёстой” болохыг онцолсон байдаг.

Саадгүй байдал, хүртээмжийн асуудал өнөөдөр ХБХ-ийн эрх гэхээс илүүтэй хүн бүрийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах зэрэг эрхийн баталгаа болж хүрээгээ тэлж байна.

Учир нь Конвенцын дагуу улс орнууд өөрийн нийгэм, эдийн засгийн хэмжээнд тохируулан хууль, бодлогын түвшинд хүртээмжийг хангах стандарт тогтоох, олон нийтэд мэдээлэх, хяналт тавих замаар а) олон нийтэд нээлттэй барилга байгууламж, үйлчилгээний хүртээмжтэй байдлын талаарх наад захын стандарт, удирдамжийг боловсруулах, сурталчлах, хэрэгжилтэд хяналт тавих; б) олон нийтэд нээлттэй байгууламж, үйлчилгээг санал болгож буй хувийн хэвшлийн байгууллагууд ХБХ-д хүртээмжтэй байх бүх талыг харгалзан үзэх; в) ХБХ-д тулгарч буй хүртээмжтэй байдлын асуудлаар оролцогч талуудад сургалт явуулах; г) барилга байгууламжид нийтийн хүртээл болохуйц газар брайл үсгээр, уншихад хялбар хэлбэрээр

¹Convention on the Rights of Persons with Disabilities (CRPD). Эх сурвалж:

<https://social.desa.un.org/issues/disability/crpd/convention-on-the-rights-of-persons-with-disabilities-crpd>

²High-level Meeting on Disability and Development. Monday, September 23, 2013. Эх сурвалж:

<https://www.un.org/en/desa/high-level-meeting-disability-and-development>

тэмдэг тэмдэглэгээ байрлуулах; д) олон нийтэд нээлттэй барилга байгууламжид нэвтрэх боломжийг хөнгөвчлөх зорилгоор хөтөч, уншигч, дохионы хэлний мэргэжлийн орчуулагч зэрэг тусламж, дэмжэг үзүүлэх угтах үйлчилгээтэй байх; е) ХБХ мэдээлэл олж авах боломжийг хангахын тулд бусад зохих хэлбэрийн тусламж, дэмжлэгийг дэмжих; ж) ХБХ мэдээлэл, харилцаа холбооны шинэ технологи, систем, тэр дундаа интернет ашиглах боломжийг дэмжих; ж) хүртээмжтэй мэдээлэл, харилцаа холбооны технологи, системийг боловсруулах, хөгжүүлэх, үйлдвэрлэх, түгээх ажлыг эрт үе шатанд дэмжих, ингэснээр эдгээр технологи, системийг хамгийн бага зардлаар хүртээмжтэй болгох замаар саадгүй, байдал хүртээмжийг бий болгоход анхаарах шаардлагатайг тунхагласан.

Олон улсад ХБХ бусдын адил бие даан амьдрах, нийгмийн бүхий л салбарт эрх тэгш оролцох боломжтой байх, мөн барилга байгууламж, тээвэр, мэдээлэл харилцаа холбоо, үйлчилгээ саадгүй (barrier-free environment), хүртээмжтэй (accessibility) байх асуудлыг зөвхөн ХБХ-ий эрхийг хангахад чиглэгдсэн арга хэмжээ гэдэг ойлголтоос бүх хүний эрхийн асуудал гэж үзэн барилга байгууламж, дэд бүтцийг хүүхэд, хөгшид, түр хугацаагаар хөгжлийн бэрхшээлтэй болсон гээд хүн бүрт саадгүй болгох, бүхий л төрлийн үйлчилгээг хүн бүрт хүртээмжтэй байдлаар хүргэхэд анхаарч буй энэ үед манай улс Саадгүй байдал, хүртээмжийн тухай анхдагч хууль боловсруулах хэрэгцээ, шаардлагаа тодорхойлж байгаа нь чухал ач холбогдолтой байна.

Иймээс Монгол Улсад хүн бүр, эн тэргүүнд ХБХ бусдын нэгэн адил саадгүй, хүртээмжтэй үйлчилгээ авах эрхийг баталгаажуулах зорилгоор тухайлсан хууль боловсруулах шаардлагатай эсэхийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалт, 13 дугаар зүйлд заасны дагуу Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлал” (цаашид Аргачлал гэх)-д заасан 1/тандан судлах, 2/асуудалд дүн шинжилгээ хийх, 3/ асуудлыг шийдвэрлэх зорилгыг томъёолох, 4/хувилбарыг тогтоох, 5/зөвлөмж боловсруулах үе шаттайгаар тодорхойлохыг зорьлоо.

НЭГ. АСУУДАЛД ДҮН ШИНЖИЛГЭЭ ХИЙХ

Хөгжлийн бэрхшээлтэй хүн нийгмийн харилцаанд бусдын нэгэн адил эрх тэгш оролцох эрхийг хангах, орчин, нөхцөлийг бүрдүүлэхэд шаардлагатай эрх зүйн орчныг тухайлсан хууль тогтоомжоор зохицуулах хэрэгцээ, шаардлагыг тодорхойлох зорилготой энэхүү судалгааны “Асуудалд дүн шинжилгээ хийх” үе шатанд Монгол Улсад саадгүй байдал, хүртээмжийн асуудал эрх зүйн орчны хувьд хэрхэн зохицуулагдаж байгаа, мөн хууль тогтоомжийн хэрэгжилт буюу бодит нөхцөл ямар байдалтай байгаа гэсэн үндсэн 2 хүрээнд судалж үзнэ.

1.1. Эрх зүйн орчны дүн шинжилгээ

Монгол Улсын Үндсэн хуулийн³ Арван дөрөвдүгээр зүйлийн 2-т “Хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно.” гэж, Арван зургадугаар зүйлийн 2/-т эрүүл, аюулгүй орчинд амьдрах, ... эрхтэй; 4/ажил мэргэжлээ чөлөөтэй сонгох, хөдөлмөрийн аятай нөхцөлөөр хангуулах, ... эрхтэй; 6/эрүүл мэндээ хамгаалуулах, эмнэлгийн тусламж авах эрхтэй; 7/сурч боловсрох эрхтэй гэж Монгол Улсын иргэний баталгаатай эдлэх үндсэн эрх, эрх чөлөөг дурдаж, Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна.” хэмээн баталгаажуулсан.

НҮБ-ын “Тогтвортой хөгжлийн зорилго 2016-2030” буюу дэлхийн хөгжлийн зорилтуудын 10 дахь “Тэгш бус байдлыг бууруулах”⁴ зорилтын хүрээнд Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам (цаашид ГБХНХЯ гэх) “2030 он гэхэд нас, хүйс, хөгжлийн бэрхшээл, арьс өнгө, яс үндэс, удам угсаа, шашин шүтлэг, эдийн засгийн болон бусад байр сууриасаа үл хамааран хүн бүрийг нийгэм, эдийн засаг, улс төрийн амьдралд эрх тэгш оролцох боломжоор хангаж, дэмжих”⁵, мөн “Ялгаварлан гадуурхсан хууль журам, бодлого, зан заншлыг халж, энэ талын хууль тогтоомж, бодлого, үйл ажиллагааг хөхүүлэн дэмжих замаар тэгш боломж бололцоог бүрдүүлж, тэгш бус байдлыг бууруулах”⁶, “Санхүү, цалин, нийгэм хамгааллын бодлогыг батлан хэрэгжүүлж, тэгш байдлыг аажмаар хангах”⁷ үүргийг хүлээсэн. “Тогтвортой хөгжлийн зорилго 2016-2030”-ын 10 дахь зорилтоос гадна Ядуурлыг бууруулах 1 дэх зорилгын 1.3 дахь зорилт⁸, Чанартай боловсролыг дэмжих, 4 дэх зорилтын 4.5 дахь зорилго⁹, Зохистой

³ Монгол Улсын Үндсэн хууль. Эх сурвалж: <https://legalinfo.mn/mn/detail?lawId=367>

⁴ Тогтвортой хөгжлийн зорилго

⁵ Мөн тэнд Зорилт 10.2

⁶ Мөн тэнд Зорилт 10.3

⁷ Мөн тэнд Зорилт 10.4

⁸ Үндэсний онцлогт тохирсон нийгэм хамгааллын тогтолцоо, бүх хүнд зориулсан нийгэм хамгааллын арга хэмжээ, түүний дотор нийгэм хамгааллын үндсэн үйлчилгээг нэвтрүүлж, түүнд ядуу, эмзэг бүлгийн дийлэнх хэсгийг 2030 он гэхэд хамруулах

⁹ 2030 он гэхэд боловсролын байгууллагад суралцагсдын жендерийн зохистой харьцааг хангаж, эмзэг бүлэг, түүний дотор хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс, нутгийн уугуул хүмүүс, эмзэг бүлгийн хүүхдүүдэд бүх шатны боловсрол, мэргэжлийн сургалтыг тэгш авах боломжийг бүрдүүлэх

хөдөлмөр ба эдийн засгийн өсөлтийг дэмжих 8 дахь зорилгын 8.5 дахь зорилтын¹⁰ хүрээнд ХБХ-ий боловсрол, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх шаардлага бий болсон.

ХБХ-ий эрхийг хангахад чиглэсэн суурь хууль болох Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай¹¹ хууль (цаашид ХБХЭтХ гэх)-ийн 27 зүйл, заалтад хүртээмжтэй байдлын талаар, 5 зүйл, заалтад саадгүй байдлыг хангах замаар ХБХ боловсрол, эрүүл мэнд, нийгэм, эдийн засгийн үйлчилгээг эрх тэгш авах нөхцөлийг бүрдүүлэх талаар тусгажээ.

Монгол Улсын Их Хурал (цаашид УИХ гэх)-ын 2020 оны 52 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтаар баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны бодлогын баримт бичгийн “Хүний хөгжил” хэмээх Хоёрдугаар бүлгийн 2.3.3-т “...хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хамгаалах, нийгмийн суурь үйлчилгээг хүргэх, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих талаар баримтлах бодлого, хөтөлбөр хэрэгжүүлж, салбар дундын зохицуулалтыг сайжруулна.”, 2.6.14-д “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн оролцоог дэмжихэд чиглэсэн шинэ төрлийн үйлчилгээг нэвтрүүлнэ.”, “Амар тайван, аюулгүй нийгэм” хэмээх Долоодугаар бүлгийн 7.3.5-д “Хорих анги, цагдан хорих, баривчлах байр, “Сургалт-хүмүүжлийн тусгай байгууллага”-д хоригдож хүмүүжиж байгаа суурь өвчтэй, хөгжлийн бэрхшээлтэй иргэний эрүүл, аюулгүй байдлыг бүрэн хангаж, хүний эрхийг дээдэлсэн орчин нөхцөл бүрдүүлнэ.”, 7.3.11-д “Гэр бүлийн хүчирхийлэлд өртөж байгаа ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг хамгаалах төрөлжсөн түр хамгаалах байр, гэр бүлийн хүчирхийллийн хохирогчдод мэдээлэл зөвлөгөө өгөх төвийг байгуулна.” гэж тус тус тусгасан.

Түүнчлэн, УИХ-ын 2024 оны 21 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн Хоёрдугаар бүлгийн 2.1.1.23-т “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн талаарх зөв ойлголт, хандлагыг нийгэмд төлөвшүүлэх цогц төлөвлөгөөг хэрэгжүүлж, нийгмийн харилцаанд оролцох тэгш эрхийг хангах эрх зүйн орчныг сайжруулна.”, 2.1.1.25-д “... салбар дундын нийгмийн үйлчилгээний нэр төрөл, хүртээмжийг нэмэгдүүлж, мэдээллийн тэгш байдлыг хангана.”, 2.1.1.28-д “Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөрлөх эрхийг хангаж, цахимаар, зайнаас, цагаар болон богино хугацааны хөдөлмөр эрхлэх, орлого олох боломжийг нэмэгдүүлнэ.” гэж тус тус тусгажээ.

УИХ-ын 2024 оны 181 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын хууль тогтоомжийг 2028 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл¹²”-ийн 98-д Монгол Улсын Засгийн газарт 2015, 2023 онд НҮБ-ын Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн хорооноос ирүүлсэн “хүртээмжтэй орчин, нөхцөлийг бүрдүүлэх замаар бие даан амьдрах эрхийг хангах” гэсэн зөвлөмжийг хэрэгжүүлэх зорилгоор хөгжлийн бэрхшээлтэй хүний нийгмийн харилцаанд эрх тэгш, бүрэн дүүрэн, бие даан оролцох нөхцөлийг бүрдүүлэх, аливаа саад учрахаас урьдчилан сэргийлэх, учирч буй саадыг арилгах, барилга байгууламж, авто зам, замын байгууламж, нийтийн тээвэр, мэдээллийн технологи, харилцаа холбоо, үйлчилгээний хүртээмжийг бүрдүүлэхтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулах зорилгоор Саадгүй байдал, хүртээмжийн тухай анхдагч хуулийг 2025 онд батлуулахаар тусгасан.

¹⁰ 2030 он гэхэд эрэгтэй, эмэгтэй бүх хүн, түүний дотор залуу болон хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг бүрэн, бүтээмжтэй ажил, зохистой хөдөлмөр эрхлүүлж, адил үнэ цэнэтэй ажилд адилхан цалин хөлс олгох

¹¹ Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль. Эх сурвалж: <https://legalinfo.mn/mn/detail/11711>

¹² Монгол Улсын хууль тогтоомжийг 2028 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл. Эх сурвалж: <https://legalinfo.mn/mn/detail?lawId=17333392437841&showType=1>

Монгол Улсад 100 орчим хууль, 20 гаруй стандарт, норм, дүрэмд ХБХ саадгүйгээр хүртээмжтэй үйлчилгээ авч, Үндсэн хуулиар баталгаажсан эрхээ эдлэх тухай заасан байх авч хэрэгжилт хангалтгүй байгаа нь зорилтот бүлгийн эрх ашгийг хойш тавих, албан тушаал, эрх мэдлээ урвуулан ашиглах, бусдад давуу байдал олгох явдал түгээмэл байгааг илэрхийлэхийн сацуу хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлагын тогтолцоо, хэмжээ хангалтгүй байгааг харуулж байна. Түүнчлэн холбогдох стандартууд зөвлөмжийн шинжтэй байгаа нь хуулийг нэр төдий хэрэгжүүлэх, шаардлага хангахгүй бүтээн байгуулалт хийх, үйлчилгээ нэвтрүүлэхэд нөлөөлж байна.

Монгол Улсын эрх зүйн мэдээллийн нэгдсэн сан “Легалинфо¹³”-д бүртгэлтэй эрх зүйн баримт бичгүүдийг судалж үзэхэд 10 гаруй олон улсын гэрээ, конвенц, 100 орчим хуульд саадгүй байдал, хүртээмжийн асуудлыг тусгасан байна. Тухайлбал, Хүний эрхийн түгээмэл тунхаглал, Эдийн засаг, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пактын нэмэлт протоколыг соёрхон батлах тухай, Боловсролын талаар алагчилахтай тэмцэх тухай конвенц, Тахир дутуу хүмүүсийн мэргэжлийн нөхөн сэргээлт, ажил эрхлэлтийн тухай 168 дугаар зөвлөмж, Хараагүй, харааны бэрхшээлтэй, эсхүл хэвлэмэл бүтээл унших бэрхшээлтэй хүмүүст зориулан хэвлэн нийтлэгдсэн бүтээлийг хүртээмжтэй болгох тухай Марракешийн гэрээг соёрхон батлах тухай, Эмэгтэйчүүдийг алагчилах бүх хэлбэрийг устгах тухай конвенц зэрэг 10 гаруй олон улсын эрх зүйн баримт бичигт Монгол Улс нэгдэн орж, соёрхон баталсан.

Хүчин төгөлдөр мөрдөгдөж буй 933 хуулиас “хүртээмжтэй” байдлыг 82 хуульд¹⁴, саадгүй байдлыг 5 хуульд тусгасан байна. Эдгээрээс Монгол Улсын Үндсэн хууль, Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль, Барилгын тухай¹⁵, Хот байгуулалтын тухай¹⁶, Автотээврийн тухай¹⁷, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай¹⁸, Өргөн нэвтрүүлгийн тухай¹⁹, Олон нийтийн радио, телевизийн тухай²⁰, Харилцаа холбооны тухай²¹, Номын сангийн тухай хууль²², Сонгуулийн тухай²³ зэрэг хуулиуд тусгасан ХБХ-нд хүртээмжтэй, саадгүй орчин, үйлчилгээ бий болгох талаарх зохицуулалтууд чухал ач холбогдолтой байна. Эдгээр хуулийн заалтад нийцүүлэн боловсруулсан барилгын норм, дүрмээр, тухайлбал, Олон нийт, иргэний барилга /БНБД 31-03-03/, Олон нийт, иргэний барилга (нэмэлт) /БНБД 31-03-03*/11/, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн амьдрах орчны шаардлагад нийцсэн зураг төсөл зохиох дүрэм /БД 31-112-11/, Хот тосгоны төлөвлөлт барилгажилтын норм ба дүрэм /БНБД 30-01-04/, Тахир дутуу иргэдэд зориулсан барилгын төлөвлөлтийн нормаль /БД 31-101-04/, Иргэний барилгын төлөвлөлтөнд хөгжлийн бэрхшээлтэй хүний шаардлагыг тооцсон орон зай, орчин, үндсэн шаардлага MNS 5682-2006, Орон сууцны барилгын зураг төсөл төлөвлөлт /БНБД 31-01-10/, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн амьдрах орчны шаардлагад нийцсэн зураг төсөл зохиох дүрэм /БД 31-112-11/, Захиргааны зориулалттай олон нийтийн барилга /БНБД 31-04-12/,

¹³ Монгол Улсын эрх зүйн мэдээллийн нэгдсэн сан. Эх сурвалж: <https://legalinfo.mn/>

¹⁴ Хавсралт №1-ээс харна уу.

¹⁵ Барилгын тухай хууль Эх сурвалж: <https://legalinfo.mn/mn/detail/11705>

¹⁶ Хот байгуулалтын тухай хууль Эх сурвалж: <https://legalinfo.mn/mn/detail/530>

¹⁷ Автотээврийн тухай хууль Эх сурвалж: <https://legalinfo.mn/mn/detail?lawId=29>

¹⁸ Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль Эх сурвалж: <https://legalinfo.mn/mn/detail/11224>

¹⁹ Өргөн нэвтрүүлгийн тухай хууль Эх сурвалж: <https://legalinfo.mn/mn/detail/15067>

²⁰ Өргөн нэвтрүүлгийн тухай хууль Эх сурвалж: <https://legalinfo.mn/mn/detail/424>

²¹ Харилцаа холбооны тухай хууль Эх сурвалж: <https://legalinfo.mn/mn/detail?lawId=523>

²² Номын сангийн тухай хууль Эх сурвалж <https://legalinfo.mn/mn/detail/10844>

²³ Сонгуулийн тухай хууль Эх сурвалж: <https://legalinfo.mn/mn/detail/12178>

Иргэний барилгын төлөвлөлтөд хөгжлийн бэрхшээлтэй хүний шаардлагыг тооцсон орон зай, орчин, үндсэн шаардлага MNS 6055-2009, Явган хүн, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан зам, техникийн шаардлага MNS 5682-2006, Явган хүн, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан замыг төлөвлөх заавар MNS 6056-2009 зэргээр ХБХ-д холбогдох нийтийн барилга байгууламж, зам талбайд тавигдах шаардлагыг тодорхойлж байна.

Хэдийгээр Монгол Улсад ХБХ-нд нийтийн барилга байгууламж, тээвэр, мэдээллийн хүртээмжтэй байдлыг хангах хууль эрх зүйн орчин харьцангуй бүрдсэн боловч хэт ерөнхий, тодруулбал, санхүүжилтийн эх үүсвэр, хариуцан хэрэгжүүлэх этгээдийг тодорхой тусгаагүй, саадгүй байдал, хүртээмжийг олон нийтэд ойлгуулах, мэдлэг, мэдээлэл түгээх, хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлагын асуудлыг орхигдуулсан, салбар бүр өөр өөрийн өнцгөөс хуулийн хэрэгжүүлдэг гээд саадгүй, хүртээмжтэй орчныг бий болгох асуудалд цогцоор нь хандаж чадахгүй байна.

Үүний улмаас ялангуяа хот төлөвлөлт, барилга байгууламж, дэд бүтцийн төлөвлөлт ХБХ-нд ээлгүй, хүртээмжгүй нь олон нийтийн өмнө ил байж шүүмжлэлтэй хандах боломж олгож байгаа бол төдийлөн ил харагддаггүй мэдээллийн, үйлчилгээний хүртээмж ч мөн адил маш хангалтгүй байна. Эдгээр нь ХБХ-ийг нийгмийн харилцаанд аливаа саадгүйгээр оролцох боломжийг хязгаарлаж, ялгаварлан гадуурхалтыг нэмэгдүүлэх суурь шалтгаануудын нэг болж байна.

Бүх хүн зорчих боломжтой, хүртээмжтэй зам, барилга байгууламж барьж, дэд бүтэц бий болгох нь зөвхөн ХБХ-ий эрхэд хамаарах асуудал гэхээс илүүтэй бүх хүн тэгш эрх эдлэх боломж бүрдүүлж буй явдал гэдгийг олон улсад хүлээн зөвшөөрч энэ талаар НҮБ-ын Конвенцод “иргэн нийгмийн харилцаанд оролцох боломжийг орчин нь хязгаарлаж байвал тэр хүн хөгжлийн бэрхшээлтэй биш. Харин тэр хүнийг орчин нь хөгжлийн бэрхшээлтэй болгож байгаа хэрэг” хэмээн онцолсон. Монгол Улсын хувьд шаардлага хангаагүй барилга байгууламж, дэд бүтцээс гадна цаг уурын нөхцөл байдал ч саадгүй байдалд давхар нөлөөлдөг тул ХБХ жилийн талаас илүү хувьд хараат, хязгаарлагдмал байдалд байдаг, мөн хэвлэл мэдээлэл, олон нийтийн мэдээллийн хэрэгсэл, ялангуяа цахим орчны хүртээмжгүй байдал нь ХБХ сурч, хөгжих, мэдээлэл авах эрхээ эдэлж чадахгүй байх, хот хөдөөгийн ялгаа улам нэмэгдэхэд нөлөөлж байна.

Манай улсын хувьд салбар бүр өөр өөрийн эрх зүйн орчинд ХБХ-ий эрхийг хангах, тэдэнд үзүүлж буй үйлчилгээг саадгүй, хүртээмжтэй байдлаар үзүүлэхийг эрмэлзэн холбогдох зохицуулалтыг оруулж байгаа боловч эдгээр зохицуулалт нь бусад салбарын хууль тогтоомжтой хэрхэн уялдаж, харилцан хамааралтай үйлчилж байгаа эсэхийг тогтоосон судалгаа байхгүй, зөвлөмж, стандартууд нь заавал мөрдөх шинжгүй, сонгож хэрэглэх боломжтой байхаар хуульчилсан, мөн нэг салбарын мэргэжилтэн нөгөө салбарын хууль тогтоомжийн талаар мэдлэг сул, өөрийн ажиллаж буй салбарынхаа хууль тогтоомжийн талаар бүрэн мэдээлэлгүй байдаг нь хууль тогтоомжийг хэрэгжүүлэхэд саад учруулах, хяналт хэрэгжүүлэх механизм тодорхойгүй байх, хариуцлагаас мултрах арга хэлбэр олон байхад нөлөөлж байгаа тул саадгүй байдал, хүртээмжийн асуудлыг зохицуулсан нэг эрх зүйн акт бий болгох шаардлагатайг харуулж байна.

1.2.Хэрэгжилт: Орчны саадгүй байдал

Хөгжлийн бэрхшээлтэй хүний нийгмийн харилцаанд тэгш эрхтэй оролцох эрхийг орчны саад, хүртээмжгүй байдал хамгийн ихээр зөрчиж, гадаад орчноос хязгаарлах шалтгаан болдог.

Саадгүй байдал, хүртээмжийг хангах зорилготой хууль эрх зүйн орчны хувьд 2016 онд батлагдсан Барилгын тухай хуулийн 11.1.6 дахь “хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хангах, барилга байгууламж хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг зорчих, хөдөлгөөний аюулгүй байдлыг бүрэн хангасан байхаар төлөвлөн баригдсан байх”, 12.1.6-д зааснаар хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хэрэгцээ, техникийн шаардлагыг хангасан байх” шаардлага тавигддаг ба хуулийн хэрэгжилтийг стандарт, норм, дүрмээр нарийвчлан зохицуулдаг. Тухайлбал, Улаанбаатар хотын хувьд иргэдийн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангах, сайжруулах үүднээс нийт 22 бүлэг, 97 стандартыг батлан мөрдөхөөр төлөвлөж байгаагаас 2023 оны байдлаар эхний 52 стандартыг батласан ба үүний 19 стандартад тусгай хэрэгцээт иргэдийн хүртээмжийг хангах тухай заалтууд туссан. Сүүлд нэмэгдсэн 14 стандартын хоёр нь зөвхөн тусгай хэрэгцээт иргэдийн хүртээмжтэй байдлыг хангахад чиглэсэн байна.²⁴

Мөн Хот байгуулалтын тухай хуулийн 20 дугаар зүйлд ХБХ-ий барилга байгууламж, дэд бүтцийг саадгүй, хүртээмжтэй байдлыг төлөвлөхдөө төрийн захиргааны төв байгууллагаас гаргасан хэм хэмжээ, дүрэм, журмыг дагаж мөрдөх, хот төлөвлөлт, барилга угсралтын шийдэл, зураг төсөл, инженерийн зураг төсөл боловсруулах ажилд аливаа төсөл хэрэгжүүлэх зөвшөөрөл олгохыг хориглоно гэж заасан байна. Харин эдгээр хот байгуулалтын үйл ажиллагааг хэрэгжүүлэхийг хориглосон дүрмийг зөрчвөл хууль бусаар олж авсан хөрөнгө, орлогыг хурааж, учирсан хохирлыг нөхөн төлүүлж, хүнийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, мөн Зөрчлийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.5-т хот байгуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас баталсан хэм хэмжээ, дүрэм, журмыг дагаж мөрдөөгүй бол хүнийг найман зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг найман мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно гэх хариуцлагын зохицуулалт хэрэгжиж байна. Үүнээс харахад 100 мянгаас 10 сая төгрөг хүртэлх төгрөгийн торгуулийн арга хэмжээ хэдэн зуун сая, тэрбумын хөрөнгө оруулагчийн хувьд үр дүнгүй, хууль биелүүлэх сэдэл, хөшүүрэг болохгүй байна.

Саадгүй байдал (Barrier-free environment) нь илүү барилга байгууламж, дэд бүтэц буюу гадаад орчны хүртээмж буюу буюу бие, мэдрэхүй, мэдээллийн болон нийгмийн саадыг арилгасан нөхцөл байдалд хамааралтай бол хүртээмж (Accessibility)-ийн хувьд ХБХ болон бүх хүний оролцоог дэмжих чиглэлд хэрэгжүүлж буй үйл ажиллагаа, үр дүнг илэрхийлдэг.

Иймээс саадгүй байдал, хүртээмжийн асуудлыг барилга, байгууламж, дэд бүтэц, зам тээвэр болон үйлчилгээ, мэдээлэл, харилцаа холбоо гэсэн үндсэн хоёр хэсэг хувааж судаллаа.

1.2.1. Барилга, байгууламж, дэд бүтцийн саадгүй байдал

²⁴ Монголын тэргэнцэртэй иргэдийн үндэсний холбооны гишүүдтэй уулзлаа Эх сурвалж: НЗДТГ-ЫН ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЭЛ, ОЛОН НИЙТТЭЙ ХАРИЛЦАХ ХЭЛТЭС 2023 оны 05 сарын 08

Монгол Улсад өнөөдөр 112 мянга гаруй ХБХ амьдарч байгаагаас 2023 оны байдлаар 3 хүн тутмын 1 нь буюу 35 мянга гаруй²⁵ ХБХ нийслэл Улаанбаатар хотод амьдарч байгаа ба эдгээр иргэд жирийн иргэдийн адил нийгмийн үйлчилгээг авч чадахгүй байна. Үүний гол шалтгаан нь ХБХ-д зориулсан дэд бүтэц хангалтгүй, төрийн үйлчилгээ, олон нийтийн үзвэр үйлчилгээний газрууд тэдний асуудлыг орхигдуулсны улмаас хязгаарлагдмал нөхцөл байдал буюу бэрхшээлийг улам нэмэгдүүлж хэн нэгнээс хараат амьдрахаас өөр аргагүй байдал үүсгэж байна. Энэ нөхцөл байдал хотын захын гэр хороолол, хөдөө орон нутагт илүү хүндрэлтэй байна.

Хэдийгээр 2016 онд батлагдсан ХБХЭТХ-ийн 8, 9 дүгээр зүйлд ХБХ орон сууц, олон нийтийн барилга байгууламж, зам талбай, нийтийн тээвэр, мэдээлэл, харилцаа холбооны технологийг хүртээмжтэй, саадгүй ашиглах нөхцөлийг бүрдүүлэх, ийм шаардлага хангаагүй барилга байгууламжийг ашиглалтад авахгүй байх зохицуулалт оруулсан боловч өнөөг хүртэл бүрэн хэрэгжээгүй. Үүнд уг хуулийн 9.5-д заасан барилга ашиглалтад авах улсын комисс шаардлага хангаагүй барилга хүлээж авч байгаа нь нөлөөлж байгаа боловч тэдэнд хариуцлага хүлээлгэх эрх зүйн орчин тодорхойгүй, хариуцлага хүлээлгэдэггүй байдал нөлөөлж байна. Үүний нэг илрэл бол ХБХ-ийг орон сууцаар хангах, нийтийн зориулалттай орон сууц ХБХ-нд саадгүй хүртээмжтэй байх асуудал юм. Тухайлбал, сүүлийн жилүүдэд шинээр баригдаж буй орон сууц, орон сууцны хорооллын барилга байгууламж нь ХБХ-нд ээлгүй, орц, гарц, зогсоол хангалтгүй зэргээс гадна явган хүний зам талбай, замын хашлага, замын гарц тэргэнцэртэй болон харааны бэрхшээлтэй иргэдэд ээлгүй, хүүхэд, хөгшидөд ч хүндрэл үүсгэж байна.

Орчны хүртээмжийг сайжруулах тухай асуудал нь зөвхөн ХБХ-д хамааралтай бус, харин тухайн улс, хотын хөгжлийн суурь бодлого, төлөвлөлт болон хөгжиж байна. Харах, сонсох, хөдлөх, танин мэдэх, бусадтай харилцах, сэтгэн бодох, хүртэх, сэтгэлийн хөдөлгөөнөө удирдах, өөрийгөө хянах, анхаарлаа төвлөрүүлэх, суралцах зэргээр хүн бүрийн үйлдэхүйн чадвар нь өөр өөр. Ийм өөр өөр хүн бүр л саадгүй амьдрах орчныг бүрдүүлэх нь эдүгээ улс орнуудын тэргүүлэх зорилго болжээ.²⁶

Манай улсад ХБХ-ий эрхийг хангах чиглэлээр өмнө дурдсан цөөнгүй хуулиудад тодорхой зохицуулалтуудыг тусгаж эрх зүйн орчныг бүрдүүлсэн хэдий ч хэрэгжилт хангалгүйн улмаас ХБХ-ий эрх алхам тутамд зөрчигдөж байна. Нэн ялангуяа ХБХ-ий хамгийн ихээр үйлчилгээ авдаг эрүүл мэндийн байгууллагуудын хэмжээнд ч хангалтгүй байна. Тодруулбал, 2018 онд Хүний эрхийн үндэсний комиссоос хийсэн “*Эрүүл мэндийн салбар дахь хүний эрхийн хэрэгжилтэд хийсэн үнэлгээний тайлан*”²⁷-д дурдсанаар “*нийслэлийн хэмжээнд судалгаанд хамрагдсан 9 өрхийн эрүүл мэндийн төвийн барилгуудад сүүлд шинээр бий болгосон тэргэнцэртэй хүнд зориулсан налуу зам стандартын шаардлага хангахгүй, мөн эрүүл мэндийн төв хүртэлх замд хашлага, босго, шон, бродюрь их байх боловч хараагүй иргэд зориулсан тусгай тэмдэглэгээтэй замгүй байгаа нь гадаад орчны хамгийн том бэрхшээл байна. ... Харин үнэлгээнд хамрагдсан аймаг, сумын нэгдсэн эмнэлэг, БОЭТ, амаржих газруудын гадаад орчны*

²⁵ ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ХҮНИЙ ТОО, хүйс, бус, аймаг, нийслэлээр. Эх сурвалж: https://www2.1212.mn/tables.aspx?tbl_id=DT_NS0_3900_002V1&SOUM_select_all=1&SOUMSingleSelect=&SEX_select_all=0&SEXSingleSelect=_1&YearY_select_all=0&YearYSingleSelect=_2023_2022_2021&viewtype=table

²⁶ Хүн бүр саадгүй амьдрах орчин бүрдүүлэе. Өнөөдөр сонин. *О.Бат-Ундрах. 2022.02.16*

²⁷ ХЭҮК. Эрүүл мэндийн салбар дахь хүний эрхийн хэрэгжилтэд хийсэн үнэлгээний тайлан. 2018 он. Эх сурвалж: <https://lib4u.net/?lib=nhrс&search=>

Эрүүл+мэндийн+салбар+дахь+хүний+эрхийн+хэрэгжилтэд+хийсэн+үнэлгээний+тайлан

тохижилт ХБХ эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авах боломжийг харьцангуй сайн хангаж өгсөн нь барилга байгууламж анхнаасаа эмнэлгийн зориулалтаар баригдсанаас гадна түүний гадаад, дотоод орчинд зарим өөрчлөлт, өргөтгөл хийх зай талбай хангалттай байсантай холбоотой байв.” гэжээ.

Мөн Хөгжлийн бэрхшээл үүсгэж буй шалтгаан нөхцөлийн 40 хувийг эзэлж буй зам тээврийн осол, түүнийг үүсгэгч автозамын болон явган хүний зам талбайн дэд бүтцийн асуудал өнөөг хүртэл шийдэгдээгүй, ХБХ-д төдийгүй, эрүүл мэндийн хувьд асуудалгүй иргэдэд ч ээлгүй байна. Тиймээс зам тээврийн ослын эрсдэлтэй нөхцөлд хөгжлийн бэрхшээлтэй хүний дэд бүтцийн хүртээмж хангалтгүй байх нь тэднийг нийгмийн харилцаанаас шууд тусгаарлах хүчин зүйл болж байгааг судалгааны дүн харуулж байна. Тодруулбал, ХБХ нийгмийн харилцаанд тэгш эрхтэй оролцоход юу саад болж буй талаарх асуулгад хамрагдсан иргэдийн 2,36 хувь нь өөрөө оролцох сонирхолгүй, 27,6 хувь нь нийгмийн харилцаа, 80,0 хувь нь зам, шат, хаалга хүндрэл үүсгэдэг гэсэн бол 98 хувь нь тээврийн хэрэгсэл, унаа гэсэн хариултыг өгчээ.²⁸

Тэгвэл олон улсад барилга байгууламжийн хүртээмжтэй байдлыг “ISO 21542:2021 — Building construction — Accessibility and usability of the built environment” стандартаар барилга, байгууламжийн хүртээмжийг тодорхойлдог ба 1/Олон нийтэд нээлттэй барилга, дотор/гадаах орчныг хөгжлийн бэрхшээлтэй болон өндөр настай хүмүүст зориулах шаардлагууд (өргөн хаалга, шатнаас гадна налуу зам, мэдээллийн тэмдэглэгээ гэх мэт), 2/ Тэргэнцэртэй хүний эргэн тойронд эргэх зай, хаалга онгойлгох, ариун цэврийн өрөөний зохион байгуулалт гэх мэт нарийн зааварчилгаа, 3/ Тохиромжтой г г мөрдсөн эсэхийг шалгадаг.

Сүүлийн үед “Түгээмэл загвар” (Universal Design) гэх хүн бүрийн хэрэгцээнд нийцсэн, тусгай зохицуулалт шаардахгүйгээр ашиглах боломжтой архитектурын шийдлүүд ч хөгжиж байна. Энэхүү түгээмэл загвар нь үндсэн 7 зарчимд тулгуурлах ба эдгээр нь 1/ бүх хүн ижил нөхцөлд ашиглах боломжтой байх “Тэгш хэрэглээ”-ний зарчим, 2/ хэрэглэгчийн онцгой хэрэгцээ, шаардлагыг хангахуйц “Уян хатан байдал”-ын зарчим, 3/ ашиглахад ойлгомжтой, төвөгшил багатай “энгийн, ойлгомжтой байх” зарчим, 4/ хараа, сонсгол, мэдрэхүйн ялгаатай байдлыг харгалзах “мэдрэхүйд хүртээмжтэй байх” зарчим, 5/ хэрэглэгч алдаа гаргасан ч аюулгүй байх “Алдаа тэсвэрлэх” зарчим, 6/ ашиглах, хэрэглэхэд их хүч, хичээл шаарддаггүй байх “Бага хүч шаардах” зарчим, 7/ хүн бүрт тохирсон орчинтой байх (хүүхдийн тэрэгтэй, тэргэнцэртэй хүн гэх мэт) “Хэмжээ, орон зайн хүртээмж”-ийн зарчмаас бүрддэг байна.

Барилга байгууламжийн саадгүй байдлыг бүрдүүлэхэд чиглэсэн өөр нэг зарчим бол “Дизайны 7 зарчим” (Seven principles of design) юм. Энэ нь аливаа зураг, уран бүтээл, график, архитектур, бүтээгдэхүүн зэргийн загвар нь тэнцвэртэй, ойлгомжтой, гоо зүйн хувьд зөв зохион байгуулах үндсэн суурь зарчмыг агуулдаг. Эдгээр зарчмуудыг дагах нь хэрэглэгчид ойлгомжтой, сэтгэлд нийцсэн бүтээлийг бий болдог. Эдгээр 7 зарчимд тэнцвэр (Balance)²⁹, эсрэг тэсрэг байдал (Contrast)³⁰, тодруулах (Emphasis)³¹, хөдөлгөөн (Movement)³², давталт (Repetition)³³, харьцаа

²⁸ Д.Сүнжид. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээний тайлан. 2018 он.

²⁹ Харааны жинг зөв хуваарилах. Симметрик буюу тэнцүү, асимметрик буюу тэнцвэрт бус зохиомж ч байж болно.

³⁰ Хэмжээ, өнгө, хэлбэр, бүтэц зэргийн ялгааг тодотгож анхаарал татах.

³¹ Анхаарал хандуулах төв цэг буюу гол элемент. Жишээ нь: том гарчиг, хурц өнгө.

³² Харааны урсгал бий болгох буюу хэрэглэгчийн нүдийг аль чиглэлд удирдах.

³³ Элементийг дахин давтах нь бүтээлд нэгдмэл байдал, хэмнэл өгдөг.

(Proportion)³⁴, нэгдмэл байдал (Unity or Harmony)³⁵ гэсэн үндсэн агуулга багтдаг байна. Эдгээр зарчмуудыг хэрэгжүүлснээр тухайлбал, веб дизайнын хувьд гарчиг том, ойлгомжтой (emphasis), товчлуурууд жигд байрласан (balance), нэг төрлийн өнгө, фонтоо (unity) байх боломжтой бол гэрэлтүүлэг дизайны тухайд гэрлийн цэгийн байрлал хөдөлгөөнийг удирдана (movement), тод/бүүдгэр ялгаа (contrast) гарна зэрэг энгийн, саадгүй, хялбар байх боломж бүрдэнэ гэж үздэг.

Монгол Улсын хувьд саадгүй байдал, хүртээмжийг нэг дор тусгасан хууль, эрх зүйн орчин одоогоор бүрдээгүй. Гэхдээ энэ чиглэлд УИХ-аас 2017 баталсан “Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрх, оролцоо, хөгжлийг дэмжих үндэсний хөтөлбөр”-т хүртээмжтэй орчин бүрдүүлэх ажлуудыг үе шаттай хэрэгжүүлэх, барилга, тээвэр, мэдээлэл, үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх талаар цогцоор нь тусгасан байсан боловч уг хөтөлбөрийг 2021 онд хүчингүй болгосон. Иймээс одоо ХБХ-д саадгүй, хүртээмжтэй орчин, нөхцөлийг бүрдүүлэх асуудлыг харьцангуй нэг дор зохицуулсан хууль ХБХ-ЭтХууль бөгөөд ХБХ-ий тухайд үүрэгжүүлсэн зохицуулалтууд нь хүүхэд, хөгшид зэрэг саадгүй орчин нэн шаардлагатай иргэдийн асуудалд хамаарахгүй.

Барилга байгууламж, дэд бүтцийн хувьд саадгүй байдлыг баталгаажуулах эрх зүйн зохицуулалтыг ихэвчлэн барилгын стандарт, норм, дүрмээр зохицуулж байгаа ба эдгээр баримт бичгийг боловсруулах ажил хангалттай түвшинд хэрэгждэг ч эдгээр эрх зүйн актуудыг нь энэ чиглэлээр ажиллаж буй аж ахуйн нэгж, байгууллага, тэдгээрийн үйл ажиллагаанд хяналт тавих эрх бүхий байгууллага, албан тушаалтнууд ашиглах нь түгээмэл байна. Учир нь иргэд стандартууд төлбөртэй, саадгүй байдлыг бүрдүүлэхийг шаардсан ямар стандарт, норм, дүрэм байдаг нь мэргэжлийн бус хүнд ойлгомжгүй, жагсаалт байдаггүй зэрэг асуудлаас үүдэн анхаарлын гадуур үлдээж байгаа нь олон нийтийн хяналт хэрэгжихгүй байх үндэс болж байна. Иймээс хүчин төгөлдөр мөрдөгдөж буй холбогдох хууль, тогтоомж, стандартуудыг бүрэн дүүрэн хэрэгжүүлэхэд шаардлагатай үнэлгээний хуудас, стандартуудыг цаг тухайд нь боловсруулах, шинэчлэх, үүнд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн төлөөллийн оролцоог бодитойгоор хангаж барилга байгууламжийн болон замын зураг төсөл боловсруулах, зураг төсөл хүлээн авах комисст заавал оруулах шаардлагатай байна.

Өнөөгийн байдлаар дэд бүтцийн саадгүй байдлыг хангах талаар Барилга дотор ба гадна орчны зохион байгуулалтын талаар MNS 6055:2009 ХБХ-д зориулсан барилгын хүртээмж, зам, гудамж, нийтийн талбайд хэрэглэх нөхцөлийг заасан MNS 6056:2009 Хөдөлгөөнд саадгүй орчин, тэргэнцэртэй хүний зорчих налуу замын шаардлагыг заасан MNS 6228:2010 Барилгын налуу замын стандарт, Тэмдэглэгээ харааны бэрхшээлтэй иргэнд нийцэх шаардлагын талаарх MNS 6302:2011 Мэдээллийн тэмдэг, дохио, Саадгүй орчны шаардлага, мэдээлэл, тав тухын талаарх MNS 6389:2013 Нийтийн тээврийн хэрэгсэл зэрэг стандартуудыг сонгон хэрэглэх боломжтой байна.

Нийтийн зориулалттай барилга байгууламжууд, ялангуяа төрийн үйлчилгээ үзүүлж буй байгууллагууд хуучны барилга байгууламжид эсхүл түрээсийн байранд үйл ажиллагаа явуулж байгаа нь стандартад нийцээгүй орчинд ХБХ үйлчилгээ авах нөхцөл байдалд хүргэж байна. Тухайлбал, ХНХСайдын 2018.04.18-ны өдрийн А/93 тушаалаар хөдөлмөр хамгааллын

³⁴ Элементүүдийн хоорондын хэмжээний зохистой байдал. Жишээ нь: хүний биетэй харьцуулахад сандал тохиромжтой хэмжээтэй байх.

³⁵ Бүх элементүүд нэгэн цогц болж зохицон харагдах. Сэдэв, өнгө, хэлбэр зэргээр уялдаж байх

салбарын нийслэл дэх нийт 37 байгууллагуудын барилга, байгууламжууд холбогдох стандартад нийцсэн эсэх хүртээмжийн үнэлгээг нэгдсэн удирдамжийн дагуу Түгээмэл хөгжил төв, Сонгино бие даан амьдрах төв, Монголын тэргэнцэртэй иргэдийн үндэсний холбоо ТББ аас 2018 онд гүйцэтгэсэн бөгөөд үнэлгээний дүгнэлтэд үнэлгээнд хамрагдсан нийт байгууллагуудын налуу замаас нэг ч стандартад нийцсэн зам байгаагүй, бүх байгууламжид ариун цэврийн өрөөний хаалга стандарт бус, суултуурын өмнөх орон зай стандарт бус буюу хүртээмжгүй, нэмэлт тоноглол буюу бариулгүй байсан бол 90% нь авто зогсоолдоо ХБХ-ий авто зогсоолын төлөвлөлт хийгээгүй, тэмдэг тэмдэглэгээ хийгээгүй, зогсоолын өргөн стандартын бус, үнэлгээнд хамрагдсан ХХҮХ-үүдээс цөөнгүй байгууллага стандарт огт хангаагүй түрээсийн байранд үйл ажиллагаа явуулдаг, давхар хаалгатай, хаалганы өргөн, босгоны өндөр стандартын шаардлага хангаагүй байсан зэрэг зөрчлийг арилгах чиглэлээр урт ба богино хугацааны ажлын төлөвлөгөө боловсруулах, шийдвэр гаргах төрийн зохих шатны эрх бүхий этгээдэд энэхүү үнэлгээний товч мэдээлэл боловсруулан хүргүүлэх, Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн төрийн бус байгууллагуудтай хамтарч ажиллахыг мөн зөвлөмждөө тусгасан байна.³⁶

Шигтгээ: Тэргэнцэртэй хүний хувьд би хотод үнэхээр муу дүн тавина. Улаанбаатар хот бол аймшигтай, үнэхээр харгис байна л гэж хэлнэ. Би өөрөө машинаа бариад явдаг. Нийгмийн амьдралаа идэвхтэй байж ажлаа хийнэ, мөн хувийн амьдралаа зохицуулна, бусдад дараа болохгүй гээд бүх чадлаараа зүтгэдэг. Гэтэл энэ ярьж байгаа дэд бүтцээс авхуулаад хүмүүсийн хандлага, ойлголт маш хэцүү байдаг. Би уг нь ажил хөдөлмөр эрхлээд, цалин аваад, улсдаа татвар төлөөд, өрхийнхөө амьдралыг аваад явж байгаа. Зарим үед жирийн хүнээс илүү ачаалалтай ажилладаг. Гэтэл хүмүүс тэгж ойлгодоггүй, бидний ялгаатай талыг л хараад байдаг. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд халамжийн мөнгө өгөөд, гэрт нь байлгах ёстой гэдэг социализмын үеийн сэтгэлгээ одоо хүртэл ард иргэдэд байсаар л байна. Энэ утгаараа төрийн бодлого, хийж байгаа дэд бүтцийн төлөвлөлт нь үнэхээр муу. Улаанбаатар хотод олон гоё шинэ барилгууд баригдаж байна. Хүмүүс тэнд орж амьдарч, үйлчлүүлэх ёстой. Бид бас хүн шүү дээ. Бид бусадтай адил дэлгүүр орж, ресторанд сууж, үйлчилгээний газруудаар үйлчлүүлэх эрхтэй. Гэтэл тэр дэд бүтцүүд нь байдаггүй. Имарт дэлгүүр гарч ирээд бидний хувьд нөхцөл байдал нилээд таатай болж ирсэн. Хүнтэй гадуур хоолонд орё гэхээд аль газар налуу замтай билээ, аль ресторан нь тусгай 00-той билээ гээд ярьсаар байгаад таардаг. Тэргэнцэртэй хүн өөрөө ороод, бие даагаад зорчоод явах байшин барилга Монголд байдаггүй. (“Би чадна” ТББ-ын тэргүүн Б.Отгонтуяа ikon.mn-д нийтлэгдсэн ярилцлагын хэсгээс)

ХБХ-нд хүртээмжтэй орчин бий болгох асуудлыг нэр төдий хэрэгжүүлж байгаа нь аль аль талдаа үр ашиггүй зардал гаргаж байна.

Шигтгээ: “оролцогчийн амьдардаг байранд лифттэй боловч хаалганаас лифт хүртэл шаттай учраас хүртээмжгүй байна гэсэн үг. Тиймээс энэ нь хот төлөвлөлт, хамтын ажиллагааны асуудал болж харагдаж байгаа юм; “ихэнх байшин цөөхөн хүртээмжтэй газруудтай хэдий ч тэдгээрийг холбосон хонгил хүртээмжгүй байдаг”³⁷.

³⁶ Д.Сүнжид. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээний тайлан. 2018 он.

³⁷ [UB Case Study Publication Package Mongolian version.pdf](#)

1.2.2. Явган хүний зам, тээврийн хэрэгслийн саадгүй байдал

Монгол Улсын 110 гаруй мянган ХБХ хаана амьдарч буйгаас үл шалтгаалан гэрээсээ гараад аливаа үйлчилгээг саадгүй авахад эхний ээлжинд тулгамдаж буй асуудал бол дэд бүтэц, зам, тээврийн хэрэгслийн саад юм. Иймээс зам, барилга барих бүртгээ нас насныхан, бүх хүн явах боломжийг бүрдүүлэхийн хэрээр хүний эрх хангагдах ба замын өргөн, эхлэл, төгсгөлийг ямар ч тэрэг, дугуйтай хүн явахад саадгүй байх нь иргэн бүрт тэгш, хүртээмжтэй, ээлтэй орчин бүрдүүлэхэд чухал үүрэгтэй юм. Ялангуяа төрийн захиргааны болон үйлчилгээний байгууллагуудын барилга, байгууламжийн саадгүй байдал нэн чухал. Сүүлийн жилүүдэд орчны хүртээмж бага багаар сайжирч байгаа ч хот төлөвлөлтийн алдаатай байдлаас шалтгаалан нэгэнт барьсан барилга байгууламж, зам талбайн саадгүй байдлыг хангахад хүндрэлтэй байна.

Үүнээс гадна ХБХ-ий амьдрах орчны саад бэрхшээлүүдэд өвлийн улирлын цаг уурын хүндрэл, лифтгүй өндөр барилгууд (өндөр гадаах шат), халаалтын ба бохир зайлуулах дэд бүтэц болон гэр хорооллын гадаах жорлон багтаж байна.³⁸

Барилга байгууламж, дэд бүтцийн саадгүй байдал, хүртээмжийг нэмэгдүүлэхэд төрийн үүрэг, оролцоо, санаачлага хэрэгтэй байна. Өөрөөр хэлбэл, төр өөрөө Үндсэн хуулиар иргэдийнхээ өмнө хүлээсэн үүргийнхээ хүрээнд төрийн байгууллагуудын барилга байгууламжийн саадгүй байдал, хүртээмжийг сайжруулах, хуулийн шаардлага хангах, мөн улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр, санхүүжилтээр хэрэгжүүлэх төсөл хөтөлбөрүүд, жишээ нь зам талбайн ажил зэргийг сонгон шалгаруулах, хүлээн авахдаа саадгүй байдал, хүртээмжийг анхдагч шалгуур үзүүлэлт болгох шаардлагатай байна.

ХБХ-ий ажиллаж, амьдрах, нийгмийн харилцаанд оролцох орчин нөхцөл бүрдүүлэх, тулгарсан саадуудыг арилган, бүх хүнд ээлтэй хот төлөвлөн, байгуулах нь төрийн болон хувийн хэвшлийн байгууллагынхны ч үүрэг, хариуцлага. Хүртээмжтэй орчин буюу түгээмэл загвар нь зөвхөн ХБХ-нд зориулагддаггүй, харин ч нас насны бүх иргэн, нийгмийн харилцаанд оролцогч хүн бүрт шаардлагатай зүйл. Жишээ нь, налуу болон чиглүүлэгчтэй хөтөч замаар тэрэг түрсэн хүн, өндөр настан, хүүхдүүд ч ээлтэй орчин, бүх хүн түүгээр эрх тэгш зорчих боломжийг бүрдүүлдэг. ХБХ-ий эрхийг хангах чиглэлээр хэрэгжүүлж буй хууль тогтоомж, стандартууд нь барилгажсан хотын төвийн бүсэд хамааралтай байгаа бол гэр хороолол буюу дэд бүтэц хөгжөөгүй хотын хэсэгт амьдарч буй ХБХ-ий эрхийн асуудал хүнд хэвээр байна.


Шигтгээ: Явган зорчигчдын хувьд хотоор явахад хэцүү. Хотын төвийн зарим хэсэгт тактилан зам, хүртээмжтэй гарцтай хэдий ч газар бүрд адил биш. Гэр хороололд зам нь засмал биш, эгц өгсүүр газарт цаг агаарын ямар ч нөхцөлд явахад хүнд байдаг. Манай зарим оролцогчид автомашины замаар явахад хялбар гэж үзэн тэргэнцэртэйгээ явдаг: “энэ нь аюултай, машинууд маш ойрхон явдаг, гэвч надад явах өөр зам байхгүй, өөр сонголт байхгүй. Явган хүний зам дээр заримдаа шороо овоолчихсон, заримдаа машин зогсчихсон байдаг”.

³⁸ Мөн тэнд

ХБХ-нд аливаа үйлчилгээ тасралтгүй хүртээмжтэй байх нь чухал. Өнөөгийн байдлаар ХБХ өөрт шаардлагатай ямарваа нэг үйлчилгээг авах хамгийн эхний хэрэгцээ болох дэд бүтцийн, тээврийн хэрэгслийн хүртээмж хангалтгүй, холбогдох хууль тогтоомж хэрэгжихгүй байгаа нь тэднийг эрхээ эдлэх боломжийг хязгаарлаж байна.

ХБХ-нд саадгүй, хүртээмжтэй явган хүний зам талбайд холбогдох асуудлыг Барилгын тухай хууль, Хот байгуулалтын тухай хууль, ХБХЭТХ-иас гадна “Авто замын байгууламж: Явган хүн, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан зам, Техникийн шаардлага” MNS 5682:2006, “Авто замын байгууламж: Явган хүн, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан замыг төлөвлөх заавар” MNS 6056:2009 стандартуудад тусгасан. Гэвч хууль тогтоомжийн хэрэгжилт хангалтгүй, улс, орон нутгийн санхүүжилтээр жилээс жилд тэлж буй явган хүний болон автозам, тэдгээрийн бүрэлдэхүүн хэсэг ХБХ-нд саадтай хэвээр байна. Тухайлбал, ЖАЙКА ОУБ-ын “Улаанбаатар хот дахь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн оролцоог дэмжих” төслийн хүрээнд ХБИ-ийн нийгмийн үйлчилгээний хүртээмжид хийсэн үнэлгээнд³⁹ Улаанбаатар хотын 19 чиглэлд 98 км явган хүний замд 1/ явган хүний замын гарцын налууугийн хэвгий, 2/ Хөтөч зам, 3/ анхааруулах тэмдэг, тэмдэглэгээ, 4/ дуут дохио гэсэн шалгуурын хүрээнд үнэлгээ хийжээ. Үнэлгээг дээр дурдсан стандартын дагуу үнэлж дараах асуудлуудад илүүтэй анхаарсан бөгөөд үр дүн маш хангалтгүй байсан. Үр дүнгээс харуулбал,

График 1 Явган хүний замын гарцын налууугийн хэвгий:




Явган хүний замын гарц гэсэн тэмдэгтэй, эсвэл гарцын тэмдэгт цагаан судалт замтай ч стандартын дагуу гарцад налуу огт хийж өгөөгүй гарц нийт замын 41.83%, стандарт бус зам 37,5%-ийг эзэлсэн байна. Үүнээс харахад нийслэлийн явган хүний замын 80 хувь нь стандарт хангахгүй байна. Жишээ болгон үзүүлж буй зурагнуудаар нийтийн эзэмшлийн зам талбай налуу замын стандарт хангахгүй байгаа талаар харуулахыг зорьлоо. Хэдийгээр гарцын замын тэмдэглээ байгаа ч налуу зам хийж өгөөгүй, гарцанд налуу хийсэн боловч налуу стандарт бус, хэтэрхий огцом, урьдчилан таашгүй бэрхшээл үүсгэсэн, налуу стандарт боловч хөтөч зам салаагүй, анхааруулах хавтангүй, стандарт хангаагүй, анхааруулга, мэдээлэл хангалттай хүргэж

³⁹ ХНХЯ-ны төрийн нарийн бичгийн даргын 2016 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн А/183 дугаар тушаалаар 3-н салбарт хүртээмжийн үнэлгээ хийгдсэн байна

боломжгүй, цэвэрлэгээ, арчилгаа муу зэрэг ашиглахад хүндрэлтэй, дүр эсгэсэн гүйцэтгэлүүд их байна.

Зураг 1 Явган хүний зам




Налуу замын налуугийн хэвгий $7.1 \pm 1.2\%$ гэсэн үндсэн шаардлагыг хангаж байвал стандарт хангана гэж үздэг. Дээрх зургаар харуулсан жишээнүүдэд стандартыг бүрэн хангасан гарц байгаагүй ба стандарт бус налуу нь тэргэнцэртэй хүн ашиглахад хойшоо савж унах эсвэл урагшаа тонгорцоглох бол явдаг хүмүүст халтирах бэрхшээл үүсгэж байна. Иймээс стандарт бус гарц нь бүх хүмүүст бэрхшээл үүсгэж байгааг анхаарах ёстой.

График 2 Хөтөч зам




Үнэлгээгээр “хөтөч зам”-ын нөхцөл байдлыг үнэлсэн байх ба үнэлгээнд хамрагдсан замын 35% нь огт хөтөч замгүй, 57% нь стандарт бус хөтөч замтай буюу нийт замын 90% шаардлага хангаагүй байна. Энэ нь явган хүний замын 90% нь харааны бэрхшээлтэй хүн ашиглах боломжгүй байна гэсэн дүгнэлтэд хүргэсэн байна.



Үнэлгээгээр “Огт байхгүй” гэсэн ангилалд огт хөтөч зам тавиагүй замыг, харин бусад дутагдалтай замыг “стандарт бус”-д тооцжээ.

График 3 Анхааруулах хавтан



Анхааруулах хавтан буюу гадаргуу нь гарцны дээр тавьж хүн, авто зам зэрэг ямар нь осол аюултай бүсд нэвтэрч буйг мэдээллэх зориулалттай. Иймээс ихэнх улсын явган зам нь анхааруулах хавтанд хөтөч замаас илүү их анхаарал тавьж ханддаг. Харин үнэлгээ хийсэн явган замд гарцын анхааруулах гадаргуу 63.8%-д нь огт байхгүй, 7% нь стандарт бус байв.


Анхааруулах гадаргуу нь стандартын дагуу хөтөч замаас өргөн буюу 51см байх ёстой. Мөн замын булангийн гарц, түвшингийн өөрчлөлттэй газар, гарцны налуу хэсэгт, тусгаарлах аралтай хэсэгт, галт тэргэнд суух шилжих тавцангийн ирмэг дээр байрлуулах ёстой. Мөн анхааруулах гадаргуун товрууны стандарт, хоорондын зай өндөр, өнгө, оройн голч нь хөтөч замын стандартаас эрс ялгаатай байх нь сул хараатай хүн хараад танигдах, хараагүй хүний таягны үзүүрт ялгаатай мэдрэгдэх ёстой өөрөөр хэлбэл хөтөч замаас өргөн, өнгөний хувьд эрс ялгаран харагдах ёстой байх стандартын шаардлагууд зөрчигдөж байгааг дараах жишээнээс харж болно.

график 4 Дуут дохио



Харааны бэрхшээлтэй иргэдийг нийгмийн харилцаанд орох, бие даан замын хөдөлгөөнд аюулгүй зорчих, осол гэмтэлд өртөхөөс урьдчилан сэргийлэхэд “Дуут дохио”-ны үүрэг их. Үнэлгээний явцад дуут дохиотой гарц 2 байсан ба эдгээр нь ажиллагаагүй байжээ.

График 5 Дуут дохио



Стандартад дуут дохионы тухай заалт байхгүй ч хөгжлийн бэрхшээлтэй иргэдээс ирүүлсэн хүсэлтийн дагуу Улаанбаатар хотод дуут дохиотой гарц нэмэгдсэн, гэхдээ хэдэн байршилд дуут гэрлэн дохио байдаг, хэд нь байнгын ажиллагаатай талаар тодорхой тоо, мэдээлэл байхгүй. Иймээс ХБХ-ий эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийг хангахын тулд төрөөс наад захын аюулгүй

байдлыг хангасан тэмдэг, тэмдэглээ бүхий зам, талбайг бий болгох шаардлагатай байна.

Явган замын стандарт

Дараагийн асуудал бол ХБХ-ээр хязгаарлагдахгүй, бүх хүний эрх, тав тухтай, аюулгүй байдалд нөлөө бүхий явган хүний замын үнэлгээ юм. Үнэлгээний багийн зүгээс явган хүний замын үнэлгээг 1/ явган хүний замын өргөн, 2/ ногоон байгууламж, 3/анхааруулах товруут хавтан, 4/ хөтөч зам, 5/ зам дээрх саад гэсэн 5 шалгуур үзүүлэлтийн хүрээнд үнэлсэн байна. Хөтөч зам болон анхааруулах товруут хавтангийн тухайд өмнөх хэсэгт оруулсан тул энэ хэсэгт эдгээр асуудлыг давтах шаардлагагүй гэж үзсэн.

Стандартад зааснаар зорчих чөлөөний өргөн буюу бидний хэлж заншсанаар явган хүний замын өргөний план зураглал дараах хэсгээс бүрддэг байна. Үүнд:

Хэсгийн нэр	Хамгийн бага өргөн, мм
Замын хашлага	80/150
Ногоон байгууламж/тохижилтын хэсэг	610
Явган хүний зам	1500
Барилга байгууламжийн нүүр хэсгийн зай	760
Зорчих чөлөөний өргөн нийт өргөн	3100

График 6 Явган хүний замын өргөн стандартад нийцсэн эсэх


Үнэлгээний дүнгээс харахад үнэлгээнд хамрагдсан явган хүний замын 96% нь стандартын шаардлага хангасан өргөнтэй байсан байна. Гэхдээ үнэлгээнд хамрагдсан зам нийслэлийн “А” бүсэд байрлаж байсан нь 1990 оноос өмнөх хот



төлөвлөлт буюу хот төлөвлөлт эмх замбараатай байсан үед хийгдсэнийг анхаарах шаардлагатай юм.

Дээрх нөхцөл байдал одоо хотын төв хэсгээс бусад байршилд эсрэгээрээ 90 гаруй хувь нь стандартад нийцээгүй байх магадлал өндөртэй байдаг. Ялангуяа гэр хороолол, зуслангийн бүс гээд хүн амын төвлөрөл эрс нэмэгдсэн ч дэд бүтэц хөгжөөгүй байршлуудад стандартын бус байтугай огт явган хүний замгүй байх, явган хүний зам дээр цас, хог овоолох, худалдаа эрхлэх нь хотын нийтлэг дүр төрх юм.

Зураг 2 Явган хүний зам



Ногоон



байгууламж


Ногоон байгууламжтай холбоотой хоёр асуудал байгаа нь нэгт, стандартад заасан ногоон байгууламжийг байгуулдаггүй, байсныг нь устгаж талбайг нь өөр зориулалтаар ашиглахгүй байх, хоёрт, нэгэнт бий болгосон ногоон байгууламжийн арчлалт, үйлчилгээг орхигдуулснаас үүсэж буй саад юм.

Ногоон байгууламж/тохижилтын хэсэг зам дээр байрлуулсан аливаа зориулалтын шон, цахилгааны шат, рекламн самбар, автобусны буудал, гэрэлтүүлэг, ногоон байгууламж хийх ёстой. Мөн өвлийн улиралд цас хураах хэсэг болох ёстой гэж олон улсын жишигт тайлбарласан байдаг. Ийм өргөнтэй зурвас байх нь автомашины гэнэтийн ослын улмаас явган хүний зам уруу орсон тохиолдолд ногоон байгууламж дахь эдгээр зүйлст тээглэн явган зорчигч нарын эрүүл мэндийг хамгаалах үүрэгтэй. Мөн автомашины утаа нь хүнд металл нэлээн агуулсан байх учир явган зорчигчийн амьсгалд хүрэхгүй энэ хэсэгт унаж байх ёстой.

График 7 Ногоон байгууламж


Үнэлгээний явцад ногоон байгууламжтай явган хүний зам маш

ногоон байгууламж



бага, бүх замын дөнгөж 7% эзэлж байх ба хуучин ногоон байгууламжтай байсан Улаанбаатар хотын Энхтайваны өргөн чөлөөний зарим хэсэг л энэ шаардлагыг хангаж байна. Гэвч эдгээр ногоон байгууламжийн зарим хэсгийг устгаж зогсоол болгох, зам өргөтгөхөд ашиглах зэргээр бууруулж байгаа нь туйлын харамсалтайгаас гадна шинээр тавигдаж буй авто болон явган замыг зааглах ногоон байгууламжийн хэсгийг хийхгүй байгаа нь ихээхэн эрсдэл дагуулж байгаа боловч захиалагч, гүйцэтгэгчийн аль аль нь хариуцлага хүлээлгүй, ажил цааш үргэлжилсээр байна. Өөрөөр хэлбэл шинээр тавигдсан явган хүний замууд нь ямар ч ногоон байгууламжийн зурвасгүй байгаад анхаарах шаардлагатай байна.

Зураг 3 Замын ногоон байгууламж




Нөгөө талдаа ногоон байгууламжийн ашиглалт,

арчилгааны дутагдалтай байдалд анхаарах шаардлагатай байна. Явган хүний замын дэргэдэх арчлаагүй, шаардлагатай тайралт, таналт хийгээгүй ногоон байгууламж саад үүсгэж байна. Иймээс хот төлөвлөлтөөс гадна тохижилт үйлчилгээний чанар, гүйцэтгэлд анхаарах нь зүйтэй юм

Явган хүний зам дээрх саад

Түүнчлэн стандартад зааснаар явган хүний замаас хамгийн багадаа 76 см зайд ямарваа эд зүйлс байрлах ёстой боловч энэ стандартыг мөн л дагаж мөрдөхгүй байна. Тухайлбал, замын голд байршуулсан шон, зам дагуух ТҮЦ, замруу түрж барьсан барилга, траншений таг илүү гарсан, зарим таггүй нүх нь ХБХ нүхэнд унах, бэртэх, гээд дурдаж дуусахгүй олон зөрчил алхам тутамд байсаар байна.

Зураг 4 зам дээрх саад



Стандартын дагуу зам дээрх саад нь 6 мм-ээс хэтрэхгүй байх ёстой. Үнэлгээ хийсэн багийн гишүүд нийт 98-километр зам туулахдаа 109 саадтай тулгарсан байна. Тухайлбал, ялангуяа сонгуулийн үеэр эрс нэмэгддэг реклам, танилцууллагын самбарууд, худалдаа үйлчилгээ эрхлэгчид, шон, хур хог, түр байрлуулсан эд зүйл, барилгын хашаа гээд дурдаж болох юм. Эдгээр саадуудад бидний нүд дасаж, байх ёстой, байдаг л зүйл мэтээр хүлээн авч асуудлыг хөндөхгүй байгаа нь саад бэрхшээл, стрессийг нэмэгдүүлж байна.



Үнэлгээний тайланд хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомжийн хэрэгжилт хангалтгүй байгаа нь зохицуулалтыг бүрэн хийж чадаагүй, өөрөөр хэлбэл олон зүйлс орхигдсон, хариуцлагын цогц систем үйлчилж чадахгүй байна гэж дүгнэсэн байна.

Үүнд явган хүний зам буюу олон нийтийн зориулалттай газрыг хувь хүн, байгууллага ашигласан, болон өөрчилсөн, эвдсэн тохиолдолд хүлээлгэх хариуцлага сул, хүмүүст таниулан мэдээлэх ажил хийгддэггүй, зам тавьсан байгууллагуудад хүлээлгэх үүрэг хариуцлага сул байгаагаар холбоотой байна. Явган гарцтай холбоотой нүхэн болон гүүрэн гарц, төмөр замын гарцын тухай огт эрх зүйн заалт байхгүй байгаад анхаарч өөрийн орны цаг уурын онцлогт тохирсон явган хүний замын хийцийн нарийн стандарттай болох шаардлага байна.


Нийтийн тээврийн хүртээмж

ХБХЭтХууль, Автотээврийн тухай хууль, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулиудад ХБХ нийтийн тээврээр хүртээмжтэй зорчих тухай заасан. Эдгээрээс гадна Нийтийн тээврийн зогсоол, ангилал, техникийн шаардлага MNS 5879-2012, Нийтийн тээврийн зогсоолын төлөвлөлт, БД 32-101-17, Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийтийн тээврээр үнэгүй зорчих журам зэрэг дүрэм, журам, стандартууд мөрдөгдөж байна.

Хуулийн зохицуулалтаас харахад, тухайлбал, Автотээврийн тухай хуулийн 7.4-т мөн сонсголын бэрхшээлтэй иргэдэд зориулсан автобусны чиглэлд бичгээр болон харааны самбар байрлуулах, харааны бэрхшээлтэй иргэдэд зориулсан автобусны зогсоол дээр дуут мэдэгдэл гаргах шийдвэрийг аймаг, дүүргийн Засаг дарга үүрэг болгоно гэж заажээ. Гэтэл аль ч шатны Засаг дарга энэхүү баримт бичгийг боловсруулаагүй байна. Одоо Нийслэлийн ИТХ-ын 2022 оны 24 дүгээр тогтоолоор баталсан “Нийтийн тээврийн хэрэгслийн зогсоолд тавих ерөнхий шаардлага⁴⁰” мөрдөгдөж байгаа ба энэхүү шаардлагад дуут дохионы талаар тусгаагүй. Мөн Автотээврийн тухай хуулийн 10.2.8, 10.2.9 дэх заалтад 20-оос дээш автомашин эзэмшдэг аливаа байгууллага тэдгээрийн дор хаяж 10%-ийг хөгжлийн бэрхшээлтэй иргэд ашиглах боломжтой эсэхийг баталгаажуулахаар заасан байдаг. Хэрэв байгууллага энэ заалтыг дагаж мөрдөөгүй эсвэл зохих ёсоор хэрэгжүүлээгүй бол Засгийн газраас боловсруулсан (тогтоол/тушаал) -ын дагуу жил бүр тодорхой хэмжээний тор боловч зам, тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны тушаал, шийдвэрийг гаргаж, хэрэгжилтийг хангуулж буй эсэх

2016 онд батлагдсан ХБХЭТХ-д саадгүй орчин бүрдүүлэх, бодлого, хэтийн төлөвлөлтийг тодорхойлох зорилгоор тодорхой зохицуулалт оруулсан. Хуулийн 9 дүгээр зүйлд дэд бүтэц, орон сууц, олон нийтийн газар саадгүй чөлөөт орчин бүрдүүлэх талаар төрөөс хүлээх үүргийг тодорхойлж, авто зам, хучилт, замын байгууламжийн үндэсний стандартыг боловсруулахыг үүрэг болгосон. Гэвч хуулийн зохицуулалт хэрэгжээгүй. Тухайлбал, нийтийн тээврийн хэрэгсэл, автобус, нийтийн үйлчилгээний байгууллагуудын авто зогсоол, автобусны зогсоол зэрэг нь ХБХ-ий онцлог хэрэгцээг хангахгүй байна.

ХБХ-д зориулсан хөрөнгө оруулалт, тохижилт нийслэлийн хэмжээнд илүү хийгдэж байгаа бол орон нутагт хэрэгжилт



⁴⁰“Нийтийн тээврийн хэрэгслийн зогсоолд тавих ерөнхий шаардлага. 2022 он. Эх сурвалж: https://inspection.ub.gov.mn/include/standards/27.%20UCS%201601B_Нийтийн%20тээврийн%20хэрэгслийн%20зогсоолд%20тавих%20ерөнхий%20шаардлага.pdf

хангалтгүй байна. Үүнд хөгжлийн бэрхшээлийн хандлага төлөвшөөгүй, санхүүжилт хангалтгүй гэсэн үндсэн 2 шалтгаан нөлөөлж байна. Нийслэл Улаанбаатар хотын хувьд Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах нийслэлийн салбар зөвлөлийн ажлын төлөвлөгөөнд дэд бүтэц, нийтийн тээврийн хүртээмжийг сайжруулах, шинээр оруулж ирэх автобуснууд хөгжлийн бэрхшээлтэй иргэнд ээлтэй байх шаардлага хангах, мөн явган хүний замын хүртээмжийг сайжруулан, хөтөч хавтан, орц гарцын налуу стандартыг хангах, өргөтгөх, тохижилт, бүтээн байгуулалт хийх зэрэг иргэдээс гаргасан саналыг тусгадаг. Гэхдээ хэрэгжилт хангалтгүй, хотын төв хэсэгт л эдгээр өөрчлөлтүүд бага багаар хийгдэж байна. Тодруулбал, нийслэлийн нийтийн тээврийн үйлчилгээнд шинээр худалдан авах автобусны техникийн үзүүлэлтэд “хөгжлийн бэрхшээлтэй иргэд зорчих нэмэлт тоноглолтой байх” шаардлагыг 2015 оноос хойших худалдан авалтад тавьж байгаа боловч 2024 онд өдөр тутам үйлчилж байгаа 1020 тээврийн хэрэгслийн 40.8 хувь буюу 417 автобус ХБХ-д зориулсан налуу тавцантай болсон ч хөдөлгөөний эрчим, автобусны ачаалал зэргээс шалтгаалан налуу хавтанг ихэвчлэн ашиглах боломжгүй байна.

Дээрхээс харахад нийтийн тээврийн үйлчилгээг ХБХ-д хүртээмжтэй болгох гэсэн оролдлого 2015 оноос эхэлсэн ч 10 жилийн хугацаанд нийт нийтийн тээврийн хэрэгслийн 10% л хүртээмжтэй болсон нь тэд бусдын адил ажиллаж, сурч, нийгмийн амьдралд ороход хангалттай эсэх, ид ачааллын үед ч зорчих боломжтой эсэх, жолоочийн хандлагаас хамаарч ХБХ зориулалтын тавцан ашиглан автобусанд суух эсэх нь асуудал хэвээр байна. Тухайлбал, Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн ерөнхий газар (цаашид ХБХЕГ гэх), Түгээмэл хөгжил төв хамтран нийслэлийн төв зам, хотын захын хорооллын чиглэлийн 23 автобусны буудалд 5-н үзүүлэлтийн хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй хүний зорчих, үйлчлүүлэх боломж нөхцөлийн хүртээмжийн үнэлгээ 2019 онд хийсэн. Үнэлгээгээр эдгээр буудлуудын 5-н үзүүлэлтийн 2-3 нь стандарт хангасан байхад үлдсэн хэсэг нь стандарт бус байж бүрэн стандарт зогсоол байхгүй байсан. Автобусны буудлын үзүүлэлт бүрийг өөр байгууллага хариуцан барьсан, өөр хүмүүс хариуцах, санхүүжилт тогтмол бус зэрэг шалтгаанаас болдог гэсэн дүгнэлтэд хүрсэн байв. Энэ нөхцөл байдал хот хоорондын тээврийн хэмжээнд илүү хүндрэлтэй байна.

Нийтийн тээврийн үйлчилгээний саадгүй байдал, хүртээмжийн асуудлыг ерөнхийдөө Улаанбаатар хотын нийтийн тээврийн үйлчилгээгээр хязгаарлаж ойлгох нь өрөөсгөл юм. Учир нь нийтийн тээврийн үйлчилгээний бусад төрөл болох аймаг, сумын төв дэх нийтийн тээвэр, такси, төмөр замын, хот хоорондын үйлчилгээ, агаарын тээврийн үйлчилгээ зэрэг уламжлалт тээврийн хэрэгслээс гадна шинэ тутам нэвтрүүлэхээр зорьж буй дүүжин тээвэр, трамвай зэргийг ХБХ-д хүртээмжтэй болгох тухай зохицуулалт үгүйлэгдэж байна.

Мөн нийтийн тээврийн салшгүй нэг хэсэг болох нийтийн үйлчилгээний байгууллагуудын автомашины зогсоол, автобусны зогсоол зэрэг нь ХБХ-ий онцлог хэрэгцээг хангахгүй, хүртээмжгүй байна. Мөн ХБХ-д зориулсан хөрөнгө оруулалт, тохижилт нийслэлийн хэмжээнд илүү хийгдэж байгаа бол орон нутагт хэрэгжилт хангалтгүй байна. Үүнд хөгжлийн бэрхшээлийн хандлага төлөвшөөгүй, санхүүжилт хангалтгүй гэсэн үндсэн 2 шалтгаан нөлөөлж байна. Нийслэл хотын хувьд Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийг хангах нийслэлийн салбар зөвлөлийн ажлын төлөвлөгөөнд дэд бүтэц, нийтийн тээврийн хүртээмжийг сайжруулах, шинээр оруулж ирэх автобуснууд хөгжлийн бэрхшээлтэй иргэнд ээлтэй байх шаардлага хангах, мөн явган хүний замын хүртээмжийг сайжруулан, хөтөч хавтан, орц гарцын налуу стандартыг хангах, өргөтгөх, тохижилт, бүтээн байгуулалт хийх зэрэг иргэдээс гаргасан саналыг тусгадаг. Гэхдээ эдгээр ажлууд зөвхөн хотын төв хэсэгт бага багаар хийгдэж байна. Тодруулбал,

нийслэлийн нийтийн тээврийн үйлчилгээнд шинээр худалдан авах автобусны техникийн үзүүлэлтэд “хөгжлийн бэрхшээлтэй иргэд зорчих нэмэлт тоноглолтой байх” шаардлагыг 2015 оноос хойших худалдан авалтад тавьж байгаа боловч 2024 он хүртэл хотод өдөр тутам үйлчилж байгаа 1020 тээврийн хэрэгслийн 40.8 хувь буюу 417 автобус хөгжлийн бэрхшээлтэй иргэнд зориулсан налуу тавцантай болсон. Харин хөдөлгөөний эрчим, автобусны ачаалал зэргээс шалтгаалан налуу хавтанг ихэвчлэн ашиглах боломжгүй байна. Тэгвэл зам, талбайд үүссэн эвдрэл, гэмтэл, тогтсон ус, цас, мөсний асуудлаас гадна замын хашлаганы буруу төлөвлөлт ХБХ төдийгүй, эрүүл саруул хүнд ч бэрхшээл үүсгэж байна. Төрөөс хэрэгжүүлэх арга хэмжээ хангалтгүй байхаас гадна иргэдийн дунд ХБХ-нд олон нийтийн газар тулгамдаж буй асуудлын талаар ойлголт, мэдлэг дутмаг, зарим тохиолдолд ухамсар, хүн чанар үгүйлэгдэж байгаагаас шалтгаалан ХБХ-ий эрх зөрчигдөж байна.

ХБХ-ий эрхийг хангах чиглэлээр эрх зүйн орчныг боловсонгуй болгох арга хэмжээг авч байгаа ч төсөв санхүүжилтийг тодорхой тусгадаггүй, шаардлагатай журам, аргачлал зэрэг хуулийн хэрэгжилтийг бүрэн хангуулахад чиглэсэн эрх зүйн актуудыг боловсруулах батлуулах ажил удаашралтай байдаг, төрийн захиргааны байгууллагууд үйл ажиллагаагаа уялдуулдаггүй зэргээс шалтгаалан хэрэгжилт хангалтгүй байна. Иймээс саадгүй байдал, хүртээмжийн асуудлыг нэгтгэсэн эрх зүйн орчныг бий болгох шаардлагатай гэж үзэж байна.

1.3. Хэрэгжилт: Хүртээмжтэй үйлчилгээ

ХБХ-ий эрхийг хангахад хүртээмжийн асуудал нэн чухал бөгөөд хүртээмжтэй байдал гэдэгт физик орчны, харилцаа холбоо, мэдээллийн, цахим үйлчилгээ, мэдээллийн технологийн болон уламжлалт нийгмийн үйлчилгээний, хөдөлмөр эрхлэлтийн гээд олон салбар хамаарна. Эдгээрийн дундаас мэдээлэл, үйлчилгээний хүртээмжтэй байдал нэн чухал. ХБХ-ий мэдээлэл хүлээн авах, технологи ашиглахад тулгардаг асуудлуудыг шийдвэрлэснээр тэдний сурч боловсрох, хөдөлмөрлөх, эрүүл мэндээ хамгаалах зэрэг суурь эрхийг хангахаас гадна цаг үетэйгээ, бусадтай эн зэрэгцэх боломж олгож амьдралын чанарыг сайжруулах боломжтой.⁴¹

Хүртээмжтэй байдал бол ХБХ-ий оролцоог нэмэгдүүлэх “сонголт биш эрх” бөгөөд оролцоо, тэгш эрхийг хангаснаар ХБХ-ий нэр төр, нийгэмд эзлэх байр суурийг бэхжүүлэх, шийдвэр гаргах эрх чөлөөг бататгах асуудал юм. Иймээс хүний ялгаатай байдлаас үл хамаарч төрийн болон хувийн хэвшлийн аж ахуйн нэгж байгууллагаас үзүүлж буй аливаа үйлчилгээ хүн бүрт хүртээмжтэй байх нь хүний эрхийг хангах суурь үзүүлэлт гэж үзнэ.

Иймээс хүртээмжийн асуудлыг мэдээллийн технологи, харилцаа холбоо буюу цахим үйлчилгээний хүртээмж, биечлэн үзүүлэх үйлчилгээний хүртээмж, үйлчилгээ үзүүлэхэд хэрэглэгдэж буй бүтээгдэхүүн, програм хангамжийн хүртээмж гэж үндсэн 3 бүлэгт хуваан үзэж нөхцөл байдлыг тандан судаллаа.

1.3.1. Үйлчилгээний хүртээмж: Мэдээллийн технологи, харилцаа холбоо

⁴¹ Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Хүн амын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хүртээмжийн асуудал хариуцсан мэргэжилтэн З.Мөнгөнцоож

Дэлхий нийтээр техник технологийн хөгжилд нийцүүлэн хил хязгааргүй үйлчилгээ авах/үзүүлэх боломжууд бий болсон нь уламжлалт мэдээллийн технологи, харилцаа холбооны үйлчилгээний төрлүүдээс гадна цахим үйлчилгээний хүртээмжийн асуудлыг хөндөх шалтгаан болж байна. Олон улсын хэмжээнд ч энэ чиглэлд анхаарч, тухайлбал Европын холбооны гишүүн орнуудын хэмжээнд ХБХ-ий дотоодын болон хилийн чанадад бүтээгдэхүүн, үйлчилгээнд тэгш, саадгүй, хүртээмжтэй байх эрхийг хангах зорилготой Европын Холбооны хууль болох Европын Хүртээмжийн тухай хууль (Directive (EU) 2019/882 — European Accessibility Act⁴²)-ийг 2019 оны 4-р сарын 17-нд баталсан бөгөөд бүх гишүүн орнууд 2025 оны зургадугаар сар гэхэд уг хуулийг дотоодын хууль тогтоомждоо нэвтрүүлэх үүрэг хүлээсэн. Уг хуулиар компьютер, гар утас, цахим ном уншигч төхөөрөмж, банкны автомат, карт уншигч төхөөрөмж, вэбсайт болон гар утасны аппликейшнүүд, цахим худалдаа, тээврийн үйлчилгээний мэдээлэл (тасалбарын автомат, цахим үйлчилгээ гэх мэт), онцгой хэрэглээний онцлог бүхий бүтээгдэхүүн, үйлчилгээг ХБХ-нд хүртээмжтэй болгох асуудлыг тусгасан байна. Энэхүү хуулийг боловсруулахдаа ЕХ-ны -ны Комиссын захиалгаар 2019 онд гүйцэтгсэн вэб хүртээмжийн заалтыг гишүүн орнуудад хэрхэн хэрэгжиж байгааг судалж, холбогдох талуудын оролцоог тодорхойлох зорилготой “Study on the implementation of the European Accessibility Act and Web Accessibility Directive” (2019)⁴³ судалгаанд үндэслэжээ.

Манай улсын хувьд ХБХЭтХ, Өргөн нэвтрүүлгийн тухай⁴⁴ хууль, Олон нийтийн радио, телевизийн тухай⁴⁵ хууль, Харилцаа холбооны тухай⁴⁶ хуульд ХБХ-ийн онцлог хэрэгцээг хангахуйц мэдээ, мэдээллийн агуулга, төрөлд илүүтэй анхаарч “мэдээллийн хүртээмж”-тэй байх тухай заасан байна. Мөн 2012 онд УИХ-аас “Цахим засаг” үндэсний хөтөлбөрийг баталж хэрэгжүүлж байна.

ХБХ-нд зориулсан харилцаа холбооны салбарын хүртээмжтэй байдлын тухайд ХБХЭТХ-ийн 11 дүгээр зүйлийн 11.2-т хуулийн этгээд ХБХ-ий мэдээлэл авах эрх, харилцаа холбооны үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлээр 1/төрийн байгууллагын цахим хуудас хөгжлийн бэрхшээлтэй хүн мэдээллийг чөлөөтэй авах боломжийг бий болгох, 2/ ХБХ-нд зориулсан компьютерын дэлгэц дээрх бичгэн мэдээллийг дуу авиа руу хөрвүүлэн хувиргах дэлгэц уншигч, программ хангамж болон шинэ технологи, систем, тусгай хэрэглээний тоног төхөөрөмжийг хөгжүүлэх, хэрэглээнд нэвтрүүлэх, тэдгээрийг эх хэл дээрээ ашиглах боломжийг бий болгох, 3/ хараа, сонсголын бэрхшээлтэй хүмүүст мэдээлэл хүргэх зорилгоор байгуулагдсан ашгийн бус радио, телевизийг төрөөс дэмжих зэрэг зохицуулалт тусгагдсан. Гэвч 2025 оны 1 дүгээр сарын байдлаар МУ-ын ЗГ-ын харьяа 14 яамны цахим хуудас⁴⁷ харааны бэрхшээлтэй иргэдэд хүртээмжгүй байгаа бол олон нийтийн хэвлэл мэдээллийн цахим хуудаснууд мөн адил хүртээмжгүй байна. Тухайлбал, Монцамэ, news.mn, gogo.mn зэрэг 10 мэдээллийн цахим хуудаснаас харааны болон сонсголын бэрхшээлтэй хүн мэдээлэл авах боломжгүй байна. Харин төрийн үйлчилгээний цахим системүүдээс e-mongolia, боловсролын байгууллагуудаас Монгол улсын их сургуулиас бусад нь хүртээмжгүй байгаа нь ХБХ-ий төрийн үйлчилгээ авах эрхийг хязгаарласан, хэн нэгнээс хараат байх, мэдээллийн нууц алдагдах нөхцөлийг бүрдүүлж байна.

⁴² [Directive - 2019/882 - EN - EUR-Lex](#)

⁴³ [reddit.com+9en.wikipedia.org+9deloitte.com+9accessible-eu-centre.ec.europa.eu](#)

⁴⁴ Өргөн нэвтрүүлгийн тухай хууль. Эх сурвалж: <https://legalinfo.mn/mn/detail/15067>

⁴⁵ Олон нийтийн радио, телевизийн тухай хууль. Эх сурвалж: <https://legalinfo.mn/mn/detail/424>

⁴⁶ Харилцаа холбооны тухай хууль. Эх сурвалж: <https://legalinfo.mn/mn/detail?lawId=523>

⁴⁷ Яамдын цахим хуудасны хүртээмжтэй байдлыг <https://mongolia.gov.mn/холбооцоо> орж шалгасан.

ХБХ-ий нийгэм, соёлын эрхийг хангахтай холбоотой Олон нийтийн радио, телевизийн тухай хуульд олон нийтийн радио, телевиз нь нийгмийн цөөнх, эмэгтэйчүүд, хүүхдүүд, хөгжлийн бэрхшээлтэй иргэд зэрэг нийгмийн бүлэг, давхарга, хамт олны хэрэгцээг тэнцвэржүүлэх бодлого баримтлах, нэвтрүүлгийн талаар зөвлөгөө өгөх орон тооны бус зөвлөл байгуулах талаар, Сонгуулийн тухай хуульд сонгуулийн насны харааны бэрхшээлтэй сонгогчдын саналын хуудсыг унших, тэмдэглэх тусгай брайль хавтас нь санал авах байр тус бүрт нэг байхаар заасан байна. Харин Номын сангийн тухай хуульд “тусгай бүлгийн уншигч” болох өндөр настан, өвчтэй, хөгжлийн бэрхшээлтэй иргэд номын сангаар үйлчлүүлэх боломжгүй бол гэрээр үйлчилгээ авах нөхцөлийг хангахаар заасан. Эдгээр хууль тогтоомжийн хэрэгжилтийг үнэлээгүй учир хуулийн зохицуулалт хэр үр дүнтэй, түгээмэл хэрэглэгдэж байгаа талаар мэдээлэлгүй байна.

Үнэлгээний хүрээнд судалсан хууль тогтоомжоос харахад төрийн бодлого, хууль тогтоомжид заасан „хүртээмжтэй байдал” нь хүн бүрийн хэрэгцээнд нийцсэн байдлаар үйлчилгээ хүргэх „төрөл, хэлбэр”-ийг заахаас илүүтэй, газарзүйн байршлын хувьд „хаанаас ч авч болох” байдлыг чухалчилж, цахим харилцаа холбооны хэрэгслээр дамжуулан сургалт, арга хэмжээ зохион байгуулахад илүү чиглэжээ.

Иймээс холбогдох хууль тогтоомжийн зорилтууд нь хууль батлагдсанаас хойшхи 20 гаруй жилийн хугацаанд тодорхой хэмжээнд биелэгдсэн гэж үзэж болох тул үйлчилгээний хүртээмжийн талаарх ойлголтыг шинэ шатанд гаргаж „хүн бүрт хүртээмжтэй” байдлаар хүргэх буюу мэдээлэл харилцаа холбооны бүтээгдэхүүн, үйлчилгээний хүртээмжтэй байдалд тавигдах шаардлагыг тодорхойлж зарчмын өөрчлөлт хийх шаардлагатай гэж үзэж байна. Тухайлбал, Харилцаа холбооны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.21 дэх заалтад “үйлчилгээний хүртээмж” гэж чанар, стандартын шаардлага хангасан харилцаа холбооны сүлжээ, үйлчилгээний төрлийг ойлгоно гэж заасан. Үүнээс харахад мэдээллийг хүртээмжтэй хүргэх асуудал төрлүүдээр хязгаарлагдаж зорилтот бүлэгт хүргэх хэлбэр, тухайлбал ямар туслах технологи, програм хангамжаар, дэмжлэг, тэмдэг, тэмдэглэгээгээр дамжуулан хүртээмжийг нэмэгдүүлэх зэрэг асуудал зохицуулалтгүй байна.

1.3.2. Бүтээгдэхүүн, үйлчилгээний хүртээмжийн тухайд

Өнөө цагийн мэдээлэл, харилцаа холбооны гол хэрэгсэл интернэтэд/вебэд суурилсан эсхүл бусад хэлбэрээр үзүүлж буй цахим үйлчилгээ болж байгаатай холбогдуулан цахим болон зайнаас үзүүлэх үйлчилгээнд ашиглагдах биет болон биет бус бүтээгдэхүүн, үйлчилгээний үйлдвэрлэл, хөгжүүлэлт, худалдаа, үйлчилгээ, импортод тавих шаардлагыг тодорхойлох нь зүйтэй юм. Ингэснээр тусгай хэрэгцээт иргэдэд тухайлбал, харааны бэрхшээлтэй хүмүүст зориулсан дэлгэц уншигчтай нийцтэй байх, өндөр контраст, уншихад хялбар фонтогтой байх, сонсголын бэрхшээлтэй хүний хувьд дуу, дүрсний контентод тайлбар, хадмал орчуулгатайгаар уншиж, танилцах боломжийг бүрдүүлэх боломжтой.

Дээр дурдсан мэдээлэл солилцох нөхцөлийг бүрдүүлэх нь ХБХ эрүүл мэнд, боловсрол, хөдөлмөр эрхлэлтээс гадна улс төр, эдийн засаг, нийгмийн асуудлаарх мэдээллийг цаг тухайд нь олж танилцах боломжийг олгож хүртээмжийг нэмэгдүүлэх замаар хувь хүний хөгжил, амьдралын чанарыг дээшлүүлэх боломжтой ба ХБХ боловсрол, соёл, шинжлэх ухаан, эрүүл мэнд, урлаг, шашин, соёл, хүрээлэн буй орчин, спортын нэвтрүүлгүүдийг хүртээмжтэй хэлбэрээр авч чадахгүй байгаа байдалд эерэг өөрчлөлт гарна гэж үзэж байна.

ХБХ бусдын нэгэн адил суурь эрхээ эдлэхэд мэдээллийн хүртээмжтэй байдал нэн чухал бөгөөд өөрт шаардлагатай мэдээллээ онцлогтоо нийцсэн байдлаар бусдын тусалцаагүйгээр авах нь түүний туйлын зорилго болох бие даан амьдрах, шийдвэр гаргах эрхээ хэрэгжүүлэх үндсэн хэрэгсэл гэж үзэж болно. Иймээс аливаа бүтээгдэхүүн, үйлчилгээ, програм хангамжийг анхлан бий болгохдоо аль болох ХБХ-ий ялгаатай байдалд нийцүүлдэг байх асуудал хөндөгдөж байна. Мөн аливаа үйлчилгээ хүртээмжгүй байхад үйлчилгээ үзүүлж буй төрөл, хэлбэр, арга зүй, техник, тоног төхөөрөмж хангалттай байлаа ч мэргэшсэн хүний нөөцийн дутагдлаас шалтгаалан үр дүнгүй болох эрсдэлтэй тул хүний нөөцийн асуудалд зайлшгүй анхаарах нь зүйтэй юм. Үүний жишээг төр иргэнийхээ өмнө хүлээсэн үүргээ хэрэгжүүлээгүйгээс буюу ХБХ-ий сурч боловсрох, эрүүл мэндээ хамгаалуулах, хөдөлмөрлөх эрх хүртээмжгүй байдлаас шалтгаалсан үр дагаврыг цөөн жишээн дээр харуулахыг зорьлоо.

Боловсролын салбарын хүртээмжтэй хүртээмжтэй холбогдох зарим асуудал

Монгол Улсад хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн тоог 2020-2024 оны байдлаар авч үзвэл 2020 онд 106,400 хүн, 2022 онд 115,000 хүн, 2024 онд 111,200 хүн бүртгэгдэж нийт хүн амын 3.4-4 хувийг эзэлж байна⁴⁸. 2020 оны хүн амын тооллогын дүнгээс⁴⁹ харахад хөгжлийн бэрхшээлтэй 4 хүн тутмын 1 нь боловсролгүй байгаа ба хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн 21,6 хувь нь бага боловсрол эзэмшиж байгаа ч шатлал ахих тусам энэ тоо буурч дээд боловсролыг 6,7 хувь нь эзэмшсэн байдаг.

ХБХ-ий сурч боловсрох эрхийн хэрэгжилтэд сөргөөр нөлөөлж буй хүчин зүйлсийг 1/Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдэд сургалтын орчин хүртээмжгүй, 2/ Дээд боловсрол эзэмших боломж хязгаарлагдмал, хүртээмжтэй сургалтын хөтөлбөр, дэмжлэг дутмаг, 3/ Харааны, сонсголын болон оюуны бэрхшээлтэй хүнд зориулсан хичээл заах арга зүй, багш хангалтгүй, 4/ Тусгай хэрэгцээт боловсролын сургалтын материал хомс зэрэг хэд хэдэн хүчин зүйлийг нэрлэж болно.

Эдгээр хүртээмжгүй байдлыг үүсгэж буй хүчин зүйлс нь хот, хөдөөгийн ялгаа, хөгжлийн бэрхшээлийн төрлөөс хамааран өөр өөр байх ба хөдөөд хотоос илүү, оюуны болон хараа, сонсголын бэрхшээлтэй хүн тулгуур эрхтний бэрхшээлтэй хүнд илүү нөлөөлж байна. Тухайлбал, боловсрол эзэмшиж буй ХБХ-ийг хөгжлийн бэрхшээлээр нь авч үзвэл хөдөлгөөний болон сонсголын бэрхшээлтэй хүний 50-иас дээш хувь нь тодорхой түвшний боловсрол эзэмшиж байгаа бол оюуны бэрхшээлтэй иргэдийн 70 гаруй, харааны бэрхшээлтэй ХБХ-ий 55 гаруй хувь нь боловсрол эзэмшээгүй⁵⁰, боловсролын хүртээмж төвөөс алслагдах тусам буурч байна.⁵¹ ЕБС-д суралцаж буй хөгжлийн бэрхшээлтэй суралцагчийн тоо жил бүр буурч байгаа нь сургалтын байгууллагын хүртээмжгүй байдал, сургалтын хөтөлбөр, багш, мэргэжилтний арга зүй зэрэг олон зүйлээс шалтгаалж байгааг, тухайлбал, сургуулийн өмнөх боловсролын байгууллагад улсын хэмжээнд тусгай хэрэгцээт боловсролын 7 багш⁵² байгаагаас, Монгол Улсад улсын хэмжээнд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдэд зориулсан тусгай сургалттай долоон

⁴⁸ 1212.mn

⁴⁹ ХҮН АМ, ОРОН СУУЦНЫ 2020 ОНЫ УЛСЫН ЭЭЛЖИТ ТООЛЛОГЫН НИЙСЛЭЛИЙН НЭГДСЭН ДҮН Эх сурвалж: https://www2.1212.mn/BookLibraryDownload.ashx?url=1.Summary%20report_Ulaanbaatar.pdf&In=Mn

⁵⁰ Монгол Улсын боловсролын суурь мэдээллийн тайлан

⁵¹ ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦДАГ ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ СУРАЛЦАГЧИД, БҮС, АЙМАГ, НИЙСЛЭЛЭЭР

⁵² *Боловсролын яам, сургуулийн өмнөх боловсролын 2024-2025 оны хичээлийн жилийн статистик тайлан. Эх сурвалж: БОЛОВСРОЛЫН ЕРӨНХИЙ ГАЗАР*

сургуульд мэргэшсэн багш нар тусгай хэрэгцээт хөтөлбөрийн дагуу боловсрол эзэмшүүлдэг⁵³, сургуулийн орчинд сурах боломжгүй ХБХ сургалтад хамрагдаж чаддаггүй зэргээс харж болно. Статистик мэдээллээс харахад 2013 оноос 2025 он хүртэл тусгай хэрэгцээт боловсролын нийт 200 оюутан МУБИС-ийг 3.5 жилийн бакалаврын болон 1 жилийн хөрвөх сургалтаар төгссөн⁵⁴ нь хүний нөөцийн хомстол ямар түвшинд байгааг харуулна.

УИХ-аас 2023 онд баталсан Боловсролын багц хуулиудад тусгаж өгсөн тэгш хамруулан сургах бодлого нь хүн бүрийг боловсролд тэгш хамруулах зорилготой боловч хэрэгжүүлэх багшлах боловсон хүчин бэлтгэгдээгүй нь боловсролын хүртээмжийг бууруулах, үр дүн багатай байх шалтгаан болж байна. Үүний нэг жишээ бол 29 дүгээр тусгай сургуульд суралцаж буй хүүхдүүд дохионы хэлний мэргэжлийн багш, мэргэжилтний хомстол, хүртээмжгүй байдлаас шалтгаалан зохих түвшний боловсрол эзэмшиж чадахгүй хохирч буй асуудал юм Энэ нөхцөл байдал харааны болон оюуны бэрхшлэлтэй хүүхдүүдийн хувьд ч мөн адил байх бөгөөд тэдний онцлог хэрэгцээнд нийцсэн ном, сурах бичиг, хэрэглэгдэхүүн цөөн, тэдгээрийг боловсронгуй болгох асуудал удаашралтай байдаг зэргээс шалтгаалан эдгээр хүүхдүүд эзэмших ёстой мэдлэгээ бүрэн дүүрэн олж авч чадахгүйд хүргэдэг.

Үүнээс харахад хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн боловсролд хамрагдалт бага, сургууль завсардалт өндөр, боловсролын хүртээмж хөдөө орон нутагт хоттой харьцуулахад бага, тусгай хэрэгцээт боловсролын сургалтын материал, орчин хомс, дээд боловсрол эзэмших боломж хязгаарлагдмал байгаа нь ХБХ-ий сурч боловсрох эрхийг зөрчих, ямар бэрхшээлтэй эсэхээс хамааран давхар ялгаварлан гадуурхалтад өртөх, цаашлаад хөдөлмөр эрхлэлт, амьдралын чанар зэрэг дараа дараагийн нийгмийн хамгааллын асуудалд сөргөөр нөлөөлж байна.

Эрүүл мэндийн салбарын хүртээмжтэй холбогдох зарим асуудал

Хөгжлийн бэрхшээлтэй хүний байнга үйлчлүүлдэг эрүүл мэндийн байгууллагын үйлчилгээний хүртээмжгүй байдал ХБХ-нд чирэгдэл, хүндрэл үүсгэж, бусдын нэгэн адил хялбар аргаар үйлчилгээний талаар мэдээлэл авах боломжийг хааж байдаг. Тухайлбал, харааны болон сонсголын бэрхшээлтэй хүн үзлэгийн цаг олгох, ямар үйлчилгээ авах талаар мэдээлэл авахад хүндрэлтэй, угтах үйлчилгээний ажилтан тусгай хэрэгцээт хүнтэй харилцах наад захын мэдлэггүйгээс мэдээллээр бүрэн хангаж чадахгүй байх зэрэг асуудал үүсдэг.

Хүн бүр Үндсэн хуульд заасны дагуу эрүүл мэндээ хамгаалуулах эрхтэй бөгөөд төр иргэнийхээ, ялангуяа тусгай хэрэгцээт иргэдэд шаардлагатай эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг цаг алдалгүй, чанартай хүргэх үүрэгтэй. ХБХ Монгол Улсын Үндсэн хууль болон нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенцод заасан эдийн засаг, оршин суугаа газар зэргээс үл хамааран эрүүл мэндийн чанартай, хүртээмжтэй тусламж, үйлчилгээг эрх тэгш авах нөхцөлийг бүрдүүлэхэд тулгарч буй асуудал боловсролын салбарын нэгэн адил ХБХ-нд барилга байгууламж, үйлчилгээний төрөл, хэлбэр, мэргэжлийн хүний нөөцийн дутагдал, санхүүжилт, тээвэрлэлт, хангамжаас шалтгаалан хүртээмжгүй байна. Тухайлбал, ХБХ-ий хамгийн ихээр үйлчилгээ авдаг эрүүл мэндийн байгууллагуудын хэмжээнд 2018 онд ХЭҮК-оос хийсэн

⁵³ Тусгай хэрэгцээт хүүхдүүд оршихын тулд биш хөгжихийн тулд амьдардаг. Эх сурвалж: <https://gogo.mn/r/191y2>

⁵⁴ Тусгай хэрэгцээт боловсролын багш нарыг бэлтгэж байна

“Эрүүл мэндийн салбар дахь хүний эрхийн хэрэгжилтэд хийсэн үнэлгээний тайлан⁵⁵”-д дурдсанаар “нийслэлийн хэмжээнд судалгаанд хамрагдсан 9 өрхийн эрүүл мэндийн төвийн барилгуудад сүүлд шинээр бий болгосон тэргэнцэртэй хүнд зориулсан налуу зам стандартын шаардлага хангахгүй, мөн эрүүл мэндийн төв хүртэлх замд хашлага, босго, шон, бродюрь их байх боловч хараагүй иргэд зориулсан тусгай тэмдэглэгээтэй замгүй байгаа нь гадаад орчны хамгийн том бэрхшээл байна. ... Харин үнэлгээнд хамрагдсан аймаг, сумын нэгдсэн эмнэлэг, БОЭТ, амаржих газруудын гадаад орчны тохижилт ХБХ эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авах боломжийг харьцангуй сайн хангаж өгсөн нь барилга байгууламж анхнаасаа эмнэлгийн зориулалтаар баригдсанаас гадна түүний гадаад, дотоод орчинд зарим өөрчлөлт, өргөтгөл хийх зай талбай хангалттай байсантай холбоотой байв.” гэжээ. Үүнтэй холбоотойгоор хөндөгдөх асуудал бол эрүүл мэндийн байгууллагын барилга байгууламжийн хэмжээ, өрөө тасалгааны хуваарилалтаас шалтгаалан нэг өрөөнд хэд хэдэн эмч үзлэг хийх, эмч мэргэжилтэн ХБХ-ий бэрхшээлийн онцлогт нийцсэн харилцааны ур чадвар, мэдлэг, ашиглаж болох програм хангамж зэрэг дэмжих хэрэгсэл дутмаг зэргээс шалтгаалан хамгийн түрүүнд ХБХ-ий эрүүл мэндийн нууцаа хадгалах, эрүүл мэндийн асуудлаар бие даан шийдвэр гаргах эрх зөрчигдөж, хамгийн түгээмэл тулгардаг бэрхшээлийн нэг болсон.

Эрүүл мэндийн салбарын ХБХ-ий эрүүл мэндийн байдлыг дордуулахгүй байх, амь насанд нь эрсдэл учрахаас урьдчилан сэргийлэх эм, эмийн бэлдмэлийн хангамж, хүртээмж, бүртгэл, нөөц бүрдүүлэлт, үнэ, өртгийг хянах, бүртгэх, хянах тогтолцоо хангалттай ажиллахгүй байгаа нь хот, хөдөөгийн ялгаа ХБХ-нд илүү мэдрэгдэхэд хүргэж байна. Тухайлбал, эмийн түгээлт, ложистикийн хүртээмжгүй байдлаас болж унаж татах өвчтэй хүүхдүүдийн амь насыг аврах үндсэн эмийн хүртээмж орон нутагт хангалтгүй байгаа бол эрүүл мэндийн байгууллага дохионы хэлмэрч, орчуулагч, брайль үсгээр бэлтгэсэн танилцуулга материал хүртээмжгүй байна.

Энд жишээ болгон авсан боловсрол, эрүүл мэндийн салбарт тулгамдаж буй хүртээмжийн асуудал төрийн болон орон нутгийн өмчит байгууллага, хувийн хэвшлийн аж ахуйн нэгжээс тухайлбал, амралт, рашаан сувилал, спорт, биеийн тамир, урлагын үйлчилгээнд ашиглаж буй хэрэгслүүд нь ялгаатай хэрэгцээтэй хүмүүст хүртээмжгүй байгаа нь ХБХ -ээс гадна тэдний ар гэрт эдийн засгийн дарамт, нэмэлт зардал үүсгэж байна.

ХОЁР. АСУУДЛЫН МӨН ЧАНАР, ЦАР ХҮРЭЭ

Хөгжлийн бэрхшээл нь зөвхөн хувь хүний эрүүл мэндийн асуудал бус нийгмийн хүртээмжгүй орчин, сөрөг хандлагаас үүсэх хүчин зүйл болохыг олон улсад хүлээн зөвшөөрч байна. Өөрөөр хэлбэл барилга байгууламж, дэд бүтцийн хүртээмжгүй байдал, хөгжлийн бэрхшээлийн талаарх буруу ойлголт хандлага, оновчтой бус нийгмийн хамгааллын тогтолцоо хөгжлийн бэрхшээлийг бий болгож байгаа тул эдгээр саадыг арилгах нь хөгжлийн бэрхшээлтэй иргэд, өндөр настны хувьд өдөр тутмын нийгмийн амьдралд оролцох, ахуй амьдралаа бусдын адил авч явахад, бусдын адил суурь эрхээ эдэлж боловсрол эзэмших, хөдөлмөр эрхлэх, нийгмийн үйлчилгээнд хамрагдах боломжийг бүрдүүлэхэд онцгой үүрэгтэй.

⁵⁵ ХЭҮК. Эрүүл мэндийн салбар дахь хүний эрхийн хэрэгжилтэд хийсэн үнэлгээний тайлан. 2018 он. Эх сурвалж: <https://lib4u.net/?lib=nhrс&search=Эрүүл+мэндийн+салбар+дахь+хүний+эрхийн+хэрэгжилтэд+хийсэн+үнэлгээний+тайлан>

Манай улсын хувьд газар нутгийн хэмжээ, хүн амын тоо, засаг захиргааны нэгжийн харьяалал, хөдөө, хот суурин газрын ялгаатай хөгжлийн түвшин, түүнийг дагасан хүн амын нягтаршил зэргээс шалтгаалан ХБХ-нд саадгүй, хүртээмжтэй байдлыг бий болгоход тодорхой хүндрэлүүд үүсдэг.

Саадгүй байдал, хүртээмжийн тухай анхдагч хуулийн төслийг боловсруулах хэрэгцээ, шаардлагыг тодорхойлохдоо үндэсний онцлогоос гадна Үндсэн хуулиар баталгаажсан хүний эрхийг хангах, төрийн болон олон нийтэд чиглэсэн үйлчилгээ, түүнд зориулагдсан барилга байгууламж, дэд бүтэц ихэвчлэн хот суурин газар бий болдог тул саадгүй байдал, хүртээмжийн асуудлыг эхний ээлжинд хот, суурийн газрын төлөвлөлттэй холбож үзсэн.

Өнөөдөр хот, суурин газрын архитектурын төлөвлөлт, дэд бүтэц дагасан газар болон барилгын зөвшөөрөл олголт сүүлийн 20 гаруй жилийн хугацаанд албан тушаал, эрх мэдлийн хэмжээнд хэн нэгний ашиг сонирхолд нийцсэн байдлаар шийдэгдэж ирсний үр дагаварт хүнд ээлгүй хотын сонгодог жишээ болсон Улаанбаатар хот үүссэн. Монгол Улсын хэмжээнд аймаг, сумын төвүүдийн хүн амын тоо өсөхийн хэрээр төрийн болон хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар шинээр баригдах барилга байгууламжийн тоо өсөн нэмэгдэж буй энэ үед саадгүй байдал, хүртээмжийн асуудлыг эхнээс нь зөв төлөвлөж шийдэх, холбогдох стандартуудыг мөрдүүлэх замаар хүнд ээлтэй, эмх цэгцтэй хот төлөвлөлтийг төлөвшүүлэх, хувийн эрх ашиг, капиталаас илүү нийтийн эрх ашгийг хамгаалах асуудалд хуулийн төслийн мөн чанар оршино.

Улс орны хөгжил, нийгэм, эдийн засгийн нөхцөл байдалтай уялдан төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх арга хэмжээний дийлэнх хэсгийг дэд бүтэц, боловсролын, эрүүл мэндийн зэрэг төрийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэхэд зарцуулж байна. Тухайлбал, 2023 оны Монгол Улсын нэгдсэн төсвийн төсөлд төсвийн хөрөнгө оруулалтаар нийтдээ 6.9 их наяд төгрөгийн төсөвт өртөг бүхий 2.7 их наяд төгрөгийн санхүүжих дүнтэй 1061 төсөл, арга хэмжээг тусгаснаас 15 нь барилга байгууламжийн төсөл, 66 нь их засвар, 63 нь тоног төхөөрөмж худалдан авах ажил байсан⁵⁶ бол 2024 онд Улсын төсвийн төсвийн 22 хувь нь боловсролын салбарт, 18 хувь нь зам, тээврийн салбарт, 8 хувь нь эрүүл мэндийн салбарт хуваарилагдсан⁵⁷ ба төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих 1,320 төсөл, арга хэмжээнд 3.8 их наяд төгрөг батлагдаж, 3.1 их наяд төгрөгийн санхүүжилтийг олгосон байна. Энэ санхүүжилтийн хүрээнд тус төсвийн жилд нийт 1.4 их наяд төгрөгийн төсөвт өртөг бүхий 430 төсөл, арга хэмжээг бүрэн хэрэгжиж, үүнээс 1.1 их наяд төгрөгийн төсөвт өртөг бүхий 338 барилга, байгууламж ашиглалтад орсон⁵⁸. Харин 2025 онд энэ хэмжээ улам өсөж 4 их наяд төгрөг давсан байна. Төсвийн хөрөнгө оруулалтын 30-40 хувь, дотоодын нийт бүтээгдэхүүний 1-4 хувийг эзэлж, жил бүр өсөн нэмэгдэж буй эдгээр төслүүд үр ашигтай байхаас гадна ХБХ, өндөр настан, хүүхэд гээд зорилтот бүлгийн иргэдэд саадгүй, хүртээмжтэй байх нь чухал билээ.

Саадгүй байдал, хүртээмжийн асуудлын мөн чанар нь Монгол Улсын нийт иргэдийн эрүүл, аюулгүй орчинд төрийн үйлчилгээг саадгүй авах нөхцөлийг хот, хөдөөгийн ялгаагүйгээр

⁵⁶ 2023 онд 1061 төсөл, арга хэмжээ хэрэгжүүлэхээр тусгасны 915 нь БАРИЛГА БАЙГУУЛАМЖ. Эх сурвалж: <https://www.zindaa.mn/4cun>

⁵⁷ ТӨСӨВ-2024: Бодиг орлогыг хамгаалж, орон нутгийн хөгжлийг дэмжинэ. Эх сурвалж: <https://www.montsame.mn/mn/read/333125>

⁵⁸ 2024 онд улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 338 барилга, байгууламжийг ашиглалтад оруулжээ. Эх сурвалж: <https://www.inews.mn/>

Үндсэн хууль болон бусад хууль тогтоомжид заасан эрхээ эдлэхэд шаардагатай наад захын шаардлагыг тодорхойлж, орчин, нөхцөлийг бүрдүүлэх, цаашлаад хүний эрүүл мэнд, амь насанд учирч болох эрсдэлээс хамгаалах, урьдчилан сэргийлэхэд чиглэсэн байхаас гадна улсын болон орон нутгийн төсвийн төлөвлөлт, зарцуулалт, үр дүнд хүргэх ач холбогдолтой юм.

2.1. Эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж буй нийгмийн бүлэг, иргэдийг тодорхойлох

Нийгмийн харилцаанд оролцох идэвх, оролцоог тандсан судалгаанд хамрагдсан хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн 2,36% нь өөрөө оролцох сонирхолгүй, 27,6% нь нийгмийн харилцаа, хандлага, 80,0% нь зам, шат, хаалга, 98% хувь нь тээврийн хэрэгсэл, унаа гэсэн хариулт⁵⁹ өгснөөс ХБХ-ий эрхийн зөрчлийн суурь шалгаан бол орчны саад, хүртээмжгүй байдал болохыг харж болно. Үүнээс харахад ХБХ-ий хувьд орчны саад бэрхшээлүүд нь дэд бүтцийн хүртээмжгүй байдал, хүртээмжгүй нийтийн тээвэр, нийгмийн сөрөг хандлага, хууль тогтоомж дахь хөгжлийн бэрхшээлийн ангилал, туслах технологийн хүрэлцээгүй, мэдээллийн хүртээмжгүй байдал зэргээс хамгийн их шалтгаалдаг байна.⁶⁰

Манай улсад 2004 оноос эхлэн ХБХ-д ээлтэй дэд бүтэц хөгжүүлж, бүх хүн адил тэгш ажиллаж, амьдрах нөхцөлийг бүрдүүлэхэд анхаарч, ХБХ-д хүнд учирч буй орчны буюу зам, тээвэр, барилга байгууламжийн саадыг багасгаж, хүртээмжийг нэмэгдүүлэхтэй холбоотой хууль тогтоомжуудыг боловсронгуй болгож байгаа ба хэрэгжилт ямар түвшинд байгаа талаар энэ хэсэгт судална. Тухайлбал, 2016 оноос яам бүрт Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрхийг хангах дэд зөвлөл байгуулах ажлыг ХНХЯ-наас санаачлан эхлүүлсэн. Яамдын дэргэдэх зөвлөлөөс ирүүлсэн санал, зөвлөмжийг ХНХЯ хагас жил тутам авч хянан, дүн шинжилгээ хийдэг болсон зэрэг дэвшилт гарсан.


Гэвч ХБХ зам, барилга, орон сууц гэхчлэн нийтийн байгууламжид зорчиход орчны саадтай цаг ямагт тулгарч байна. Эдгээр саад, бэрхшээлийг арилгаснаар ХБХ төдийгүй ахмад настан, бага насны хүүхэдтэй хүн гээд бүх иргэн аливаа үйлчилгээг хүртээмжтэй авч, ялгаатай байдал арилах юм. ХБХ орчны саад бэрхшээлээс шалтгаалан бусдаас байнга дэмжлэг авч, тэднээс хараат, нийгмийн идэвхгүй нэгэн болж байгаа нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан орчны дэд бүтцийн асуудал шийдвэрлэгдэхгүй байгаатай, мөн эдгээр иргэдэд үзүүлж буй үйлчилгээний төрөл, хэлбэр, түүнийг үзүүлж буй ажилтан, албан хаагчийн харилцаа, хандлага, ур чадвартай салшгүй холбоотой.

Монгол Улсын хүн амын тоо 2016 оноос 2024 он хүртэл 16,9 хувиар өссөн бол ХБХ-ий тоо 11,7 хувиар өссөн байна. Дээрх тоо мэдээллийг 3 жилийн мөчлөгөөр судалж үзэхэд ХБХ-ий тоо нийт хүн амын 3,1-3,3 хувийг ХБХ эзэлж байгаа ба нийт хүн амд эзлэх ХБХ-ий тоо 2014 онд 3,32 хувь, 2017 онд 3,26 хувь, 2020 онд 3,22 хувь, 2023 онд 3,17 хувь болж буурсан байдал ажиглагдаж байна.

График 8 Хүн амд эзлэх ХБХ-ий тоо, ХБХ-ий тоо 3 жилийн өмнөх дүнтэй харьцуулсан үзүүлэлт (хувиар)


⁵⁹ Д.Сүнжид. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээний тайлан. 2018 он.

⁶⁰ [UB Case Study Publication Package Mongolian version.pdf](#)



ХБХ-ий тоо 2011 онтой харьцуулахад 2014 онд 12,708 хүнээр буюу 14,6 хувь болж өссөн бол 2023 оныг 2020 онтой харьцуулахад 2,829 хүнээр буюу 2,6 хувиар өссөн үзүүлэлттэй байна.


График 9 ХБХ-ий тоо, хөгжлийн бэрхшээлээр



Саадгүй байдал, хүртээмжийн тухай хууль боловсруулагдсан тохиолдолд ХБХ-тэй 112 мянга орчим иргэнээс гадна 0-9 насны 725 мянга гаруй, 65-аас дээш насны 188 мянга орчим иргэн багтахар байна. Үүнээс харахад саадгүй байдал, хүртээмжийн асуудлыг тухайлсан хуулиар зохицуулснаас Монгол Улсын нэг сая гаруй хүний буюу 3 хүн тутмын нэгний эрх ашиг, амьдрах орчныг сайжруулахад нөлөөлөх боломжтой юм.

График 10 ахмад настан, хүүхдийн тоо 2022-2024 он⁶¹

⁶¹ ХҮН АМЫН ТОО, насны бүлэг, хүйсээр. ҮСХ, Эх сурвалж:
https://www2.1212.mn/tables.aspx?tbl_id=DT_NS0_0300_003V1&SEX_select_all=0&SEXSingleSelect=_1&AGE_GRP5_select_all=0&AGE_GROUP5SingleSelect=_2_3_15_16&YearY_select_all=0&YearYSingleSelect=_2024_2023_2022&viewtype=table



Дээрхээс харахад саадгүй байдал, хүртээмжийн тухай хуулийн үйлчлэл нь зөвхөн 112 мянга орчим ХБИ төдийгүй өндөр настан, түр хугацаагаар хөдөлмөрийн чадвараа алдсан хүн, жирэмсэн эмэгтэй, хүүхэд, хүүхдээ түрсэн эцэг эх гээд Монгол Улсын хүн амын 3/1 хувьд шууд хамааралтай байна.

Орчны саадгүй байдлыг бий болгох асуудлыг хуульчилж, холбогдох стандарт, норм, дүрмүүдийг хэрэгжүүлдэг болсноор өмнө дурдсан хүн амд үзүүлэх эерэг нөлөөллөөс гадна хот төлөвлөлтийн зөв хэвшил тогтох, хотын өнгө үзэмж, тав тухтай байдлыг бүрдүүлэхэд нөлөөлөх бөгөөд энэ нь хот суурин газрын бэлгэ тэмдэг мэт болсон шаардлагагүй хөрөнгө оруулалт, сэтгэлгүй гүйцэтгэлд хязгаар тавих боломж олгоно гэж үзэж байна. Ингэснээр улс, орон нутгийн төсвийг үргүй зарцуулах, стандарт шаардлага хангаагүй барилга байгууламж, зам талбайд хөрөнгө оруулдаг, зөрчлөө арилгах зорилгоор дахин хөрөнгө үрдэг байдал хяналттай болох зэргээр төсвийн хэмнэлт үүсгэх боломжтой юм. Мөн олон нийтийн үйлчилгээ, амьдрах орчны тав тухтай байдал бий болсноор алс хэтдээ хүнд ээлгүй улс, хотоос дүрвэж буй залуучуудын тоо буурах, манай улсыг зорин ирж буй гадаадын аялагч, жуулчдын тоо өсөхөд ч нөлөөлөх боломжтой юм.

Үүний бодит жишээ бол Монгол Улсын нийт хүн амын 50 гаруй хувь амьдарч буй Улаанбаатар хот сүүлийн 20-н жилд эрчимтэй тэлэн хөгжих явцдаа хүн бүрт ээлтэй байх, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг саадгүй зорчуулахад тал дээр ямар нэг төлөвлөлтгүй явж ирсэн. Жишээлбэл нийслэлийн хүн амын 60-аас илүү хувь нь гэр хороололд оршин суудаг хэдий ч дэд бүтцийн хүртээмж нь илүү хотын төв хэсэгтээ төвлөрдөг. Гэр хороололд үндсэн дэд бүтцийн хүртээмжгүй байдал, тэгш бус байдал улам өргөжиж, эрүүл мэнд, сайн сайхан байдалд нөлөөлөх, улмаар хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөгжил, нийгмийн оролцоонд асар их бэрхшээлийг үүсгэж байна. Нэг хотын дотор л хүртээмжийн эрс ялгаатай нөхцөл үүссэн нь цогц төлөвлөлтгүй, ойлголт мэдээлэл хангалтгүйг харуулна. Өмнөх нийгмийн үед хөгжлийн бэрхшээлийн талаарх уламжлалт хандлага, хот суурингууд суурилсан ч хөгжлийн явцдаа орчин үеийн технологи, үзэл хандлагаар хот төлөвлөлт барилга архитектурын зохион байгуулалтыг хэрэгжүүлэх шаардлага үүсэж байна. Үүнийг хэрэгжүүлэхэд саадгүй байдал, хүртээмжийн хууль жинтэй хувь нэмэр оруулна.

2.2. Асуудлыг үүсгэж буй шалтгаан нөхцөл

Хөгжлийн бэрхшээлтэй хүний нийгмийн оролцоо, сурч, хөгжих, хөдөлмөрлөх зэрэг суурь эрхийг хангахад чиглэсэн хууль тогтоомжуудаар зохицуулагдаж буй харилцаа, тухайлбал барилга байгууламж, зам тээвэр, дэд бүтцийн саадгүй байдал, уламжлалт болон цахим үйлчилгээний, эдгээр үйлчилгээг үзүүлэхэд ашиглагдах техник, тоног төхөөрөмж, програм хангамж, туслах хэрэгсэл, хүний нөөцийн хүртээмжийн асуудлыг мэргэжлийн салбар бүр өөр өөрийн өнцөг эрх ашгийн үүднээс тайлбарлан хэрэглэж ирсэн нь салбар дундын бодлогоор шийдвэрлэх асуудлыг аль ч шатанд анхаарлаас гадуур үлдээж, холбогдох хууль тогтоомжийг хэрэгжүүлэхгүй, эсхүл дүр эсгэсэн байдлаар хэрэгжүүлэх үндэслэл болжээ.

Энэ судалгааны 1.1 дэх хэсэгт дурдсан саадгүй байдал, хүртээмжтэй холбоотой харилцааг тусгасан Хот байгуулалтын тухай, Барилгын тухай, Сонгуулийн тухай хууль, Автозамын тухай хуулиудад хүртээмжийн асуудлыг ерөнхий байдлаар тусгасан, мөн эл асуудлыг нэг хуульд дунджаар 2-4 заалтад тусгасан, салбар хоорондын уялдаа холбоогүй байдал, асуудлыг нэг нэг салбарын, хуулийн хэмжээнд хэтэрхий ерөнхий тусгаснаас цогц байдлаар хэрэгждэггүй, нийгмийн хандлага хүртээмж, саадгүй байдлын асуудлыг зөвхөн ХБХ-ий асуудал мэтээр хардаг, хяналт, хариуцлагын тогтолцоо сул зэрэг олон хүчин зүйлс хэрэгжилт хангалтгүй, үр дүнгүй байхад нөлөөлж байна гэж үзлээ. Тухайлбал, ХБХЭтХ-д саадгүй байдал, хүртээмжийн асуудлыг бүлэг болгон оруулсан байдаг ч эрхийн тухай суурь хууль учир ямар эрхтэй тухай зааснаас хэрхэн хэрэгжүүлэх талаар маш товч байна. Барилга байгууламж ба явган хүний зам талбай, мэдээллийн технологи ба харилцаа холбоо, үйлчилгээний хүртээмж, эдгээрт хамаарах технологиуд нь өргөн цар хүрээтэй, олон салбарыг хамардаг бөгөөд хүртээмжгүй байдлаас үүсэх сөрөг нөлөө нийгмийн бүхий л салбарт хүрч байна. Жишээлбэл мэдээллийн технологи, харилцаа холбооны асуудал гэхэд бараг бүхий л салбарт хамааралтай ч ХБХ-д хүртээмжтэй байдал нь хэвлэл мэдээллийн хэрэгслээр хязгаарлагддаг зэрэг асуудал байсаар байна.

Дээрхээс харахад саадгүй, хүртээмжтэй байдалд сөргөөр нөлөөлж буй голлох шалтгаануудыг төрийн бодлого, хууль тогтоомжид саадгүй байдал, хүртээмжийн асуудлыг цогц байдлаар бус зөвхөн тухайн салбарын харилцаанд хамаарах асуудлыг ерөнхий байдлаар тусгасан, үүнээс шалтгаалж хэрэгжилт хангагддаггүй, энэ нь хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага, хяналтын тогтолцоо дутагдалтай, хүлээлгэх хариуцлагын хэмжээ бага, хот, суурин газрын төлөвлөлт хүний эрхэд суурилагаас илүү хөрөнгө чинээ, эрх мэдэлд суурилсан, газар олголт, чөлөөлөлт үүнтэй холбоотой ажиллагаа хүний эрхийг хүндэтгэдэггүй, улс, орон нутгийн төсвөөс хүртээмж, саадгүй байдлыг бий болгоход хөрөнгө зарцуулдаггүй, шинээр хөрөнгө оруулж гүйцэтгэж буй ажлууд ч гүйцэтгэлийг чухалчилж стандартыг үл хайхардаг зэрэг тулгамдсан олон асуудал хуулийн төсөл боловсруулах шалтгаан нөхцөлийг бүрдүүлж байна.

ГУРАВ. АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭХ ЗОРИЛГЫГ ТОМЪЁОЛОХ

Монгол Улсын Үндсэн хуульд заасан эрхээ эдлэх боломжийг бүрдүүлж, хүнийг нийгмийн соёл, хэл, үндэс угсаа, нас, хүйс, хөгжлийн бэрхшээл гэх мэт ялгаатай байдлаас үл хамааран нийтийн зориулалттай аливаа бүхнийг ашиглах, оролцох боломжийг хангасан барилгын архитектур, зам талбай, харилцаа холбоо, тоног төхөөрөмж, бүтээгдэхүүн, үйлчилгээ, мэдээллийг хүн бүрт саадгүй орчин, хүртээмжтэй үйлчилгээг бий болгох шаардлагатай. Үндэсний хууль тогтоомжоос гадна Монгол Улсын нэгдэн орж, соёрхон баталсан олон улсын хүний эрхийн

конвенцууд, түүн дотроо 2009 онд нэгдэн орсон ХБХЭК-ийн хэрэгжилтийг хангаж, үндэсний бодлого, үйл ажиллагааг ХБХ-нд ээлтэй болгон шинэчлэн сайжруулах, олон улсын чиг хандлагатай нийцүүлэх, ялангуяа дэд бүтцийн хүртээмж нь аливаа асуудлын суурь тул үүнд хамаарах үйл ажиллагаа, эрх зүйн орчныг шинэчлэх шаардлагатай юм.

Саадгүй байдал, хүртээмжийн тухай анхдагч хуулийг боловсруулах нь ХБХ нийгмийн харилцаанд эрх тэгш оролцох, нийгмийн үйлчилгээ авах, хөдөлмөр эрхлэлт, сурч боловсрох эрхээ эдлэх суурь нөхцөлийг бий болгох, улмаар бусдаас хараат бусаар бие даан амьдрах орчин, нөхцөлийг бүрдүүлэхэд чухал шийдвэр болох юм.

Дээрхээс харахад Саадгүй байдал, хүртээмжийн тухай анхдагч хуулийн үйлчлэл нь нийгмийн хамгааллын салбарт илүү хамааралтай мэт боловч хуулийн зохицуулалт нь нийгмийн бүх салбарыг хамарч, иргэн бүхийн өдөр тутмыг амьдралын тав тух, аюулгүй байдлаас эхлээд улс орны төлөвлөлт, төсөв санхүүжилтийг зохистой байлгахад нөлөөлөх боломжтой байна.

Аргачлалын 4.1-д бичсэнээр зорилгыг аль болох тодорхой, хэмжих боломжтой, хүрэхүйц, бодитой байдлаар томъёолох хэрэгтэй юм. Иймээс “төрийн үйлчилгээ хүн бүрт саадгүй, хүртээмжтэй болгох” гэх зорилгыг тодорхойлсон болно. Бидний тодорхойлсон зорилгын тухайд хөгжлийн бэрхшээлтэй хүнд хүртээмжтэй, саадгүй орчин, нөхцөлийг бүрдүүлэх замаар хүн бүрт эрх, эрх чөлөөгөө эрх тэгш эдлэх боломжийг олгож хүний эрүүл, аюулгүй орчинд амьдрах, сурч хөгжих, ажил хөдөлмөр эрхлэх гээд үндсэн эрхүүдээ хэрэгжүүлэхэд аливаа хүндрэл, бэрхшээл, саадыг арилгах, хүртээмжийг нэмэгдүүлэх төрийн үйл ажиллагаа үр дүнтэй болгох боломжтой байгаа нь зорилготой нийцэж байна.

ДӨРӨВ. АСУУДЛЫГ ЗОХИЦУУЛАХ ХУВИЛБАРУУД, ТЭДГЭЭРИЙН ЭЕРЭГ, СӨРӨГ ТАЛЫГ ХАРЬЦУУЛСАН БАЙДАЛ

Асуудлыг шийдвэрлэх боломжтой хувилбаруудыг тогтоож, Аргачлалын 5-д заасны дагуу зорилгод хүрэх байдал буюу “Хүн бүрт хүртээмжтэй, ээлтэй орчныг бий болгох” зорилгыг хангаж чадах эсэх, зардал, үр өгөөжийн харьцаа буюу хувилбарыг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардал, үзүүлэх эерэг өөрчлөлтийг харьцуулан судалж дараах дүгнэлтийг гаргалаа.

Хүснэгт 1 Хувилбаруудын харьцуулалт

№	Хувилбар	Зорилгод хүрэх байдал	Зардал, үр өгөөжийн харьцаа	Үр дүн
1.	Тэг хувилбар буюу шинээр зохицуулалт хийхээс татгалзах	Одоогийн нөхцөл байдал өөрчлөгдөхгүй, бэрхшээл хэвээр үргэлжилнэ.	Нэмэлт зардал гарахгүй бөгөөд одоогийн зохицуулалтын үр өгөөж хэвээрээ байна.	Үр дүн муутай
2.	Хэвлэл мэдээллийн хэрэгслээр ухуулга сурталчилгаа хийх	Өнөөгийн тулгамдаж буй бэрхшээл хэвээр үргэлжлэх бөгөөд хууль тогтоомж хоорондын уялдаа сайжрахгүй бөгөөд зөрчил арилахгүй.	Зардал тодорхой хэмжээнд гарна. Асуудлыг үүсгэж байгаа гол шалтгааныг арилгахад нөлөөлж, сөрөг үр дагаврыг бууруулж чадахгүй.	Тодорхой үр дүнд хүрэхгүй
3.	Зах зээлийн эдийн засгийн хэрэгслүүдийг ашиглан төрөөс зохицуулалт хийх	Хууль тогтоомжийн хоорондын уялдаа, зөрчлийг эдийн засгийн аргаар зохицуулах боломжгүй.	Зардал шаардагдана. Асуудлыг үүсгэж байгаа гол шалтгааныг арилгахад нөлөөлж, сөрөг үр дагаврыг бууруулж чадахгүй..	Тодорхой үр дүнд хүрэхгүй
4.	Төрөөс санхүүгийн интервенц хийх	Үр дүн муутай, нэг удаагийн шинжиэй төсвийн хөрөнгө үрсэн ажил болно	Зардал өндөртэй, үр ашиг муутай байна.	Тодорхой үр дүнд хүрэхгүй
5.	Төрийн бус байгууллага, хувийн хэвслээр тодорхой чиг үүргийг гүйцэтгүүлэх хувилбар	ТББ төдийлөн бэхжээгүй тул эл асуудлыг хөндөж, кейс судлахаас илүү үр дүн гарахгүй. Одоо ч хувийн хэвслээр гүйцэтгүүлж байгаа ажлууд ХБХ-ий эрхийг хангаагүй, асуудлыг шийдвэрлэж чадаагүй.	Тодорхой хэмжээний зардал гарах ч үр дүн хангалттай бус	Тодорхой үр дүнд хүрэхгүй
6.	Захиргааны шийдвэр гаргах	Саадгүй, хүртээмжтэй орчныг бий болгоход чиглэсэн хууль тогтоомж, дүрэм, журмыг баталж тодорхой асуудлыг шийдвэрлэж буй өнөөгийн тогтолцоо хэрэгжээгүй, шинээр зохицуулалт нэмж болох хэдий ч суурь	Саадгүй байдал, хүртээмжийг нэмэгдүүлэхэд нөлөөлж буй шалтгааныг арилгахад цогцоор нөлөөлж, сөрөг үр дагаврыг бүрэн бууруулж чадахгүй	Тодорхой үр дүнд хүрэхгүй

		зохицуулалт орхигдсон учир асуудлын хоорондын уялдааг хангаж чадахгүй.		
7.	Хууль тогтоомжийн төсөл боловсруулах	ХБХ-ий нийгмийн харилцаанд саадгүй оролцоход тулгамдаж байгаа бэрхшээл, асуудлыг шийдвэрлэх бөгөөд зорилгод хүрэх боломжтой.	Зардал гарах боловч энэ хувилбар нь асуудлыг үүсгэж байгаа гол шалтгааныг шийдвэрлэхэд чухал нөлөө үзүүлэх боломжтой.	Үр дүнтэй

Дээрхээс “Хүн бүрт хүртээмжтэй, ээлтэй орчныг бий болгох” зорилгыг хангах хүрээнд дараах хувилбаруудыг дэвшүүлж байна.

- Хувилбар 0. Саадгүй байдал, хүртээмжийг сайжруулах тухай шинэ зохицуулалт хийхээс татгалзах замаар асуудлыг шийдвэрлэх,
- Хувилбар 1. Саадгүй байдал, хүртээмжийг сайжруулах эрх зүйн орчныг шинэчлэх буюу боловсронгуй болгох замаар асуудлыг шийдвэрлэх.

ТАВ. ЗОХИЦУУЛАЛТЫН ХУВИЛБАРУУДЫН ҮР НӨЛӨӨГ ТАНДАН СУДАЛСАН БАЙДАЛ

Аргачлалын 6-д заасны дагуу өмнөх үе шатанд сонгон авсан хувилбарын үр нөлөөг аргачлалд заасны дагуу хүний эрх, эдийн засаг, нийгэм, байгаль орчинд үзүүлэх үр нөлөөнд шалгуур асуултын ерөнхий асуултуудад хариулах замаар дүгнэлт гаргалаа.

5.1. Хүний эрхэд үзүүлэх үр нөлөө

1. Хүний эрхийн суурь зарчмуудад нийцэж байгаа эсэх

Төрөөс гаргаж буй аливаа шийдвэр нь иргэдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хангах, хамгаалахад чиглэдэг учир асуудлыг зохицуулахаар сонгож буй хувилбар нь хүний эрхийг аливаа хэлбэрээр зөрчсөн, хууль бусаар хязгаарласан байх ёсгүй ба тухайн хувилбарыг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор хүний эрх, эрх чөлөө аливаа хэлбэрээр зөрчигдөх ёсгүй. Иймд үүнийг урьдчилан шалгасан байх шаардлагатай тул энэ хэсэгт шалгах болно. Доорх хүснэгтэд зохицуулалтын хувилбаруудын хүний эрхэд үзүүлэх үр нөлөөг холбогдох асуултын хүрээнд авч үзсэн бөгөөд хариултын тайлбарыг дэлгэрэнгүй байдлаар тусад нь бичсэн болно.

Хүснэгт 2 Хүний эрхэд үзүүлэх үр нөлөө

Үзүүлэх үр нөлөө	Холбогдох асуулт	Хувилбар	Хариулт	Тайлбар
1. Хүний эрхийн суурь зарчмуудад нийцэж байгаа эсэх	1.1. Ялгаварлан гадуурхахгүй ба тэгш байх			
	1.1.1. Ялгаварлан гадуурхахыг хориглох эсэх	Хувилбар 0	Үгүй	Одоогийн нөхцөл байдал өөрчлөгдөхгүй
		Хувилбар 1	Тийм	ХБХ-ийг ялгаварлах байдал буурна
	1.1.2. Ялгаварлан гадуурхсан буюу аль нэг бүлэгт давуу байдал үүсгэх эсэх	Хувилбар 0	Тийм	Эрсдэлтэй
		Хувилбар 1	Үгүй	Нэг бүлэгт давуу байдал үүсгэхээс сэргийлэхэд ач холбогдолтой
	1.1.3. Тодорхой эмзэг бүлгийн нөхцөл байдлыг сайжруулах зорилгоор авч хэрэгжүүлэх арга хэмжээ бол олон улсын болон үндэсний хууль тогтоомжид заасан хүний эрхийн хэм хэмжээтэй нийцэж байгаа эсэх	Хувилбар 0	тийм	Одоогийн нөхцөл байдал өөрчлөгдөхгүй
		Хувилбар 1	тийм	Нийцэж байгаа
	1.2. Оролцоог хангах			
	1.2.1. Зохицуулалтын хувилбарыг сонгохдоо оролцоог хангасан эсэх, ялангуяа эмзэг бүлэг, цөөнхийн оролцоо боломжийг бүрдүүлсэн эсэх	Хувилбар 0	тийм	Одоогийн нөхцөл байдал өөрчлөгдөхгүй
		Хувилбар 1	тийм	Эмзэг бүлэг, цөөнхийн оролцоо нэмэгдэнэ.
	1.2.2. Зохицуулалтыг бий болгосноор эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа, эсхүл хөндөгдөж болзошгүй иргэдийг тодорхойлсон эсэх	Хувилбар 0	тийм	Одоогийн нөхцөл байдал өөрчлөгдөхгүй
		Хувилбар 1	тийм	Монгол Улсын хүн амын 3 хүн тутмын 1-д хамааралтай
	1.3. Хууль дээдлэх зарчим ба сайн засаглал, хариуцлага			
	1.3.1. Зохицуулалтыг бий болгосноор хүний эрхийг хөхиүлэн дэмжих, хангах, хамгаалах явцад ахиц дэвшил гарах эсэх	Хувилбар 0	үгүй	Одоогийн нөхцөл байдал өөрчлөгдөхгүй
		Хувилбар 1	тийм	Хуульд тодорхойлох боломжтой.

	1.3.2.Зохицуулалтын хувилбар нь хүний эрхийн Монгол Улсын олон улсын гэрээ, хүний эрхийг хамгаалах механизмын талаар НҮБ-аас өгсөн зөвлөмжид нийцэж байгаа эсэх	Хувилбар 0	үгүй	Одоогийн нөхцөл байдал өөрчлөгдөхгүй
		Хувилбар 1	тийм	Нийцнэ.
	1.3.3.Хүний эрхийг зөрчигчдөд хүлээлгэх хариуцлагыг тусгах эсэх	Хувилбар 0	үгүй	Одоогийн нөхцөл байдал өөрчлөгдөхгүй
		Хувилбар 1	тийм	Хариуцлагын тогтолцоо сайжирна
2.Хүний эрхийг хязгаарласан зохицуулалт агуулсан эсэх	2.1.Зохицуулалт нь хүний эрхийг хязгаарлах тохиолдолд энэ нь хууль ёсны ашиг сонирхолд нийцсэн эсэх	Хувилбар 0	Үгүй	Одоогийн нөхцөл байдал өөрчлөгдөхгүй
		Хувилбар 1	үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй
	2.2.Хязгаарлалт тогтоох нь зайлшгүй эсэх	Хувилбар 0	үгүй	Одоогийн нөхцөл байдал өөрчлөгдөхгүй
		Хувилбар 1	үгүй	Хязгаарлалт тогтоохгүй
3.Эрх агуулагч	3.1.Зохицуулалтын хувилбарт хамаарах бүлгүүд буюу эрх агуулагчдыг тодорхойлсон эсэх	Хувилбар 0	тийм	Одоогийн нөхцөл байдал өөрчлөгдөхгүй
		Хувилбар 1	тийм	Хуульд тодорхойлох боломжтой
	3.2.Эрх агуулагчдыг эмзэг байдлаар нь ялгаж тодорхойлсон эсэх	Хувилбар 0	тийм	Одоогийн нөхцөл байдал өөрчлөгдөхгүй
		Хувилбар 1	тийм	Хуульд тодорхойлох боломжтой.
	3.3.Зохицуулалтын хувилбар нь энэхүү эмзэг бүлгийн нөхцөл байдлыг харгалзан үзэж, тэдний эмзэг байдлыг дээрдүүлэхэд чиглэсэн эсэх	Хувилбар 0	тийм	Одоогийн нөхцөл байдал өөрчлөгдөхгүй
		Хувилбар 1	тийм	Хяналтыг сайжруулж, эмзэг байдлыг дээрдүүлнэ
	3.4.Эрх агуулагчдын, ялангуяа эмзэг бүлгийн ялгаатай хэрэгцээг тооцсон мэдрэмжтэй зохицуулалтыг тусгах эсэх (хөгжлийн бэрхшээлтэй, үндэстний цөөнх, хэлний цөөнх, гагцхүү эдгээрээр хязгаарлахгүй)	Хувилбар 0	тийм	Одоогийн нөхцөл байдал өөрчлөгдөхгүй
		Хувилбар 1	тийм	ялгаатай хэрэгцээг тооцсон мэдрэмжтэй зохицуулалт
4.Үүрэг хүлээгч	4.1.Үүрэг хүлээгчдийг тодорхойлсон эсэх	Хувилбар 0	тийм	Одоогийн нөхцөл байдал өөрчлөгдөхгүй
		Хувилбар 1	тийм	Хуульд тодорхойлох боломжтой.
5.Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд нийцүүлсэн эсэх	5.1.Жендэрийн үзэл баримтлалыг тусгасан эсэх	Хувилбар 0	үгүй	Тусгаагүй.
		Хувилбар 1	тийм	Хуульд тодорхойлох боломжтой.
	5.2.Эрэгтэй, эмэгтэй хүний тэгш эрх, тэгш боломж, тэгш хандлагын баталгааг бүрдүүлэх эсэх	Хувилбар 0	үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
		Хувилбар 1	үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.

Саадгүй байдал, хүртээмжид холбогдох хувилбаруудыг харьцуулж үзэхэд дэд бүтэц, тээвэр, барилга байгууламжийн орчин нь аль ч улс орны хөрөнгө оруулалтын томоохон салбаруудын нэг бөгөөд дэд бүтцийн хувьд "сайн" нь эерэг өөрчлөлт, хөгжлийн зорилгод хүрэхэд түлхэц болдог. Дэд бүтэц нь нийгмийн хөгжлийг дэмжихэд зориулагдан төлөвлөгдсөн байх ёстой. Харин хүртээмжгүй тохиолдолд хувь хүмүүс эсвэл тодорхой бүлэг хүмүүсийг нийгмийн оролцоо болон сурч, хөдөлмөрлөх эрхийг нь боомилж, амьдралын чанарыг бууруулж, хүний эрхийн зөрчил үүсгэдэг. Иймээс хүртээмжтэй орчныг бий болгох нь нийт иргэдийн эрүүл,

аюулгүй орчинд амьдрах үндсэн суурь хангагдаж эхлэх бөгөөд хөгжлийн бэрхшээлтэй иргэд бусдын адил нийгэмдээ бүрэн дүүрэн оролцоотой амьдрах гол хүчин зүйлийн нэг болно.

5.2.Эдийн засагт үзүүлэх үр нөлөө

Эдийн засагт үзүүлэх үр нөлөөний үнэлгээний зорилго нь тухайн зохицуулалтын хувилбар нь өсөлт, ажил эрхлэлт, бизнес, өрсөлдөх чадвар болон нийтийн баялагт хэрхэн нөлөөлөх вэ гэдгийг тогтооход оршино. Эдийн засагт үзүүлэх үр нөлөөг шууд болон шууд бус үр нөлөө гэж ангилна. Шууд үр нөлөөний энгийн жишээ бол зохицуулалтын хувилбарын улмаас улсын болон орон нутгийн төсөвт нэмэлт зардал үүсэх, аж ахуйн үйл ажиллагааны татварын хэмжээг өөрчлөх зэрэг байж болно.

Хүснэгт 3 Эдийн засагт үзүүлэх үр нөлөө

Үзүүлэх үр нөлөө	Холбогдох асуулт	Хувилбар	Хариулт	Тайлбар
1.Дэлхийн зах зээл дээр өрсөлдөх чадвар	1.1.Ялгаварлан гадуурхахгүй ба тэгш байх			
	1.1.Дотоодын аж ахуйн нэгж болон гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж хоорондын өрсөлдөөнд нөлөө үзүүлэх эсэх	Хувилбар 0	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй
		Хувилбар 1	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй
	1.2.Хил дамнасан хөрөнгө оруулалтын шилжилт хөдөлгөөнд нөлөө үзүүлэх эсэх (эдийн засгийн байршил өөрчлөгдөхийг оролцуулан)	Хувилбар 0	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй
		Хувилбар 1	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй
	1.3.Дэлхийн зах зээл дээрх таагүй нөлөөллийг монголын зах зээлд орж ирэхээс хамгаалахад нөлөөлж чадах эсэх	Хувилбар 0	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй
		Хувилбар 1	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй
2.Дотоодын зах зээлийн өрсөлдөх чадвар болон тогтвортой байдал	2.1.Хэрэглэгчдийн шийдвэр гаргах боломжийг бууруулах эсэх	Хувилбар 0	Үгүй	Одоогийн нөхцөл байдал өөрчлөгдөхгүй
		Хувилбар 1	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй
	2.2.Хязгаарлагдмал өрсөлдөөний улмаас үнийн хөөрөгдлийг бий болгох эсэх	Хувилбар 0	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй
		Хувилбар 1	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй
	2.3.Зах зээлд шинээр орж ирж байгаа аж ахуйн нэгжид бэрхшээл, хүндрэл бий болгох эсэх	Хувилбар 0	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй
		Хувилбар 1	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй
	2.4.Зах зээлд шинээр монополийг бий болгох эсэх	Хувилбар 0	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй
		Хувилбар 1	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй
3.Аж ахуйн нэгжийн үйлдвэрлэлийн болон захиргааны зардал	3.1.Зохицуулалтын хувилбарыг хэрэгжүүлснээр аж ахуйн нэгжид шинээр зардал үүсэх эсэх	Хувилбар 0	тийм	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй
		Хувилбар 1	тийм	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй
	3.2.Санхүүжилтийн эх үүсвэр олж авахад нөлөө үзүүлэх эсэх	Хувилбар 0	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй
		Хувилбар 1	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй

	3.3.Зах зээлээс тодорхой бараа бүтээгдэхүүнийг худалдан авахад хүргэх эсэх	Хувилбар 0	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй
		Хувилбар 1	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй
	3.4.Бараа бүтээгдэхүүний борлуулалтад ямар нэг хязгаарлалт, эсхүл хориг тавих эсэх	Хувилбар 0	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй
		Хувилбар 1	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй
	3.5.Аж ахуйн нэгжийг үйл ажиллагаагаа зогсооход хүргэх эсэх	Хувилбар 0	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй
		Хувилбар 1	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй
4.Мэдээлэх үүргийн улмаас үүсч байгаа захиргааны зардлын ачаалал	4.1.Хуулийн этгээдэд захиргааны шинж чанартай нэмэлт зардал (Тухайлбал, мэдээлэх, тайлан гаргах г.м) бий болгох эсэх	Хувилбар 0	Үгүй	Одоогийн нөхцөл байдал өөрчлөгдөхгүй
		Хувилбар 1	Үгүй	Захиргааны зардал, ачаалал үүсгэхгүй
5.Өмчлөх эрх	5.1.Өмчлөх эрхийг (үл хөдлөх, хөдлөх эд хөрөнгө, эдийн бус баялаг зэргийг) хөндсөн зохицуулалт бий болох эсэх	Хувилбар 0	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй
		Хувилбар 1	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй
	5.2.Өмчлөх эрх олж авах, шилжүүлэх болон хэрэгжүүлэхэд хязгаарлалт бий болгох эсэх	Хувилбар 0	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
		Хувилбар 1	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
	5.3.Оюуны өмчийн (патент, барааны тэмдэг, зохиогчийн эрх зэрэг) эрхийг хөндсөн зохицуулалт бий болгох эсэх	Хувилбар 0	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
		Хувилбар 1	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
6.Инноваци болон судалгаа шинжилгээ	6.1.Судалгаа шинжилгээ, нээлт хийх, шинэ бүтээл гаргах асуудлыг дэмжих эсэх	Хувилбар 0	Үгүй	Одоогийн нөхцөл байдал өөрчлөгдөхгүй
		Хувилбар 1	Тийм	
	6.2.Үйлдвэрлэлийн шинэ технологи болон шинэ бүтээгдэхүүн нэвтрүүлэх, дэлгэрүүлэхийг илүү хялбар болгох эсэх	Хувилбар 0	Үгүй	Одоогийн нөхцөл байдал өөрчлөгдөхгүй
		Хувилбар 1	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
7.Хэрэглэгч болон гэр бүлийн төсөв	7.1.Хэрэглээний үнийн түвшинд нөлөө үзүүлэх эсэх	Хувилбар 0	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй
		Хувилбар 1	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй
	7.2.Хэрэглэгчдийн хувьд дотоодын зах зээлийг ашиглах боломж олгох эсэх	Хувилбар 0	Үгүй	Одоогийн нөхцөл байдал өөрчлөгдөхгүй
		Хувилбар 1	Үгүй	Одоогийн нөхцөл байдал өөрчлөгдөхгүй
	7.3.Хэрэглэгчдийн эрх ашигт нөлөөлөх эсэх	Хувилбар 0	Үгүй	Одоогийн нөхцөл байдал өөрчлөгдөхгүй
		Хувилбар 1	Тийм	Хүртгэмжэй үйлчилгээг саадгүй авна
	7.4.Хувь хүний/гэр бүлийн санхүүгийн байдалд (шууд буюу урт хугацааны туршид) нөлөө үзүүлэх эсэх	Хувилбар 0	Үгүй	Одоогийн нөхцөл байдал өөрчлөгдөхгүй
		Хувилбар 1	Тийм	Хувь хүний болон өрхийн орлого өсөх боломж бүрдүүлэхэд чиглэсэн

8.Тодорхой бүс нутаг, салбарууд	8.1.Тодорхой бүс нутагт буюу тодорхой нэг чиглэлд ажлын байрыг шинээр бий болгох эсэх	Хувилбар 0	Үгүй	Одоогийн нөхцөл байдал өөрчлөгдөхгүй
		Хувилбар 1	Тийм	Ажлын байр бий болгох боломжтой
	8.2.Тодорхой бүс нутагт буюу тодорхой нэг чиглэлд ажлын байр багасгах чиглэлээр нөлөө үзүүлэх эсэх	Хувилбар 0	Үгүй	Одоогийн нөхцөл байдал өөрчлөгдөхгүй
		Хувилбар 1	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй
	8.3.Жижиг, дунд үйлдвэр, эсхүл аль нэг салбарт нөлөө үзүүлэх эсэх	Хувилбар 0	Үгүй	Одоогийн нөхцөл байдал өөрчлөгдөхгүй
		Хувилбар 1	Тийм	Ажлын байр, ажилтан бий болох
9.Төрийн захиргааны байгууллага	9.1.Улсын төсөвт нөлөө үзүүлэх эсэх	Хувилбар 0	Үгүй	Одоогийн нөхцөл байдал өөрчлөгдөхгүй
		Хувилбар 1	Тийм	Халамжаас хөдөлмөрт шилжих боломжтой болно
	9.2.Шинээр төрийн байгууллага байгуулах, эсхүл төрийн байгууллагад бүтцийн өөрчлөлт хийх шаардлага тавигдах эсэх	Хувилбар 0	Үгүй	Одоогийн нөхцөл байдал өөрчлөгдөхгүй
		Хувилбар 1	Тийм	Хуульд тодорхойлох боломжтой
	9.3.Төрийн байгууллагад захиргааны шинэ чиг үүрэг бий болгох эсэх	Хувилбар 0	Үгүй	Одоогийн нөхцөл байдал өөрчлөгдөхгүй
		Хувилбар 1	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй
10.Макро эдийн засгийн хүрээнд	10.1.Эдийн засгийн өсөлт болон ажил эрхлэлтийн байдалд нөлөө үзүүлэх эсэх	Хувилбар 0	Үгүй	Одоогийн нөхцөл байдал өөрчлөгдөхгүй
		Хувилбар 1	Тийм	Ажил эрхлэх боломж нэмэгдэнэ,
	10.2.Хөрөнгө оруулалтын нөхцөлийг сайжруулах, зах зээлийн тогтвортой хөгжлийг дэмжих эсэх	Хувилбар 0	Үгүй	Одоогийн нөхцөл байдал өөрчлөгдөхгүй
		Хувилбар 1	Үгүй	Одоогийн нөхцөл байдал өөрчлөгдөхгүй
	10.3.Инфляци нэмэгдэх эсэх	Хувилбар 0	Үгүй	Одоогийн нөхцөл байдал өөрчлөгдөхгүй
		Хувилбар 1	Үгүй	Одоогийн нөхцөл байдал өөрчлөгдөхгүй
11.Олон улсын харилцаа	11.1.Монгол Улсын олон улсын гэрээтэй нийцэж байгаа эсэх	Хувилбар 0	Үгүй	Одоогийн нөхцөл байдал өөрчлөгдөхгүй
		Хувилбар 1	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй

“Хүртээмж” нь аливаа хэлбэрээр хөгжлийн бэрхшээл ба ядуурлын хоорондох анхдагч хүчин зүйл болдог. Тухайлбал, үндсэн дэд бүтэц болох ус, цахилгаан дутмаг, хүрээлэн буй орчны хүртээмжгүй байдал, эсвэл эмэгтэйчүүдэд аюулгүй орчин бий болгож чадахгүй байх тохиолдолд, тэгш бус байдал, нийгмийн гадуурхал нэмэгддэг. Энэ нь хөгжлийн бэрхшээл, эсвэл ядуурлын аль алиных нь шалтгаан, үр дагавар байж болох бөгөөд хөгжлийн бэрхшээл ба ядуурлын хоорондын холбоог бэхжүүлэх" хортой цикл" гэж тодорхойлдог. Тухайлбал, Монгол Улсад дор хаяж нэг хөгжлийн бэрхшээлтэй хүнтэй өрхийн амьдралын төвшин бусад өрхийн амьдралын төвшнээс хоёр дахин ядуу байдаг. Ядуурлын олон хэмжээст шинж чанарын судалгаагаар дунд орлоготой нөхцөлд хөгжлийн бэрхшээлтэй өрхүүдийн ядуурал бага орлоготой өрхтэй харьцуулахад харьцангуй өндөр байгааг харуулсан нь хөгжлийн

бэрхшээлийн хөгжлийн цоорхой байгааг харуулж, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг хамруулан хөгжүүлэх хөтөлбөрүүдийн ач холбогдлыг тодорхой харуулдаг.

Барилга байгууламж, зам, замын байгууламж, мэдээллийн технологи, харилцаа холбооны хүртээмжтэй орчин нөхцөлийг бий болгон ХБХ-ий бие даан амьдрах эрхийг хангуулах, хүний эрхийг дээдэлсэн, түгээмэл загварыг бий болгосноор жил болгон улсын төсөвт халамжийн чиглэлээр төлөвлөгддөг төсөв багасна. Саадгүй орчин хүртээмжийн тухай хууль батлагдсанаар хөгжлийн бэрхшээлтэй хүн боловсролд тэгш хамрагдах, ажил хөдөлмөр эрхлэх, нийгэмд оролцох боломж нэмэгдэж айл өрхийн эдийн засаг дээшилж цаашдаа халамжлуулагч биш баялаг бүтээгч, ажил олгогч болсноор улсын эдийн засагт эерэгээр нөлөөлдөг нь олон улсын туршлагаар нотлогджээ.

Мөн Монгол Улс хүн бүрт ээлтэй, хүртээмжтэй орчин нөхцөл бүрдсэнээр Монголд ирэх олон улсын аялагчдын хөгжлийн бэрхшээлтэй, ахмад настан, бага насны хүүхэдтэй гэр бүл тоо нэмэгдэж аялал жуучлалын салбарт болон Монгол улсын эдийн засагт томоохон үр нөлөө үзүүлэх боломжтой байна. Харин улсын болон орон нутгийн төсвөөс нэмэлт зардал гарахаас илүүтэй захиалагчийн эрх, үүрэг тодорхой болж төсвийн хөрөнгөөр шинээр гүйцэтгэх, бүтээн байгуулалт, засвар, үйлчилгээ хийх, худалдан авах ажил, үйлчилгээ хүний эрхэд суурилсан байх шаардлага тавигдаж эхлэх эерэг нөлөөтэй.

5.3. Нийгэмд үзүүлэх үр нөлөө

Энэ хэсэгт зохицуулалтын хувилбаруудын нийгэмд үзүүлэх үр нөлөөг авч үзсэн болно. Нийгэмд үзүүлэх үр нөлөө нь үндсэн шинжийн хувьд олон хэлбэрийг агуулдаг бөгөөд өөр хоорондоо болон бусад төрлийн үр нөлөөтэй давхцах нь бий. Доорх хүснэгтэд нийгэмд үзүүлэх үр нөлөөг холбогдох асуултын хүрээнд авч үзсэн бөгөөд дэлгэрэнгүй буюу нэмэлт тайлбарыг тухайлан бичсэн болно.

Хүснэгт 4 нийгэмд үзүүлэх үр нөлөө

Үзүүлэх үр нөлөө	Холбогдох асуулт	Хувилбар	Хариулт	Тайлбар
1. Ажил эрхлэлтийн байдал, хөдөлмөрийн зах зээл	1.1. Ялгаварлан гадуурхахгүй ба тэгш байх			
	1.1. Шинээр ажлын байр бий болох эсэх	Хувилбар 0	Үгүй	Одоогийн нөхцөл байдал өөрчлөгдөхгүй
		Хувилбар 1	Тийм	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй
	1.2. Шууд болон шууд бусаар ажлын байрны цомхотгол бий болгох эсэх	Хувилбар 0	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй
		Хувилбар 1	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй
	1.3. Тодорхой ажил мэргэжлийн хүмүүс болон хувиараа хөдөлмөр эрхлэгчдэд нөлөө үзүүлэх эсэх	Хувилбар 0	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй
		Хувилбар 1	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй
	1.4. Тодорхой насны хүмүүсийн ажил эрхлэлтийн байдалд нөлөөлөх эсэх	Хувилбар 0	Үгүй	Одоогийн нөхцөл байдал өөрчлөгдөхгүй
		Хувилбар 1	Тийм	Ахмадуудын хөдөлмөр эрхлэлтэд эерэгээр нөлөөлнө

2.Ажлын стандарт, хөдөлмөрлөх эрх	2.1.Ажлын чанар, стандартад нөлөөлөх эсэх	Хувилбар 0	Үгүй	Одоогийн нөхцөл байдал өөрчлөгдөхгүй	
		Хувилбар 1	Тийм	Саадгүй, хүртээмжтэй орчин бий болсноор хөдөлмөрийн аюулгүй байдал сайжирна	
	2.2.Ажилчдын эрүүл мэнд, хөдөлмөрийн аюулгүй байдалд нөлөөлөх эсэх	Хувилбар 0	Үгүй	Одоогийн нөхцөл байдал өөрчлөгдөхгүй	
		Хувилбар 1	Тийм	Саадгүй, хүртээмжтэй орчин бий болсноор хөдөлмөрийн аюулгүй байдал сайжирна	
	2.3.Ажилчдын эрх, үүрэгт шууд болон шууд бусаар нөлөөлөх эсэх	Хувилбар 0	Үгүй	Одоогийн нөхцөл байдал өөрчлөгдөхгүй	
		Хувилбар 1	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй	
	2.4.Шинээр ажлын стандарт гаргах эсэх	Хувилбар 0	Үгүй	Одоогийн нөхцөл байдал өөрчлөгдөхгүй	
		Хувилбар 1	Тийм	Хуулийн зохицуулалтад оруулах боломжтой	
	2.5.Ажлын байранд технологийн шинэчлэлийг хэрэгжүүлэхтэй холбогдсон өөрчлөлт бий болгох эсэх	Хувилбар 0	Үгүй	Одоогийн нөхцөл байдал өөрчлөгдөхгүй	
		Хувилбар 1	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй	
	3.Нийгмийн тодорхой бүлгийг хамгаалах асуудал	3.1.Шууд болон шууд бусаар тэгш бус байдал үүсгэх эсэх	Хувилбар 0	Үгүй	Одоогийн нөхцөл байдал өөрчлөгдөхгүй
			Хувилбар 1	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй
3.2.Тодорхой бүлэг болон хүмүүст сөрөг нөлөө үзүүлэх эсэх. Тухайлбал, эмзэг бүлэг, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, ажилгүй иргэд, үндэстний цөөнхөд гэх мэт		Хувилбар 0	Үгүй	Одоогийн нөхцөл байдал өөрчлөгдөхгүй	
		Хувилбар 1	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй	
3.3.Гадаадын иргэдэд илэрхий нөлөөлөх эсэх		Хувилбар 0	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй	
		Хувилбар 1	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй	
4.Төрийн удирдлага, сайн засаглал, шүүх эрх мэдэл, хэвлэл мэдээлэл, ёс суртахуун	4.1.Засаглалын харилцаанд оролцогчдод нөлөөлөх эсэх	Хувилбар 0	Үгүй	Одоогийн нөхцөл байдал өөрчлөгдөхгүй	
		Хувилбар 1	Үгүй	Захиргааны зардал, ачаалал үүсгэхгүй	
	4.2.Төрийн байгууллагуудын үүрэг, үйл ажиллагаанд нөлөөлөх эсэх	Хувилбар 0	Үгүй	Одоогийн нөхцөл байдал өөрчлөгдөхгүй	
		Хувилбар 1	тийм	Төрийн байгууллагын захиалагчийн болон худалдан авах ажиллагаанд хүний эрхийн хандлагад нэвтэрнэ	
	4.3.Төрийн захиргааны албан хаагчдын эрх, үүрэг, харилцаанд нөлөөлөх эсэх	Хувилбар 0	Үгүй	Одоогийн нөхцөл байдал өөрчлөгдөхгүй	
		Хувилбар 1	Тийм	Төрийн албан хаагчийн шийдвэр хариуцлагатай, хяналттай болно.	

	4.4.Иргэдийн шүүхэд хандах, асуудлаа шийдвэрлүүлэх эрхэд нөлөөлөх эсэх	Хувилбар 0	Үгүй	Одоогийн нөхцөл байдал өөрчлөгдөхгүй	
		Хувилбар 1	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй	
	4.5.Улс төрийн нам, төрийн бус байгууллагын үйл ажиллагаанд нөлөөлөх эсэх	Хувилбар 0	Үгүй	Одоогийн нөхцөл байдал өөрчлөгдөхгүй	
		Хувилбар 1	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй	
5.Нийтийн эрүүл мэнд, аюулгүй байдал	5.1.Хувь хүн/нийт хүн амын дундаж наслалт, өвчлөлт, нас баралтын байдалд нөлөөлөх эсэх	Хувилбар 0	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй	
		Хувилбар 1	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй	
	5.2.Зохицуулалтын хувилбарын улмаас үүсэх дуу чимээ, агаар, хөрсний чанарын өөрчлөлт хүн амын эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Хувилбар 0	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.	
		Хувилбар 1	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.	
	5.3.Хүмүүсийн амьдралын хэв маяг (хооллолт, хөдөлгөөн, архи, тамхины хэрэглээ)-т нөлөөлөх эсэх	Хувилбар 0	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.	
		Хувилбар 1	Тийм	ХБХ, ахмад настан, хүүхдүүд саадгүй зорчих боломжтой болно	
6.Нийгмийн хамгаалал, эрүүл мэнд, боловсролын систем	6.1.Нийгмийн үйлчилгээний чанар, хүртээмжид нөлөөлөх эсэх	Хувилбар 0	Үгүй	Одоогийн нөхцөл байдал өөрчлөгдөхгүй	
		Хувилбар 1	Тийм	Нийгмийн үйлчилгээний хүртээмж сайжирна	
	6.2.Ажилчдын боловсрол, шилжилт хөдөлгөөнд нөлөөлөх эсэх	Хувилбар 0	Үгүй	Одоогийн нөхцөл байдал өөрчлөгдөхгүй	
		Хувилбар 1	Тийм	Хүний эрхийн мэдлэг, мэдрэмж дээшилнэ	
	6.3.Иргэдийн боловсрол (төрийн болон хувийн хэвшлийн боловсролын байгууллага) олох, мэргэжил эзэмших, давтан сургалтад хамрагдахад сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Хувилбар 0	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.	
		Хувилбар 1	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.	
	6.4.Нийгмийн болон эрүүл мэндийн үйлчилгээ авахад сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Хувилбар 0	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.	
		Хувилбар 1	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.	
	6.5.Их, дээд сургуулиудын үйл ажиллагаа, өөрийн удирдлагад нөлөөлөх эсэх	Хувилбар 0	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.	
		Хувилбар 1	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.	
	7.Гэмт хэрэг, нийгмийн аюулгүй байдал	7.1.Нийгмийн аюулгүй байдал, гэмт хэргийн нөхцөл байдалд нөлөөлөх эсэх	Хувилбар 0	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй
			Хувилбар 1	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй
7.2.Хуулийг албадан хэрэгжүүлэхэд нөлөөлөх эсэх		Хувилбар 0	Үгүй	Одоогийн нөхцөл байдал өөрчлөгдөхгүй	
		Хувилбар 1	Үгүй	Одоогийн нөхцөл байдал өөрчлөгдөхгүй	
7.3.Гэмт хэргийн илрүүлэлтэд нөлөө үзүүлэх эсэх		Хувилбар 0	Үгүй	Одоогийн нөхцөл байдал өөрчлөгдөхгүй	
		Хувилбар 1	Тийм	Хүртээмжэй үйлчилгээг саадгүй авна	

	7.4.Гэмт хэргийн хохирогчид, гэрчийн эрхэд сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Хувилбар 0	Үгүй	Одоогийн нөхцөл байдал өөрчлөгдөхгүй
		Хувилбар 1	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй
8.Соёл	8.1.Соёлын өвийг хамгаалахад нөлөө үзүүлэх эсэх	Хувилбар 0	Үгүй	Одоогийн нөхцөл байдал өөрчлөгдөхгүй
		Хувилбар 1	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй
	8.2.Хэл, соёлын ялгаатай байдал бий болгох эсэх, эсхүл уг ялгаатай байдалд нөлөөлөх эсэх	Хувилбар 0	Үгүй	Одоогийн нөхцөл байдал өөрчлөгдөхгүй
		Хувилбар 1	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй
	8.3.Иргэдийн түүх, соёлоо хамгаалах оролцоонд нөлөөлөх эсэх	Хувилбар 0	Үгүй	Одоогийн нөхцөл байдал өөрчлөгдөхгүй
		Хувилбар 1	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй

Саадгүй, хүртээмжтэй орчин бий болсноор юуны өмнө ХБХ, ахмад настан, бага насны хүүхдүүд, тэдгээрийн асран хамгаалагчдын нийгмийн хамгаалал, боловсрол, эрүүл мэнд, соёл, хөдөлмөр эрхлэлт зэрэг нийгмийн идэвхтэй амьдралд оролцоход эерэг нөлөөтэй байдаг. Хуулийн төслийн хэрэгцээ шаардлагыг тандан судалсан судалгааны дүнд дэвшүүлсэн хувилбаруудыг харьцуулж үзээд шинээр хууль санаачилснаар дараах нийгмийн үр дагавар гарах боломжтой гэж үзэж байна. Үүнд:

1. Ажлын стандарт, хөдөлмөрлөх эрх хангагдах эсэх тухайд

Зохицуулалтын хувилбар 1 нь хүн ам төвлөрсөн хот суурин газар саадгүй байдлыг, төрийн болон мэдээллийн технологи, нийтийн үйлчилгээний салбарт хүртээмжтэй үйлчилгээ үзүүлэх асуудлыг нэг дор цогцоор нь шийдвэрлэх эрх зүйн орчин бүрдсэнээр ХБХ, ахмад настны хөдөлмөрлөх, ажил хөдөлмөртөө нийцсэн орлого олж өмч хөрөнгөтэй болох, эдийн засгийн хувьд бусдаас хараат бус байх, цаашлаад бие даан амьдрах эрхээ эдлэх боломж бүрдэнэ гэж үзэж байна. Саадгүй байдал, хүртээмжтэй орчин нөхцөлийг бүрдүүлэх талаар өнөө ч олон дүрэм, журам, стандарт үйлчилж байгаа боловч хэрэгжилт хангалтгүй байгааталаар үнэлэх хэсэгт тодорхой дурдсан. Иймээс хуулийн төсөл боловсруулагдсанаар эдгээр хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, холбогдох байгууллага, албан тушаалтны шийдвэр хариуцлагатай, улсын болон орон нутгийн төсвөөр хийгдэж буй бүтээн байгуулалтуудыг хүн бүр эрх тэгш хүртэх боломж бүрдэхэд нөлөөлнө.

Нийгмийн тодорхой бүлгийг хамгаалах асуудал

2. Шууд болон шууд бусаар тэгш бус байдал үүсгэх эсэх тухайд

Хүний эрхэд үзүүлэх үр нөлөөг үнэлэх хэсэгт дэлгэрэнгүй авч үзсэн билээ. Зохицуулалтын хувилбар 0-ийг хэрэгжүүлснээр одоогийн нөхцөл байдал өөрчлөгдөхгүй. Харин зохицуулалтын хувилбар 1-ийг хэрэгжүүлснээр шууд болон шууд бусаар тэгш бус байдал үүсгэхээс сэргийлэхэд эерэг нөлөө үзүүлнэ. Мөн тус хувилбарыг хэрэгжүүлснээр тодорхой бүлэг болон хүмүүст сөрөг нөлөө үзүүлэхгүй бөгөөд харин эрх нь зөрчигдсэн хүмүүст эерэг нөлөөтэй. Түүнчлэн тус хувилбарыг хэрэгжүүлэх нь гадаадын иргэдэд илэрхий нөлөөлөхгүй.

3. Төрийн удирдлага, сайн засаглал, шүүх эрх мэдэл, хэвлэл мэдээлэл, ёс суртахуун Засаглалын харилцаанд оролцогчдод нөлөөлөх эсэх тухайд

Монголын Улсын Үндсэн хуульд “Монгол Улсад засгийн бүх эрх ард түмний мэдэлд байна. Монголын ард түмэн төрийн үйл хэрэгт шууд оролцож, мөн сонгож байгуулсан төрийн эрх барих төлөөлөгчдийн байгууллагаараа уламжлан энэхүү эрхээ эдэлнэ.” гэж заасан бөгөөд хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх мэдэлд нөлөөлөх харилцаа сонгосон хувилбаруудын аль алинд нь төдийлөн нөлөөтэй биш. Харин сонгогчдоо төлөөлж УИХ-д сонгогдсон гишүүд, засаглалын харилцаанд оролцогчид хүн бүр эрх тэгш байх зарчмыг баримталж ХБХ бусдын адил ажиллаж, амьдрах орчин нөхцөлийн бүрдүүлэхэд анхаарах шаардлагатайг илтгэж байна.

4. Төрийн байгууллагуудын үүрэг, үйл ажиллагаанд нөлөөлөх эсэх тухайд

Саадгүй байдал, хүртээмжтэй холбогдуулан зохицуулалтын хувилбар 0-ийг хэрэгжүүлснээр одоогийн нөхцөл байдал өөрчлөгдөхгүй тул төрийн байгууллагуудын үүрэг, үйл ажиллагаанд нөлөөлөхгүй. Зохицуулалтын хувилбар 1-ийг хэрэгжүүлснээр төрийн үйл ажиллагаанд буюу төсвийн хөрөнгө оруулалтаар хүний эрхийн зөрчил үүсгэж, ХБХ бусдын адил эрхээ эдлэх боломжийг хаасан, стандарт, дүрэм, журамд заасан шалгуурыг хангаагүй бүтээн байгуулалт, худалдан авалт хийж буй байдлыг таслан зогсооход чиглэсэн төрийн байгууллагын хяналт, хариуцлага дээшилж, эрх бүхий байгууллагуудын үйл ажиллагаанд эерэг нөлөөлөл үзүүлэх боломжтой. Тухайн хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах чиг үүрэг холбогдох төрийн байгууллагуудын үйл ажиллагааны нэг хэсэг байсан тул шинээр чиг үүрэг нэмэгдэхгүй.

5. Иргэдийн шүүхэд хандах, асуудлаа шийдвэрлүүлэх эрхэд нөлөөлөх эсэх тухайд

Зохицуулалтын хувилбар 0-ийг хэрэгжүүлснээр одоогийн нөхцөл байдал өөрчлөгдөхгүй. Харин зохицуулалтын хувилбар 1-ийг хэрэгжүүлбэл төрийн болон нийтэд нээлттэй/чиглэсэн барилга байгууламж, үйлчилгээг саадгүй, хүртээмжтэй авч чадаагүй иргэд хууль хяналтын байгууллагад хандаж зөрчигдсөн эрхээ сэргээлгэх/хамгаалуулах, иргэдийн шүүхэд хандах, асуудлаа шийдвэрлүүлэх эрхэд эерэг нөлөө үзүүлнэ.

Нийгмийн харилцаанд саадгүй байдал, хүртээмжийн асуудал ХБХ-д зориулагдсан гэж ярих ч бодит байдал дээр бүх хүний буюу нийгмийн сайн сайхан байдал, хүмүүсийн сэтгэл зүйд эерэгээр нөлөөлөх, ая тухтай байдлыг нэмэгдүүлдэг байна. Үүний илрэл бол саадгүй, хүртээмжтэй байдал нэмэгдэхийн хэрээр ХБХ-ийн нийгмийн харилцаанд эрх тэгш, аливаа ялгаваргүйгээр оролцох, эрүүл мэнд, боловсрол, хөдөлмөр эрхлэлтийн байдал нэмэгдэж ХБХ, түүний гэр бүлийн ядуурлын түвшин буурах, эрүүл мэнд, сэтгэлзүйн хувьд тогтвортой байхаас гадна барилга байгууламж, дэд бүтцийн хангалтгүй байдлаас шалтгаалсан гэмтэл, ослын тоо буурснаар цаашид түр болон байнгын хөгжлийн бэрхшээл үүсэхээс урьдчилан сэргийлэх, ахмад настан, бага насны хүүхдийн нийгмийн оролцоог хангаж, эрүүл ,аюулгүй орчинд амьдрах эрхийг хангахад ч нөлөөтэй юм.

5.4. Байгаль орчинд үзүүлэх үр нөлөө

Үзүүлэх үр нөлөө	Холбогдох асуулт	Хувилбар	Хариулт	Тайлбар
1.Агаар	1.1.Зохицуулалтын хувилбарын үр дүнд агаарын бохирдлыг нэмэгдүүлэх эсэх	Хувилбар 0	Үгүй	Одоогийн нөхцөл байдал өөрчлөгдөхгүй
		Хувилбар 1	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй
2.Зам тээвэр, түлш, эрчим хүч	2.1.Тээврийн хэрэгслийн түлшний хэрэглээг нэмэгдүүлэх/бууруулах эсэх	Хувилбар 0	Үгүй	Одоогийн нөхцөл байдал өөрчлөгдөхгүй
		Хувилбар 1	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй
	2.2.Эрчим хүчний хэрэглээг нэмэгдүүлэх эсэх	Хувилбар 0	Үгүй	Одоогийн нөхцөл байдал өөрчлөгдөхгүй
		Хувилбар 1	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй
	2.3.Эрчим хүчний үйлдвэрлэлд нөлөө үзүүлэх эсэх	Хувилбар 0	Үгүй	Одоогийн нөхцөл байдал өөрчлөгдөхгүй
		Хувилбар 1	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй
	2.4.Тээврийн хэрэгслийн агаарын бохирдлыг нэмэгдүүлэх эсэх	Хувилбар 0	Үгүй	Одоогийн нөхцөл байдал өөрчлөгдөхгүй
		Хувилбар 1	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй
3.Ан амьтан, ургамлыг хамгаалах	3.1.Ан амьтны тоо хэмжээг бууруулах эсэх	Хувилбар 0	Үгүй	Одоогийн нөхцөл байдал өөрчлөгдөхгүй
		Хувилбар 1	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй
	3.2.Ховордсон болон нэн ховор амьтан, ургамалд сөргөөр нөлөөлөх эсэх	Хувилбар 0	Үгүй	Одоогийн нөхцөл байдал өөрчлөгдөхгүй
		Хувилбар 1	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй
	3.3.Ан амьтдын нүүдэл, суурьшилд сөргөөр нөлөөлөх эсэх	Хувилбар 0	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй
		Хувилбар 1	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй
	3.4.Тусгай хамгаалалттай газар нутагт сөргөөр нөлөөлөх эсэх	Хувилбар 0	Үгүй	Одоогийн нөхцөл байдал өөрчлөгдөхгүй
		Хувилбар 1	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй
4.Усны нөөц	4.1.Газрын дээрх ус болон гүний ус, цэвэр усны нөөцөд сөргөөр нөлөөлөх эсэх	Хувилбар 0	Үгүй	Одоогийн нөхцөл байдал өөрчлөгдөхгүй
		Хувилбар 1	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй
	4.2.Усны бохирдлыг нэмэгдүүлэх эсэх	Хувилбар 0	Үгүй	Одоогийн нөхцөл байдал өөрчлөгдөхгүй
		Хувилбар 1	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй
	4.3.Ундны усны чанарт нөлөөлөх эсэх	Хувилбар 0	Үгүй	Одоогийн нөхцөл байдал өөрчлөгдөхгүй
		Хувилбар 1	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй
5.Хөрсний бохирдол	5.1.Хөрсний бохирдолтод нөлөө үзүүлэх эсэх	Хувилбар 0	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй
		Хувилбар 1	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй

	5.2.Хөрсийг эвдэх, ашиглагдсан талбайн хэмжээг нэмэгдүүлэх эсэх	Хувилбар 0	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
		Хувилбар 1	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
6.Газрын ашиглалт	6.1.Ашиглагдаагүй байсан газрыг ашиглах эсэх	Хувилбар 0	Үгүй	Одоогийн нөхцөл байдал өөрчлөгдөхгүй
		Хувилбар 1	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
	6.2.Газрын зориулалтыг өөрчлөх эсэх	Хувилбар 0	Үгүй	Одоогийн нөхцөл байдал өөрчлөгдөхгүй
		Хувилбар 1	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
	6.3.Экологийн зориулалтаар хамгаалагдсан газрын зориулалтыг өөрчлөх эсэх	Хувилбар 0	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
		Хувилбар 1	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй.
7.Нөхөн сэргээгдэх/нөхөн сэргээгдэхгүй байгалийн баялаг	7.1.Нөхөн сэргээгдэх байгалийн баялгийг өөрөө нөхөн сэргээгдэх чадавхыг нь алдагдуулахгүйгээр зохистой ашиглах эсэх	Хувилбар 0	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй
		Хувилбар 1	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй
	7.1.Нөхөн сэргээгдэх байгалийн баялгийг өөрөө нөхөн сэргээгдэх чадавхыг нь алдагдуулахгүйгээр зохистой ашиглах эсэх	Хувилбар 0	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй
		Хувилбар 1	Үгүй	Ямар нэг сөрөг нөлөө үзүүлэхгүй

5.5. Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ, бусад хууль тогтоомжид нийцсэн байдал:

Монгол Улсын Үндсэн хуулийн 19-р зүйлийн 1-д “Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна” гэж заасан. Гэвч ХБХ төрөөс хүний эрхийг хангах чиглэлээр үзүүлж буй төрийн үйлчилгээг бусдын адил эрх тэгш хүртэж чадахгүй байна. Хэдийгээр саадгүй байдал, хүртээмжийг бий болгоход чиглэсэн 100 орчим хууль хэрэгжиж байгаа боловч хэрэгжилт хангалтгүйгээс болж ХБХ-ий эрх зөрчигдсөөр байна. Иймээс саадгүй байдал хүртээмжийн тухай анхдагч хуулийг боловсруулснаар төрийн чиг үүргийг хэрэгжүүлэгч байгууллагуудын үйл ажиллагааны уялдаа холбоо, хууль тогтоомжийн хэрэгжилтийн нэгдмэл байдлыг хангах замаар ХБХ Монгол Улсын Үндсэн хуулиар баталгаажсан эрхээ эрх тэгш эдлэх боломж бүрдүүлж байгаа тул Үндсэн хуульд нийцсэн гэж үзэж байна.

Монгол Улсын нэгдэн орж, соёрхон баталсан олон улсын гэрээ, конвенц, тухайлбал, НҮБ-ын Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн конвенц, Хүний эрхийн түгээмэл тунхаглал болон бусад олон улсын хүний эрх, эрх чөлөөг баталгаажуулсан гэрээ, конвенц, нэмэлт протоколуудаар хүлээсэн үүргээ биелүүлэхээс үүрэгтэй нийцэж байна. Тухайлбал, НҮБ-ын “Тогтвортой хөгжлийн зорилго 2016-2030” буюу дэлхийн хөгжлийн зорилтуудын 10 дахь “Тэгш бус байдлыг бууруулах”⁶² зорилтын хүрээнд Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам (цаашид ГБХНХЯ гэх) “2030 он гэхэд нас, хүйс, хөгжлийн бэрхшээл, арьс өнгө, яс үндэс, удам угсаа, шашин шүтлэг, эдийн засгийн болон бусад байр сууриасаа үл хамааран хүн бүрийг

⁶² Тогтвортой хөгжлийн зорилго

нийгэм, эдийн засаг, улс төрийн амьдралд эрх тэгш оролцох боломжоор хангаж, дэмжих”⁶³, мөн “Ялгаварлан гадуурхсан хууль журам, бодлого, зан заншлыг халж, энэ талын хууль тогтоомж, бодлого, үйл ажиллагааг хөхүүлэн дэмжих замаар тэгш боломж бололцоог бүрдүүлж, тэгш бус байдлыг бууруулах”⁶⁴, “Санхүү, цалин, нийгэм хамгааллын бодлогыг батлан хэрэгжүүлж, тэгш байдлыг аажмаар хангах”⁶⁵ үүргээ, мөн 2023 онд НҮБ-ын Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн хорооноос ирүүлсэн “хүртээмжтэй орчин, нөхцөлийг бүрдүүлэх замаар бие даан амьдрах эрхийг хангах” гэсэн зөвлөмжийг хэрэгжүүлэхэд боломж бүрдэнэ.

Дээр дурдсан баримт бичгүүдэд хүний эрхэд суурилсан хандлагыг төлөвшүүлэх буюу хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс бусдын адил тэгш нийгмийн амьдралд оролцох, сурч, хөдөлмөрлөх нөхцөл боломжийг бүрдүүлэх, зохих нийгмийн халамжийн үйлчилгээгээр хангагдах болон тэдгээрийн хэрэгжүүлэх арга замын ерөнхий чиглэлийг гаргасан байдаг. Саадгүй байдал, хүртээмжийн хууль нь төр иргэнийхээ өмнө Үндсэн хууль болон олон улсын өмнө хүлээсэн үүрэг амлалтаа биелүүлэхэд нэг алхам болно гэж үзэж байна.

⁶³ Мөн тэнд Зорилт 10.2

⁶⁴ Мөн тэнд Зорилт 10.3

⁶⁵ Мөн тэнд Зорилт 10.4

ЗУРГАА. ЗОХИЦУУЛАЛТЫН ХУВИЛБАРУУДЫГ ХАРЬЦУУЛЖ ДҮГНЭЛТ ХИЙХ

Саадгүй байдал, хүртээмжийн тухай хуулийн төсөл боловсруулах хэрэгцээ шаардлагыг тандан судалсан судалгаанд үндэслэн тухайн хоёр хувилбарын эерэг болон сөрөг талыг харьцуулан дүгнэлээ.

Хүснэгт 6 хувилбаруудын харьцуулалт

№	ШАЛГУУР	Хувилбар 0. Саадгүй байдал, хүртээмжийн асуудлыг зохицуулж буй одоогийн хувилбарыг сонгох	Хувилбар 1. Саадгүй байдал, хүртээмжийн асуудлыг зохицуулж буй эрх зүйн орчныг боловсронгуй болгох
1.	Зорилгод хүрэх байдал	2006 оноос хойш МУ ХБХ-д саадгүй, хүртээмжтэй үйлчилгээ үзүүлэх зорилгоор 100 орчим хууль, тэдгээр холбогдох дүрэм, журам, стандартыг боловсруулж мөрдөж байгаа боловч ХБХ бусдын нэгэн адил эрх тэгш сурч хөгжих, хөдөлмөрлөх, нийгмийн харилцаанд орох эрх хязгаарлагдмал байна. Энэ нь й эрх зүйн зохицуулалтын хэрэгжилт хангалтгүй, хууль тогтоомж болон салбар хоорондын уялдаа холбоо алдагдсан өнөөгийн нөхцөл байдал огт өөрчлөгдөхгүй буюу Тус хувилбар нь өнөөгийн тулгамдаж буй асуудлыг шийдвэрлэх зорилгод хүрэхгүй байна.	Саадгүй байдал, хүртээмжийг нэмэгдүүлэх эрх зүйн орчныг шинэчлэх буюу боловсронгуй болгосноор ХБХ төдийгүй ахмад настан, бага насны хүүхэд, тэдгээрийн асран хамгаалагчдын нийгмийн идэвх оролцоо нэмэгдэх, нийгэм, эдийн засгийн хувьд бусдаас хараат байдал буурах, цаашлаад улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэж буй бүтээн байгуулалт, ажил үйлчилгээ олон улсын өмнө хүлээсэн үүрэг, амлалтад хүрэхүйц хүнд ээлтэй байхад тавих хяналт, хариуцлага сайжирна. Энэ нь салбар дундыг уялдаа холбоог бий болгосон хуулийн зохицуулалттай болсноор тогтолцооны түвшинд үр дүнтэй байх боломжтой болно
2.	Хүний эрх, эдийн засаг, нийгэм, байгаль орчинд үзүүлэх үр нөлөө	Тус хувилбар нь манай улсын өнөөгийн нөхцөл байдалд ямар нэгэн өөрчлөлт бий болгохгүй. Өөрөөр хэлбэл, саадгүй байдал, хүртээмжийн зохицуулалтууд хэт ерөнхий, хэрэгжилтт хангалтгүй байгаа нь цаашид ч байдал сайжрахгүй буюу өнөөгийн тулгамдаж буй асуудлууд шийдвэрлэгдэх боломжгүй байна.	Төр иргэнийхээ өмнө хүлээсэн үүргээ биелүүлж хүний эрүүл, аюулгүй орчинд амьдрах, нийгмийн бүхий л суурь үйлчилгээг авах эрхийг хангахын тулд барилга байгууламж, дэд бүтэц, харилцаа холбооны саадгүй байдал, хүртээмжийг салбар бүрт сайжруулах асуудлыг цогц байдлаар шийдвэрлэх боломж бүрдэнэ. Энэхүү хувилбар нь судалгааны өмнөх хэсэгт шалгасны үр дүнд хүний эрх, эдийн засаг, нийгэмд эерэг нөлөө үзүүлэх нь батлагдсан болно. Харин асуудлын онцлогоос шалтгаалж байгаль орчинд ямар нэг нөлөө үзүүлэхээргүй байна.
3.	Зардал, үр өгөөжийн харьцаа	Тус хувилбарыг хэрэгжүүлснээр ХБХ-д хүртээмжгүй барилга байгууламж, үйлчилгээг засаж залруулахын тулд гаргаж буй нэмэлт зардал үр өгөөж муутай болох нь нотлогдож байна	Саадгүй, хүртээмжтэй байдалд холбогдох эрх зүйн орчныг боловсронгуй болгосноор улсын төсвөөс тодорхой хэмжээний зардал гарах нь ойлгомжтой. Эдгээр зардлууд өмнө ч гарч байсан. Харин

			шинэчлэлийн үр дүнд төрийн захиалгаар гүйцэтгэх төсөл хөтөлбөрүүд ХБХ-д саадгүй, хүртээмжтэй болсноор хожим гарах зардал буурах бөгөөд асуудлыг шийдвэрлэхэд илүү оновчтой зохицуулалт болж чадна. Үүний үр дүнд үүсэх үр өгөөж нь манай улсын нийгэм, эдийн засаг, хүний эрхийн нөхцөл байдалд онцгой ач холбогдолтой юм.
4.	Хууль тогтоомжтой нийцэж байгаа эсэх	Тус хувилбарыг сонгосноор Монгол Улсын одоогийн нөхцөл байдал өөрчлөгдөхгүй. Энэ нь тулгамдаж буй асуудлуудыг шийдвэрлэхэд үр нөлөө багатай бөгөөд Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ, Монгол Улсын хөгжлийн урт хугацааны хөтөлбөрийн хэрэгжилтийн байдал хангагдахгүй байх нөхцөлийг бий болгож байна.	Тус хувилбар нь Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ, Монгол Улсын хөгжлийн урт хугацааны хөтөлбөрийн хэрэгжилтийг хангахад эерэг нөлөөтэй.

Үүсэж болох эерэг үр дүн

Зорилгод хүрэх байдал шалгуур үзүүлэлт, хүний эрх, эдийн засаг, нийгэмд үзүүлэх үр нөлөө зардал, үр өгөөжийн харьцаа шалгуур үзүүлэлт, хууль тогтоомжтой нийцэж байгаа эсэх шалгуур үзүүлэлт, хүний эрхэд үзүүлэх үр нөлөө гэх шалгуур үзүүлэлтийн хувьд зохицуулалтын хувилбар 1 нь хувилбар 0-ээс эерэг үр дүнг үзүүлж байгаа нь харагдаж байна. Мөн зохицуулалтын хувилбар 1-ийг сонгон хэрэгжүүлснээр Монгол Улсын Үндсэн хууль, Хүний эрхийн түгээмэл тунхаглал, Иргэний болон улс төр, нийгэм, соёлын эрхийн тухай олон улсын пактад нийцсэн буюу эдгээрийн хэрэгжилтийг хангахад эерэг нөлөөтэй болохыг анхаарах нь зүйтэй.

Үүсэж болох сөрөг үр дагавар

Гарч болох сөрөг үр дагаврын хувьд зохицуулалтын хувилбар 0 нь хувилбар 1-ээс сөрөг үр дагавар ихтэй болох нь зохицуулалтын хувилбаруудын үр нөлөөг тандан судалсан байдлаас харагдаж байна. Зохицуулалтын хувилбар 0-ийг хэрэгжүүлснээр өнөөгийн тулгамдаж буй асуудлууд шийдвэрлэгдээгүй 20 орчим жил болж байгаа бөгөөд эрх зүйн орчныг боловсронгуй болгоогүй тохиолдолд энэ хугацаа цааш үргэлжилж ХБХ-ээс гадна манай улсын 1 сая гаруй иргэний эрх зөрчигдөж, эрх ашиг нь урт, богино ялгаатай хугацаанд хөндөгдөж байгаа байдал өөрчлөгдөхгүй байх эрсдэлтэй юм.

ДОЛОО. ОЛОН УЛСЫН БОЛОН БУСАД УЛСЫН ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТЫН ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА ХИЙХ

Энэ хэсэгт Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенцод ХБХ-д саадгүй, хүртээмжтэй орчин нөхцөлийг хангах талаар хэрхэн тусгасан буюу бид олон улсын өмнө ямар үүрэг, хариуцлага хүлээсэн, мөн гадаад орнуудад ХБХ-д саадгүй, хүртээмжтэй орчин нөхцөлийг бий болгоход чиглэсэн эрх зүйн онцлог зохицуулалтын талаар товч дурдах болно.

7.1. Олон улсын гэрээ, конвенцоор хүлээсэн үүрэг

Монгол Улс 2009 онд НҮБ-ын Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай конвенцид нэгдэн орсон. Энэхүү конвенцын Нийтлэг үүргүүд гэсэн 4 дүгээр зүйлийн 1 дэх заалтад “...Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст хөгжлийн бэрхшээлээс нь шалтгаалан алагчлалгүйгээр хүний бүх эрх, үндсэн эрх чөлөөг бүрэн дүүрэн эдлүүлэх явдлыг оролцогч улсууд хангаж, хөхиүлэн дэмжих үүрэг хүлээнэ. Эл зорилгоор оролцогч улсууд дараахь үүрэг хүлээнэ: а) энэхүү конвенцид заасан эрхийг эдлүүлэхийн тулд хууль тогтоох, захиргааны болон холбогдох бусад арга хэмжээ авна;” гэж, мөн конвенцийн Хүртээмж гэсэн 19 дүгээр зүйлд “хүртээмж”-ийг “Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүс бие даан амьдрах, амьдралын бүхий л хүрээнд бүрэн дүүрэн оролцох боломжийг бий болгох зорилгоор оролцогч улсууд нь хөдөө орон нутаг, хот суурин газрын хаана ч хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг бусдын нэгэн адил өөрийг нь хүрээлэн буй орчин, нийтийн тээвэр, мэдээлэл, харилцаа холбоо тухайлбал, мэдээлэл харилцаа холбооны технологи, систем болон нийтэд нээлттэй үйлчлэх буюу зориулагдсан бусад төрлийн объект, үйлчилгээг хүртэх явдлыг хангахад чиглэсэн зохих арга хэмжээ авна. Хүртээмжтэй байх явдалд учруулж буй саад, тогторыг илрүүлэх, устгахад чиглэсэн эдгээр арга хэмжээг ... авна...” гэж тодорхойлжээ. Үүнээс харахад манай улс Саадгүй байдал, хүртээмжийн талаар бүх шатандаа зохистой арга хэмжээ авахыг үүрэг болгон хүлээн авжээ.

Тогтвортой хөгжлийн зорилтын 11 дүгээр зорилгод “Хотуудыг болон оршин суугчдыг хамруулсан, аюулгүй, уян хатан, тогтвортой байлгах” хэмээн заасан байдаг. Энд байгаа “хамруулсан” гэдэг ойлголт нь хөгжлийн бэрхшээлтэй болоод бусад бүх хүмүүс нийгмийн амьдралд хамрагдан оролцох тухай зааж байна.⁶⁶⁶⁷ Эндээс үзэхэд НҮБ-ын Тогтвортой хөгжлийн зорилтуудыг хэрэгжүүлэхэд саадгүй байдал, хүртээмжийн талаар тодорхой арга хэмжээ авах шаардлага үүссэн байна.

Ази Номхон далайн орнуудын санаачлан гарган манай улсын нэгдэн орсон “Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийг бодитой болгох нь 2012 оны Инчеоны стратеги”-ийн 3 дугаар зорилтод “Биет орчин, нийтийн тээвэр, мэдлэг, мэдээлэл, харилцаа холбоо нь хамруулсан нийгэмд хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхээ эдлэх урьдчилсан нөхцөл юм” хэмээн заасан нь хамруулсан буюу хүртээмжтэй нийгэм нь хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхээ эдлэх

⁶⁶ Монгол Улсын Улаанбаатар хотын барилга байгууламжийн орчны хүртээмж ба хамруулсан загвар, Дэлхийн хөгжлийн бэрхшээлийн инновацын Сүлжээ /GDI Hub/, Их Британи, Умард Ирландын Нэгдсэн вант улсын Гадаад хамтын нөхөрлөл, хөгжлийн албанд хамтран бэлтгэсэн. хуудас 11, 2020 он.

⁶⁷ Монгол Улсын Улаанбаатар хотын барилга байгууламжийн орчны хүртээмж ба хамруулсан загвар, Дэлхийн хөгжлийн бэрхшээлийн инновацын Сүлжээ /GDI Hub/, Их Британи, Умард Ирландын Нэгдсэн вант улсын Гадаад хамтын нөхөрлөл, хөгжлийн албанд хамтран бэлтгэсэн. хуудас 3, 2020 он.

урьдчилсан нөхцөл болохыг онцолсон байна. Энэхүү Стратегийн энэ зорилтыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд хууль боловсруулах ажил хийж байна хэмээн үзэх боломжтой.

НҮБ-ын Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн Эрхийн хорооны 13-р хуралдаанаас Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн эрхийн тухай Монгол Улсын тайланд өгсөн дүгнэлт, зөвлөмжийн 6-д “Оролцогч улсын хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн талаарх хууль, тогтоомж, бодлого нь хоорондоо нийцэхгүй, холбогдох зүйл заалт нь зохих ёсоор уялдахгүй байна гэж Хороо үзэж байна” гэж заагаад 7-гийн b зөвлөмжид “Бодлого зохицуулалт, харьцуулалт хийж ... хэрэгжүүлэх стратегийг боловсруулах” хэмээн заасан байдаг. Эндээс бодлогын зохицуулалт хийх хэрэгцээтэй байгааг зөвлөж байгааг харж болно. Мөн зөвлөмжийн 17-д хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн нийгмийн оролцоог нэмэгдүүлэхийн тулд Мэдээлэл харилцааны технологиудыг хүртээмжтэй болгох, мөн хүртээмжийг бодитой болгохын тулд албадан хэрэгжүүлэх механизмыг сайжруулахыг зөвлөсөн байдаг. Эндээс үзэхэд мөн л хуульд тодорхой бодлого тусгахыг зөвлөж байна.

7.2.Бусад орнуудын эрх зүйн зохицуулалтын онцлог

Судалгааны ажлын хүрээнд хүртээмжтэй орчин бүрдүүлж буй зарим гадаад улсын эрх зүйн зохицуулалтыг судлахдаа Япон улсын хүртээмжийн тухай хууль, Канадын хүртээмжийн тухай хуулиас зарим онцлог зохицуулалтыг орууллаа.

Япон Улсын Хүртээмжийн тухай хууль

Япон Улс "Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн зорчих хөдөлгөөний саадгүй байдлыг дэмжих тухай хууль" 2000 онд батлагдаж, 2006, 2018, 2020 онуудад нэмэлт өөрчлөлт оруулжээ. Өмнө нь зөвхөн ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн саадгүй зорчих боломжийг нэмэгдүүлэх зорилгоор боловсруулагдан хэрэгжиж байсан бол 2006 оны нэмэлт өөрчлөлтөөр илүү өргөн цар хүрээг хамарч, жирэмсэн эмэгтэйчүүд, түр гэмтсэн хүмүүс зэргээр бүхий л иргэдийн асуудлыг багтааж, тээврийн хэрэгсэл, түүнд хамаарах байгууламжуудыг ашиглахад аюулгүй байдал, тав тухтай байдлыг нэмэгдүүлэх, мөн мэдээллийн хүртээмжийн асуудлыг зохицуулах бичиг баримт болон шинэчилжээ.

Тус хуулийн зорилго нь өндөр настан, ХБХ-ий өдөр тутмын нийгмийн оролцоог нэмэгдүүлэхэд нийтийн тээврийн хэрэгсэл хийгээд зорчигчдын байгууламж, зам, зогсоол, цэцэрлэгт хүрээлэн, барилга байгууламжийн хүртээмж, түүний тоноглолыг сайжруулах арга хэмжээг зохицуулах гэжээ. Энэхүү хууль нь барилга, явган хүний зам, нийтийн тээврийн хэрэгсэл, түүнд хамаарах байгууламжийн асуудлыг илүү нарийвчилсан бол мэдээллийн хүртээмжийг орхигдуулсан болохыг шүүмжилдэг.

Хуулийн хэрэгжилтийг хангах оролцоо, үүрэг хариуцлага

Нийтийн тээврийн хэрэгсэл, түүнд хамаарах барилга байгууламж, зам, авто зогсоол, хотын цэцэрлэгт хүрээлэн байгуулахад хариуцагч албан тушаалтан, менежерүүд тус хуулийг дагаж мөрдөх үүргийг тодорхой зааж өгсөн.

Мөн тус хууль болон холбогдох стандартыг заавал мөрдөх болон хүчин чармайлт гаргах гэж 2 ангилдаг байна. Тухайлбал заавал мөрдөж хэрэгжүүлэх сектор гэдэгт төрийн үйлчилгээний

байгууламж, тусгай сургууль, цэцэрлэг, нийтийн тээврийн хэрэгсэл, түүнд хамаарах үйлчилгээний барилга байгууламж, 2000-аас дээш кв² талбай бүхий худалдаа үйлчилгээний байгууламж зэргийг оруулдаг бол заавал мөрдөхгүй байж болох буюу хүчин чармайлт гаргах гэдэгт жижиг үйлчилгээний газар, худалдаа бизнесийн төвүүд зэргийг багтаасан байна.

Хуулийн онцлог:

Япон улс нь хууль дээдлэх соёл өндөртэй ард түмэн бөгөөд аливаа дүрэм, журам, хууль батлагдсан бол түүний хэрэгжилтийг дор бүрнээ дагаж, мөрдөх ёстой нийгмийн сэтгэлгээ нь Азийн улс орнуудаас ялгарах нэг давуу талтай. "Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн зорчих хөдөлгөөний саадгүй байдлыг дэмжих тухай" хууль 3-н удаагийн нэмэлт өөрчлөлтөөр ХБХЭЖ-ийн үзэл хандлагад нийцүүлэх, түүнийг иргэд ААН-д ойлгуулан таниулах, ХБИ-ийн оролцоог хангах тал дээр бодитой өөрчлөлт оруулж байсан. Тухайлбал 2018 оны хуулийн нэмэлт өөрчлөлтөөр хүртээмжтэй байдлыг заавал хангах албан үүрэгтэй секторт ерөнхий боловсролын ахлах, дунд сургуулийг оруулсан бол 2020 он буюу энэ зуны нэмэлт өөрчлөлтийг Токиогийн зуны олимпыг угтаж, түгээмэл загварын үзэл санааг тусгуулжээ(Toshiko, 2020). Үүнд стадион, үзвэр үйлчилгээ, нийтийн тээвэр, холбоо, харилцааг бүх хүнд хүртээмжтэй байх тухай хуульчилж, дагаж гарах стандартуудыг батлуулсан. Мөн эдгээр нэмэлт өөрчлөлтүүдэд ХБИ-ийн төлөөллийн байгууллагын дуу хоолой, оролцоог хангаж, шийдвэр гаргах түвшинд ажиллах бололцоог хангаж өгсөн(Сатоши, 2020).

"Ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн зорчих хөдөлгөөний саадгүй байдлыг дэмжих тухай хууль" хуулийг дагалдан (Сатоши, 2020) стандарт, хэрэгжилтийг хангуулах үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулсан байна. Тухайлбал хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор 10-н жилийн үйл ажиллагааны төлөвлөгөө буюу судалгааны тооцоолол боловсруулсан байдаг.

Хүснэгт 7 Хүснэгт Японы хуулийн хэрэгжилтийг хангах зорилгоор 10-н жилийн үйл ажиллагааны төлөвлөгөө

	Хүртээмжийг нэмэгдүүлэх объектууд	2010 он	2022 он
Төмөр зам	Төмөр замын буудал өртөөгөөр нэг өдөрт зорчих зорчигчийн тоо 3000 их	77 %	100 %
Автобус	Автобусны буудал нэг өдөр зорчих зорчигчийн тоо 3000 их	88%	100%
Автобус	Шатгүй	26%	70%
	Цахилгаан шаттай		25%
Усан онгоц	Боомт, зогсоол	100%	100%
Такси	Тусгай зориулалтын болон универсал такси	11.165 ш	28000 ш
Хотын цэцэрлэгт хүрээлэн	Авто зогсоол	38%	60%
	Нийтийн ариун цэврийн газар	31%	45%
Гэрэл дохио	Мэдээллийн хүртээмж	92%	100%
Барилга байгууламж	Хүртээмжтэй байгууламж	47%	60%

Канад Улсын хүртээмжийн тухай хууль

Канад Улсад ХБХ-д саадгүй хүртээмжтэй нийгмийн орчинг хэрхэн бүрдүүлж байгаа болон хүртээмжтэй орчинг бүрдүүлэхтэй холбоотой харилцааг хэрхэн зохицуулж байгааг судлан үзэхэд хууль эрх зүйн түвшинд нэн тэргүүнд энэхүү 2019 онд батлагдсан “Хүртээмжтэй Канад⁶⁸” хууль болон түүнтэй холбоотойгоор батлагдан хэрэгжиж буй эрх зүйн хэм хэмжээ тогтоосон бусад актууд нь гол эх сурвалж болох юм. 2019 оны байдлаар Канад Улсын нийт хүн ам нь 37,4 сая бөгөөд үүний 22 хувь нь хөгжлийн бэрхшээлтэй. Канад Улс нь НҮБ-ын Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн конвенцыг нэмэлт протоколын хамт соёрхон баталж, нэгдэн орсон улсын нэг орон.

Хууль боловсруулах үндэслэлийн нэг бол тус улсад 2017 онд хийсэн судалгаагаар, нийт хүн амын 22 орчим хувь буюу ойролцоогоор 6 сая орчим нь 15 буюу түүнээс дээш насны хөгжлийн бэрхшээлтэй хүн байгаа нь тогтоогдсон бөгөөд бодит тоо нь үүнээс ч их байх магадлалтай хэмээн үзсэн байна. Судалгаагаар нийт хөдөлмөрийн насны иргэдийн 80 хувь ажил хөдөлмөр эрхэлж байгаатай харьцуулахад 24-64 насны ХБХ-ийн 59% ажил хөдөлмөр эрхэлж, ердийн хүмүүсээс бага цалин хөлс авж, орлого олдог байна. Тухайлбал хөнгөн хэлбэрийн ХБХ 12 хувиар, хүнд хэлбэрийн ХБХ 51 хувиар бага орлого олж байгаа нь тэднийг ядууралд өртөхөд хүргэж байна гэх судалгаанд үндэслэн эл асуудлыг үүсгэж буй нэг хүчин зүйлийг хүртээмжийн асуудал гэж үзээд нөлөөллийн олон талт ажлуудыг авч хэрэгжүүлсэн байна.

НҮБ-ын ХБХЭТ конвенцоор хүлээсэн үүрэг болон ХБ-тэй иргэдийн байгууллагуудын нөлөөллийн үйл ажиллагааны үр дүнд Канадын Засгийн газар, нийгмийн гишүүн бүрийг ялангуяа ХБ хүнийг нийгмийн харилцаанд бүрэн дүүрэн үр дүнтэй оролцоход саад болж буй бэрхшээлүүдийг арилгах, саадгүй орчныг бүрдүүлэх зорилгоор “Хүртээмжтэй Канад” буюу “Accessible Canada Act (Bill C-81)”⁶⁹ хуулийг боловсруулан 2019 оны 6 сарын 24-нд баталсан. Уг хуулийг боловсруулах явцад өргөн хүрээнд хэлэлцүүлэг уулзалт хийж, 6000 орчим хөгжлийн бэрхшээлтэй хүн болон 100 орчим иргэний нийгмийн байгууллагуудтай зөвшилцөн тэдний саналыг тусгаж боловсруулсан нь ЗГ-аас хүртээмжтэй орчин бүрдүүлэхэд хэрхэн анхаарч байгааг тод харуулсан үйл явц болсон. Энэ хууль нь холбооны нутагт дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй төрийн болон хувийн хэвшлийн бүх байгууллагад адил тэгш үйлчлэх юм.

Хүртээмжийн тухай бие даасан хууль батлагдахаас өмнө тус улсад 1/Канадын эрх, эрх чөлөөний дүрэм (1982) /Үндсэн хуулийн нэг хэсэг хэмээн тооцогддог/. Уг дүрмийн 15 дугаар хэсэгт тодорхой зарим бүлгүүдийг ялгаварлан гадуурхахыг хориглосон байдаг бөгөөд тэдний дунд оюуны болон бие бялдрын хөгжлийн бэрхшээлтэй хүнийг ялгаварлан гадуурхаж үл болно хэмээн тунхагласан. 2/ Канадын хүний эрхийн тухай хууль, энэ хууль нь 11 үндэслэлээр хүнийг ялгаварлан гадуурхахыг хориглосон бөгөөд энэ хуулийн зохицуулалтад холбооны хуулийн үйлчлэлд хамаардаг хувийн хэвшлийн банк, өргөн нэвтрүүлгийн үйл ажиллагаа эрхэлдэг зэрэг компаниудад ХБХ-тэй хүнд хүртээмжтэй хүргэх үүргийг хүлээлгэсэн, тухайлбал нийтэд зориулан гаргаж буй утасны программ хангамжууд ХБХ-д хүртээмжтэй байх шаардлага тавьдаг. 3/ Хөдөлмөр эрхлэлтийн тэгш байдлын тухай хуулиар холбооны зохицуулалттай ажил олгогчдод ХБХ болон бусад зорилтот бүлгийн иргэд ажлын байранд бусадтай адил эрх тэгш, үр дүнтэй оролцохыг нь хязгаарлаж буй аливаа саад бэрхшээлийг урьдчилан илрүүлж арилгахыг үүрэг болгосон. Түүнчлэн эдгээр ажил олгогчдыг ХБ ажилтан ажил үүргээ

⁶⁸ [Accessible Canada Act](#)

⁶⁹(Government of Canada, 2019)

гүйцэтгэхэд нь хэрэгцээт тохиргоог хийж өгөх. Тухайлбал ажлын байранд ашиглагдаж буй технологи нь хүртээмжтэй байлгахыг шаарддаг. 4/Дээр дурдсан хууль тогтоомжуудаас гадна Канад Улсын муж болгон хүний эрхийг баталгаажуулсан болон хүнийг хөгжлийн бэрхшээлийг оролцуулан аливаа хэлбэрээр ялгаварлан гадуурхахыг хориглосон хуультай.

Өмнө дурдсан хуулиудаас гадна Канадын хэд хэдэн мужууд ХБХ-ий эрхийн асуудлыг бусад цөөнхийн бүлгүүдийн эрхийн асуудалтай нэгтгэн зохицуулахаас гадна тэдний эрхийг хангахад болон баталгаажуулахад чиглэсэн бие даасан хууль тогтоомжуудыг баталсан байна. Тухайлбал, Хөгжлийн бэрхшээлтэй Онтариачуудын хүртээмжийн тухай хууль (The Accessibility for Ontarians with Disabilities Act) нь 2005 онд батлагдсан бөгөөд ХБХ-д хүртээмжтэй орчин бүрдүүлэх харилцааг зохицуулсан Канад дахь хамгийн анхны бие даасан хууль юм. Уг хуулиар төр болон хувийн хэвшлийн байгууллагуудад нийтэд үйлчилгээ үзүүлэхдээ тогтоосон хүртээмжтэй байдлын стандартуудыг дагаж мөрдөхийг үүрэг болгосон байдаг. Тэдгээр стандартууд нь мэдээлэл харилцаа холбоо; хэрэглэгчийн үйлчилгээ; нийтийн тээвэр; хөдөлмөр эрхлэлт болон нийтийн зориулалтын барилга байгууламж гэсэн 5 хэсгээс бүрдэнэ. Тухайлбал, Мэдээлэл харилцаа холбооны стандартын “Хүртээмжтэй цахим хуудас болон хүртээмжтэй цахим хуудасны агуулга” гэсэн 14-р хэсэгт ХБХ-д онлайнаар мэдээлэл авхад саад бэрхшээл учрахгүй байхыг баталгаажуулах зорилгоор цахим хуудас нь олон улсын WCAG2.0-ын техникийн шаардлагыг дагаж мөрдөхийг тусгасан байна. Мөн Манитобагийн Хүртээмжийн тухай хууль, (The Accessibility for Manitobans Act) нь 2013 онд батлагдсан бөгөөд Онтариогийн хүртээмжийн тухай хуультай адил төрийн болон хувийн хэвшлийн байгууллага нь заавал дагаж мөрдөх хүртээмжийн тухай 5 стандартын хэрэгжилтийг хангахад анхаарсан. Ийнхүү Канадын хүртээмжийн тухай хууль батлагдахаас өмнө мужуудын түвшинд бие даасан хүртээмжийн хууль баталсан нь нэгдсэн хууль батлах суурь болсон байх магадлалтай байна. Канад Улс нь 10 мужтай. Эдгээрээс зарим муж Хүртээмжийн тухай хуультай зарим нь хууль байхгүй байсан боловч 2019 онд Хүртээмжтэй Канад хууль батлагдсанаар Холбооны түвшин буюу Канад Улсын нийт нутаг дэвсгэрт нэг мөр хэрэгжих хүн бүрт ялангуяа ХБХ-д саадгүй хүртээмжтэй орчин бүрдүүлэх харилцааг зохицуулсан дээр дурдсанчлан ХБХ-ий асуудалд хандах шинэ хандлагыг бий болгосон хуультай болж чадсан байна.

Хуулийн бүтэц

“Хүртээмжтэй Канад” хуулийг бүх хүмүүсийн, ялангуяа хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн нийгэм дэх бүрэн, тэгш оролцоог нэмэгдүүлэх зорилгоор бий болгосон бөгөөд уг хууль нь 12 хэсэг 206 зүйлтэй.

Хуулийн зорилгыг парламентийн хууль тогтоох эрх мэдэлд хамаарах асуудлыг хэрэгжүүлэх хүрээнд дор дурдсан орчинд буй саад бэрхшээлийг илрүүлэн арилгах болон шинэ саад бий болохоос урьдчилан сэргийлэх замаар 2040 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс өмнө бүх хүнд ялангуяа хөгжлийн бэрхшээлтэй хүнд саадгүй Канад улсыг бий болгоход оршино

- (А) хөдөлмөр эрхлэлт
- (D) барилга байгууламжийн орчин
- (B) мэдээлэл, харилцаа холбооны технологи
- (Г) мэдээлэл, харилцаа холбооны технологиос бусад харилцаа холбоо
- (Д) Бараа, үйлчилгээ болон барилга байгууламж худалдан авах
- (E) хөтөлбөр үйлчилгээг боловсруулах, хүргэх
- (Ё) Нийтийн тээвэр

(3) Энэхүү хуулийн 117-р зүйлийн 1-дэх хэсэгт заасан зохицуулалтын хүрээнд бий болсон орчин хэмээн тодорхойлсон байна. Мөн хуульд хэрэглэсэн нэр томъёог тодорхойлох хэсэгт саад гэсэн ойлголтыг тайлбарласан байх ба “Саад” гэж ХБХ үүнд бие эрхтний, оюун ухааны, танин мэдэхүйн, сурахуйн эсвэл мэдрэхүйн бэрхшээлтэй хүнийг нийгмийн харилцаанд бүрэн дүүрэн, тэгш оролцоход нь саад учруулж буй аливаа зүйлийг үүнд биет байдлын, технологийн болон хандлагын, мөн мэдээлэл харилцаа холбоо эсвэл бодлого, үйл ажиллагааны үр дүнд үндэслэсэн аливаа зүйлийг; ойлгоно хэмээн тодорхойлсон.

Хуулийн бүтцийг харвал, 1 дүгээр хэсэгт хүртээмжийн асуудал хариуцсан сайдын хүртээмжийг сайжруулах талаар аливаа бодлого, хөтөлбөр, төсөл санаачлах, хэрэгжүүлэх, хүртээмжтэй холбоотой бүх төрлийн мэдээ статистикийг цуглуулах, дүн шинжилгээ хийх бодлогод ашиглах болон нийтэд хүргэх зэрэг бүрэн эрх болон чиг үүргийг, 2 дугаар хэсэгт Канадын хүртээмжтэй холбоотой стандартуудыг боловсруулах байгууллагын бүтэц, бүрэн эрх, чиг үүргийг, 3 дугаар хэсэгт хүртээмжийн асуудал эрхэлсэн комиссарын хүртээмжийн сайдыг хуулийн хэрэгжилтийг зохион байгуулж хэрэгжүүлэхтэй холбоотой мэдээлэл, зөвлөгөө болон тайлангаар хангах эрх, үүргийн талаар, 4 дүгээр хэсэгт аж ахуйн нэгж байгууллагуудын хүртээмжтэй орчин бүрдүүлэхтэй холбоотой эрх, үүргийг, 5 дугаар хэсэгт хүртээмжийн асуудал хариуцсан комиссарын хянан шалгах болон бусад бүрэн эрхийг, 6 дугаар хэсэгт хуулийг хэрэгжүүлээгүйн улмаас эрх нь зөрчигдөж бие махбодь, сэтгэл зүйн, эд хөрөнгө болон бусад эдийн засгийн хохирол учирсан этгээд гомдол гаргах болон учирсан хохирлыг нөхөн төлүүлэх асуудлыг, 7-р хэсэгт сайдад зөвлөх чиг үүрэг бүхий хүртээмжтэй байдлын асуудал эрхэлсэн захирлыг томилох болон захирлын эрх, үүргийг, 8 дугаар хэсэгт зөвлөлд хүртээмжийн асуудлаар стандарт бий болгох, хүртээмжийн талаар авч хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө болон тайлангийн загварыг тодорхойлох зэрэг эрх олгосон заалтуудыг тусгасныг онцолж болох байна. Түүнчлэн Канад Улс 5 дугаар сарын сүүлийн ням гарагаас эхлэн 7 хоногийг “Үндэсний хүртээмжийн долоо хоног” болгон тэмдэглэж байхаар хуульчилсан байна.

НАЙМ. ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ

Саадгүй байдал, хүртээмжийн тухай анхдагч хуулийн төслийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тодорхойлох тандан судалгааны хүрээнд хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлалын дагуу гүйцэтгэж үр дүнг дараах байдлаар дүгнэв.

Дэлхий нийтээр хүний жам ёсны болон хууль ёсны эрх, эрх чөлөөг бүрэн эдлүүлэх, хүн нас, хүйс, эдийн засгийн нөхцөл, бүр болон түр хугацааны хөгжлийн бэрхшээлтэй эсэхээс үл хамаарч бусдын нэгэн адил эрх тэгш байх боломжийг бүрдүүлэх зорилгоор олон улсын хүний эрхийн гэрээ, конвенцод нэгдэн орсон орнууддаа зорилтот бүлгийн, ялангуяа ХБХ-ий эрхийг хангахад онцгойлон анхаарч төрийн үйлчилгээ болон нийтэд үйлчилгээ үзүүлж буй барилга байгууламж, дэд бүтэц, техник тоног төхөөрөмж, харилцаа холбоо, мэдээллийн хэрэгсэл, технологийн дэвшилтэт бүтээгдэхүүн, үйлчилгээг олон улсын хэм хэмжээнд нийцүүлэн саадгүй, хүртээмжтэй байлгах, бодитоор хэрэгжүүлэх тал дээр хүчин чармайлт гаргаж, үндэсний хөгжлийн бодлого, стратегидаа тусгахыг уриалж, тодорхой шаардлага тавьж байна.

Монгол Улсын тухайд НҮБ-аас баталсан Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн конвенц, Хүний эрхийн түгээмэл тунхаглал, Улс төр, нийгэм, соёлын эрхийн факт, “Тогтвортой хөгжлийн зорилго 2016-2030” зэрэг 10 гаруй гэрээ, конвенц, тэдгээрийн нэмэлт протокол зэрэг бодлогын баримт бичигт нэгдэн орсон улсын хувьд эдгээр хүний эрхийн олон улсын баримт бичиг тусгасан эрхүүдийг өөрийн нийгэм, эдийн засгийн хэмжээнд тохируулан хууль, бодлогын түвшинд хангахаар стандарт тогтоох, олон нийтэд мэдээлэх, хяналт тавих эрх зүйн орчныг бүрдүүлэх, хэрэгжилтийг хангуулах үүрэгтэй. Энэ үүргээ хэрэгжүүлэх чиглэлээр хууль тогтоомжоо боловсронгуй болгож 100 орчим хуульд саадгүй, хүртээмжтэй байдлыг хангах зохицуулалт тусгаж, эдгээрт холбогдох 20 гаруй стандарт, дүрэм, журмыг боловсруулсан ч хэрэгжилт хангалтгүй байгаа нь салбар хоорондын үйл ажиллагааны болон эрх зүйн орчны уялдаагүй байдал, хяналт, хариуцлагын тогтолцоо хангалтгүй байгаагаар холбоотой байна. Үүний илрэл бол ХБХ-д саадгүй, хүртээмжтэй байх асуудлыг “Алсын хараа-2050”, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр зэрэг Монгол Улсын урт, дунд хугацааны бодлогын баримт бичгүүдэд тусгадаг, гэхдээ үндсэндээ Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуульд уг асуудлыг харьцангуй тодорхой заасан байгаа бол бусад хууль тогтоомжид ерөнхий байдлаар 2-4 заалтын хүрээнд тунхаглалын шинжтэй тусгажээ.

ХБХ-д саадгүй, хүртээмжтэй байдлыг хангах хууль эрх зүйн орчныг үнэлж үзэхэд ХБХ бусдын адил бие даан амьдрах, нийгмийн бүхий л салбарт эрх тэгш оролцох боломжтой байх, мөн барилга байгууламж, тээвэр, мэдээлэл харилцаа холбоо, үйлчилгээ саадгүй, хүртээмжтэй байх асуудалд холбогдох зохицуулалтууд хэт ерөнхий, тодруулбал, санхүүжилтийн эх үүсвэр, хариуцан хэрэгжүүлэх этгээдийг тодорхой тусгаагүй, саадгүй байдал, хүртээмжийг олон нийтэд ойлгуулах, мэдлэг, мэдээлэл түгээх, хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлагын асуудлыг орхигдуулсан, зөвлөмж, стандартууд нь заавал мөрдөх шинжгүй буюу сонгож хэрэглэх боломжтой, мөн бусад хууль тогтоомжтой хэрхэн уялдаж, харилцан хамааралтай ажилладаг нь ойлгомжгүй, нэг салбарын мэргэжилтэн нөгөө салбарын хууль тогтоомжийн талаар мэдлэг сул, өөрийн ажиллаж буй салбарынхаа хууль тогтоомжийн талаар бүрэн мэдээлэлгүй, хяналт хэрэгжүүлэх механизм тодорхойгүй байх, олон байгууллага өөрийн эрх хэмжээнд хяналт хэрэгжүүлдгээс үүдэн хариуцлагын хэмжээ бага, түүнээс зайлсхийх арга хэлбэр олон гээд саадгүй, хүртээмжтэй орчныг бий болгоход чигдэсэн хуулийг хэрэгжүүлэхэд

саад болдог шалтгаан олон байгаа нь асуудалд цогцоор нь хандаж чадахгүй, хэрэгжихгүй, үр дүнгүй байхад нөлөөлж байна.

ХБХ-нд ээлгүй, хүртээмжгүй хот төлөвлөлт, барилга байгууламж, дэд бүтцээс гадна мэдээлэл, үйлчилгээ, техник, технологи, хүний нөөцийн хүртээмжгүй байдал ХБХ-ийг нийгмийн харилцаанд аливаа саадгүйгээр оролцох боломжийг хязгаарлаж, ялгаварлан гадуурхалтыг нэмэгдүүлэх суурь шалтгаануудын нэг болж байна. Иймээс цаашид ХБХ төдийгүй бусад хүний нийгмийн харилцаанд оролцох боломжийг хязгаарлаж хөгжлийн бэрхшээлтэй болгож буй орчны саад, хүртээмжгүй байдлыг өөрчлөхийн тулд бүх хүнд ээлтэй бүтээн байгуулалт хийх, үйл ажиллагаа явуулах ухамсрыг төлөвшүүлэхүйц эрх зүйн орчныг бүрдүүлэх шаардлагатай юм. Үүний тулд юуны өмнө ХБХ нийгмийн харилцаанд эрх тэгш оролцох эрхийг ноцтойгоор зөрчихөд хүргэж буй орчны саад, хүртээмжгүй байдлыг үүсгэж буй хот төлөвлөлт, газар олголт, архитектурын шийдэл, барилгын зөвшөөрөл зэрэг барилга байгууламж, дэд бүтцэд тавигдах шаардлага, түүнд тавих хяналт, хариуцлагыг шинэчлэн тогтоох, сайжруулах шаардлага тулгамдаж байна. Тухайлбал, өнөөдөр хот байгуулалт, барилгын тухай хууль тогтоомжийг зөрсөн этгээдэд оногдуулж буй 100 мянгаас 10 сая төгрөг хүртэлх төгрөгийн торгуулийн арга хэмжээ хэдэн зуун сая, тэрбумын хөрөнгө оруулагчийн хувьд үр дүнгүй, хууль биелүүлэх сэдэл, хөшүүрэг болохгүй байна.

Тандан судалгаагаар хүн амын нягтаршил, эдийн засаг, хөрөнгө оруулалтын төв болсон Улаанбаатар хотод үүссэн дэд бүтэц, төрийн үйлчилгээ, олон нийтийн үзвэр үйлчилгээний хүртээмжийн нөхцөл байдал орон нутагт, бусад төв суурин газарт ч мөн адил үүссэн, цаашид улам даамжрах эрсдэлтэй байгаа тул барилга байгууламж, дэд бүтцийн саадгүй байдал, хүртээмжийг нэмэгдүүлэхэд төр үүрэг, оролцоо, идэвхээгээ нэмэгдүүлэх нь чухал болох нь харагдаж байна. Өөрөөр хэлбэл, төр өөрөө Үндсэн хуулиар иргэдийнхээ өмнө хүлээсэн үүргийнхээ хүрээнд төрийн байгууллагуудын барилга байгууламжийн саадгүй байдал, хүртээмжийг сайжруулах, хуулийн шаардлага хангах, мөн улс, орон нутгийн төсвийг үргүй зарцуулахаас сэргийлж төсвийн хөрөнгөөр хэрэгжих төсөл, хөтөлбөр, арга хэмжээ саадгүй, хүртээмжтэй байх анхдагч шалгуурыг тавьж хэрэгжилтийг хангуулах нь цаашид эл асуудлыг шийдвэрлэх алхам болох юм. Ялангуяа сүүлийн жилүүдэд нийслэл, орон нутгийн зам, талбайн өргөтгөл, шинэчлэлийн ажилд ихээхэн хөрөнгө мөнгө зарцуулж байгаа боловч эдгээр төсөл, хөтөлбөрүүд нь ХБХ-ий эрхийг хангаагүй саадгүй байдал, хүртээмжийн наад захын шаардлага хангаагүй, чанаргүй гүйцэтгэлтэй байгаа, мөн шаардлага хангаагүй барилга, байгууламж, дэд бүтэц, зам талбай бий болгоход оруулсан хөрөнгө оруулалтын хэмжээ тэдгээрийг саадгүй, хүртээмжтэй болгоход чиглэсэн засвар, үйлчилгээнд зарцуулах хөрөнгө оруулалтын хэмжээгээр өсөж улсын төсөвт дарамт болж байгаагаас харж болно.

ХБХ-нд хүртээмжтэй үйлчилгээ үзүүлэхэд иргэдийн дунд хөгжлийн бэрхшээлийн хандлага төлөвшөөгүй, шаардлагатай хүний нөөц дутагдалтай, санхүүжилт хангалтгүй, шаардлагатай журам, аргачлал зэрэг хуулийн хэрэгжилтийг бүрэн хангуулахад чиглэсэн эрх зүйн актуудыг боловсруулах батлуулах ажил удаашралтай байдаг зэрэг хэд хэдэн шалтгаан нөлөөлж байна. Тухайлбал, нийслэлийн нийтийн тээврийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх ажил 10 жил үргэлжилж байгаа боловч 10 хувь нь л ХБХнд хүртээмжтэй, автобусны зогсоол, нийтийн үйлчилгээний байгууллагуудын зогсоол хүртээмжгүй, явган хүний гарцны дуут дохио хангалтгүй, ногоон байгууламжийн төлөвлөлт, арчилгаа, нийтийн эзэмшлийн талбайг зориулалтын бусаар ашиглах, зам талбайг дур мэдэн хаах, саад байршуулах асуудлаа шийдвэрлэж чадахгүй байхаас гадна такси, төмөр замын, хот хоорондын үйлчилгээ, агаарын

тээврийн үйлчилгээ зэрэг уламжлалт тээврийн хэрэгслээс гадна шинэ тутам нэвтрүүлэхээр зорьж буй дүүжин тээвэр, трамвай зэргийг ХБХ-д хүртээмжтэй болгох тухай зохицуулалт байхгүй байна.

Хүртээмжийн асуудал үндсэндээ уламжлалт буюу эрүүл мэнд, боловсрол зэрэг төрийн үйлчилгээ, харилцаа холбоо, мэдээллийн технологийн үйлчилгээ, болон шинэ тутам зохицуулалт шаардагдах програм хангамж, компьютер, гар утас, цахим ном уншигч төхөөрөмж, банкны автомат, карт уншигч төхөөрөмж, вэбсайт зэрэг бүтээгдэхүүний хүртээмж гэж ангилагдахаар байна. ХБХ-д нэн шаардлагатай үйлчилгээ нь ихэвчлэн төрөөс үзүүлэх үйлчилгээ байдаг тул саадгүй байдал, хүртээмжийг нэмэгдүүлэхэд төр өөрөө манлайлах, мөн төрийн зарим чин үүргийг хэрэгжүүлэх, төрөөс дэмжлэг, татаас авах байгууллагуудад тавигдах шаардлагад саадгүй байдал, хүртээмжийн шалгуур тогтоох нь хуулийн хэрэгжилтийг хангах хөшүүрэг болох магадлалтай юм.

Хүртээмжтэй байдал бол ХБХ-ий оролцоог нэмэгдүүлэх “сонголт биш эрх” бөгөөд оролцоо, тэгш эрхийг хангаснаар ХБХ-ий нэр төр, нийгэмд эзлэх байр суурийг бэхжүүлэх, шийдвэр гаргах эрх чөлөөг бататгах асуудал болохын хувьд хүний ялгаатай байдлаас үл хамаарч төрийн болон хувийн хэвшлийн аж ахуйн нэгж байгууллагаас үзүүлж буй аливаа үйлчилгээ хүн бүрт хүртээмжтэй байх нь хүний эрхийг хангах суурь үзүүлэлт гэж үзэн НҮБ, Европын холбоо зэрэг олон улсад хэм хэмжээ тогтоогчид жишиг эрх зүйн зохицуулалтыг бий болгосон бол Япон, Канад зэрэг орнууд олон салангид хуульд агуулагдаж буй саадгүй байдал, хүртээмжийн зохицуулалтуудыг нэгтгэн бие даасан хүртээмжийн хууль батлах замаар гишүүн орнууд, мужуудын хэмжээнд хүний эрхийг хангах нөхцөлийг бүрдүүлж буй сайн туршлага байна.

Дээрхтэй холбоотой судалгааг тайлангийн өмнөх хэсгүүдэд тусгасан ба аргачлалын дагуу эрх ашиг нь хөндөгдөх этгээдүүдийг тодорхойлсон. Мөн тус хэрэгцээ, шаардлагад үндэслэн хувилбар буюу зохицуулах аргуудад дүгнэлт хийн тэдгээрээс хоёр хувилбарыг сонгож хооронд нь харьцуулсан болно. Тэг хувилбарыг “Саадгүй байдал, хүртээмжтэй үйлчилгээ үзүүлэх талаар одоогийн зохицуулалтын хувилбарыг хэвээр үлдээх буюу шинэ зохицуулалт хийхээс татгалзах замаар асуудлыг шийдвэрлэх” гэж, хувилбар 1-ээр “Саадгүй байдал, хүртээмжтэй үйлчилгээ үзүүлэх эрх зүйн орчныг шинэчлэх буюу боловсронгуй болгох замаар асуудлыг шийдвэрлэх” гэж тус тус тодорхойлсон. Улмаар тус хоёр хувилбаруудыг зорилгод хүрэх байдал, хүний эрх, эдийн засаг, нийгэм, байгаль орчинд үзүүлэх үр нөлөө, зардал, үр өгөөжийн харьцаа, хууль тогтоомжтой нийцэж байгаа эсэх гэсэн шалгуур үзүүлэлтээр эерэг үр дүн болон сөрөг үр дагаврыг нэг бүрчлэн, нарийвчлан тодорхойлсны үр дүнд зорилгод хүрэх байдал, шалгуур үзүүлэлт, хүний эрх, эдийн засаг, нийгэмд үзүүлэх үр нөлөө зардал, үр өгөөжийн харьцаа шалгуур үзүүлэлт, хууль тогтоомжтой нийцэж байгаа эсэх шалгуур үзүүлэлт, хүний эрхэд үзүүлэх үр нөлөө гэх шалгуур үзүүлэлтийн хувьд зохицуулалтын хувилбар 1 нь хувилбар 0-ээс эерэг үр дүнг үзүүлж байна. Мөн зохицуулалтын хувилбар 1-ий сонгосноор Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хууль, Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээнд нийцсэн, хэрэгжилтийг хангахад эерэг нөлөөтэй байна. Дүгнэвэл, хувилбар 1 буюу “Саадгүй байдал, хүртээмжтэй үйлчилгээ үзүүлэх эрх зүйн орчныг шинэчлэх буюу боловсронгуй болгох замаар асуудлыг шийдвэрлэх” нь хэрэгцээ, шаардлагад илүү нийцтэй, хүний эрхийг хангах чиглэлээр төрийн үүрэг, оролцоо хариуцлагыг бэхжүүлэх асуудлыг шийдвэрлэх арга зам болж чадахаар байна.

Судалгааны дүнгээс харахад саадгүй байдал, хүртээмжтэй үйлчилгээнд холбогдох эрх зүйн орчинг боловсронгуй болгохдоо Монгол Улсад өнөөдрийг хүртэл бат бөх оршсон “хүний

эрхээс илүү эд хөрөнгө, нийтийн эрх ашгаас илүү хувийн ашиг сонирхол” гэх хандлагыг өөрчилж хүн бүр нийгмийн харилцаанд эрх тэгш оролцох, сурч боловсрох, хөдөлмөрлөх, эрүүл мэндээ хамгаалуулах, эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхээ эдлэх, ХБХ нийгэм, эдийн засгийн хувьд бусдаас хараат бусаар бие даан амьдрах боломжийг бүрдүүлэх тогтолцоог бэхжүүлэх буюу эрх зүйн зохицуулалт хоорондын уялдаа холбоог сайжруулах, төр өөрөө үлгэрлэж хууль тогтоомжийн хэрэгжилтийг сайжруулах, төрийн бодлого, стратеги хүн төвтэй, хүний эрхэд суурилсан байх зарчмыг илүү үр дүнтэйгээр тодорхойлж хэрэгжүүлэх байдлаар шийдвэрлэх нь зүйтэй юм.

Иймээс Монгол Улсад хүн бүр, эн тэргүүнд ХБХ бусдын нэгэн адил саадгүй, хүртээмжтэй үйлчилгээ авах эрхийг баталгаажуулах зорилгоор тухайлсан хууль боловсруулах шаардлагатай эсэхийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.1 дэх заалт, 13 дугаар зүйлд заасны дагуу Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан “Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлал”-ын дагуу гүйцэтгэсэн судалгааны дүнд үндэслэн ХБХ саадгүй, хүртээмжтэй орчин, нөхцөлөөр хангагдах эрхийг баталгаажуулж буй 100 гаруй эрх зүйн актад тусгасан зохицуулалтыг нэгдсэн бүтэц, нэгдмэл тогтолцоонд оруулах замаар саадгүй байдал, хүртээмжийн асуудлыг цогцоор нь шийдэж эрх, үүрэг, хяналт, хариуцлага, харилцан хамаарлыг тодорхойлох, шинэ тутам үүсэж буй саад бэрхшээлийг ХБХ-нд ээлтэй байдлаар шийдвэрлэх шийдэл гаргах зэрэг асуудлыг тусгасан тухайлсан хууль боловсруулахыг зөвлөж байна.

ЭХ СУРВАЛЖИЙН ЖАГСААЛТ

Хууль тогтоомж

1. Монгол Улсын Үндсэн хууль
2. Автотээврийн тухай хууль
3. Барилгын тухай хууль
4. Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль
5. Монгол Улсын хууль тогтоомжийг 2028 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл.
6. Номын сангийн тухай хууль
7. Олон нийтийн радио, телевизийн тухай хууль.
8. Өргөн нэвтрүүлгийн тухай хууль
9. Сонгуулийн тухай хууль
10. Статистикийн мэдээллийн нэгдсэн сан
11. Харилцаа холбооны тухай хууль
12. Харилцаа холбооны тухай хууль
13. Хот байгуулалтын тухай хууль
14. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хууль.
15. Convention on the Rights of Persons with Disabilities (CRPD).
16. [Accessible Canada Act](#)
17. [Directive - 2019/882 - EN - EUR-Lex](#)

Тайлан, бодлогын баримт бичиг

1. High-level Meeting on Disability and Development. Monday, September 23, 2013.
2. [UB Case Study Publication Package Mongolian version.pdf](#)
3. Монгол Улсын боловсролын суурь мэдээллийн тайлан
4. Монгол Улсын Улаанбаатар хотын барилга байгууламжийн орчны хүртээмж ба хамруулсан загвар, Дэлхийн хөгжлийн бэрхшээлийн инновацын Сүлжээ /GDI Hub/, Их Британи, Умард Ирландын Нэгдсэн вант улсын Гадаад хамтын нөхөрлөл, хөгжлийн албанд хамтран бэлтгэсэн. хуудас 11, 2020 он.
5. [Тогтвортой хөгжлийн зорилго](#)
6. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээний тайлан. 2018 он. Д.Сүнжид.
7. Хөгжлийн бэрхшээлтэй хүний эрхийн тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээний тайлан. 2024 он. Ж.Бариаширсүрэн
8. Эрүүл мэндийн салбар дахь хүний эрхийн хэрэгжилтэд хийсэн үнэлгээний тайлан. 2018 он. ХЭҮК
9. Эрх зүйн мэдээллийн нэгдсэн сан

Стандар, норм, дүрэм

1. Авто замын байгууламж: Явган хүн, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан зам, Техникийн шаардлага” MNS 5682:2006,
2. Авто замын байгууламж: Явган хүн, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан замыг төлөвлөх заавар” MNS 6056:2009

3. Байгалийн ба зохиомол гэрэлтүүлэг /БНБД 23-02-08/;
4. Барилга дотор ба гадна орчны зохион байгуулалтын талаар MNS 6055:2009
5. Барилгын налуу замын стандарт, Тэмдэглэгээ харааны бэрхшээлтэй иргэнд нийцэх шаардлагын талаарх MNS 6302:2011
6. Захиргааны зориулалттай олон нийтийн барилга /БНБД 31-04-12/,
7. Иргэний барилгын төлөвлөлтөд хөгжлийн бэрхшээлтэй хүний шаардлагыг тооцсон орон зай, орчин. Үндсэн шаардлага MNS 6055:2009 стандарт
8. Иргэний барилгын төлөвлөлтөд хөгжлийн бэрхшээлтэй иргэний шаардлагыг тооцсон орон зай, орчин MNS 6055:2009
9. Иргэний барилгын төлөвлөлтөнд хөгжлийн бэрхшээлтэй хүний шаардлагыг тооцсон орон зай, орчин, үндсэн шаардлага MNS 5682-2006,
10. Мэдээллийн тэмдэг, дохио, Саадгүй орчны шаардлага, мэдээлэл, тав тухын талаарх MNS 6389:2013
11. Нийтийн тээврийн зогсоол, ангилал, техникийн шаардлага MNS 5879-2012,
12. Нийтийн тээврийн зогсоолын төлөвлөлт, БД 32-101-17,
13. Нийтийн тээврийн хэрэгсэл зэрэг стандартууд
14. Олон айлын орон сууцны барилгын архитектур төлөвлөлт /БД 31-118-15/;
15. Олон нийт, иргэний барилга (нэмэлт) /БНБД 31-03-03*/11/,
16. Олон нийт, иргэний барилга /БНБД 31-03-03/,
17. Орон сууцны барилгын зураг төсөл төлөвлөх норм ба дүрэм /БНБД 31-01-10/;
18. Өндөр барилгын төлөвлөлт /БНБД 30-17-10/;
19. Тахир дутуу иргэдэд зориулсан барилгын төлөвлөлтийн нормаль /БД 31-101-04/,
20. Үйлдвэрлэлийн барилга /БНБД 31-11-09/;
21. Хот тосгоны төлөвлөлт барилгажилтын норм ба дүрэм /БНБД 30-01-04/,
22. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн амьдрах орчны шаардлагад нийцсэн зураг төсөл зохиох дүрэм /БД 31-112-11/,
23. Хөдөлгөөнд саадгүй орчин, тэргэнцэртэй хүний зорчих налуу замын шаардлага MNS 6228:2010
24. Явган хүн, хөгжлийн бэрхшээлтэй иргэдэд зориулсан замыг төлөвлөх заавар MNS 6056-2009
25. ISO 21542:2021 — Building construction — Accessibility and usability of the built environment

ooOoo